



нэгдсэн хуралдааны тэмдэглэл
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 01-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	4-40
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	41-146
<hr/>	
<i>1.Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/</i>	45-48
<i>2.Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/</i>	48-49
<i>3.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/</i>	49-49
<i>4.Нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/</i>	49-50
<i>5. Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	50-73
<i>6.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг//</i>	73-98

7. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Байнгын хороо боловсруулсан/ 98-102
8. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 102-107
9. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/ 107-108
10. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан нарын 3 гишүүн 2021.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 109-113
11. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 113-117
12. Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 117-130
13. “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Байнгын хороо боловсруулсан/ 130-133
14. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 133-138

хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулж, 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

15.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 3 гишүүн 2022.11.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

138-146

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 01-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 34 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилоттой: А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, П.Анужин, Б.Баттөмөр, Э.Батишугар, Д.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Г.Дамдинням, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Н.Наранбаатар, Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Б.Саранчимэг, Ц.Туваан, Ч.Ундрал, Н.Учрал, Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар, Н.Энхболд;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Н.Ганибал, Ж.Чинбүрэн;

Тасалсан: С.Батболд;

Хоцорсон: С.Амарсайхан-39 минут, Д.Батлут-22 минут, Ж.Бат-Эрдэнэ-1 цаг 01 минут, Д.Ганбат-1 цаг 05 минут, Д.Өнөрболор-1 цаг 11 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Т.Аюурсайхан нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Т.Аюурсайхан нар үг хэлэв.

Нэг.Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, шинжээч Б.Гоёсайхан, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхбат, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Буяннэмэх, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, мөн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Н.Бямбадорж, Ашигт малтмал, газрын тосны газрын Хуулийн хэлтсийн дарга Р.Энхтайван, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуяг, ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр, Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга С.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Б.Төгсцэнгэл, Байнгын

хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Г.Хоролмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх тухай асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./10:47/

Хуралдаан даргалагчаас Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр хууль, эрх зүйн лавлагаа гаргах чиглэл өгөв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 7

Бүгд: 44

84.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, шинжээч Б.Гоёсайхан, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхбат, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Буяннэмэх, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, мөн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Н.Бямбадорж, Ашигт малтмал, газрын тосны газрын Хуулийн хэлтсийн дарга Р.Энхтайван, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуяг, ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр, Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн нар

оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга С.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Г.Хоролмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./10:58/

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 7

Бүгд: 44

84.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, шинжээч Б.Гоёсайхан, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхбат, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Буяннэмэх, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, мөн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Н.Бямбадорж, Ашигт малтмал, газрын тосны газрын Хуулийн хэлтсийн дарга Р.Энхтайван, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуяг, ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, Газар зохион

байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр, Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга С.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Г.Хоролмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 7

Бүгд: 44

84.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Нийгмийн зайлигүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, шинжээч Б.Гоёсайхан, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхбат, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Буяннэмэх, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, мөн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Н.Бямбадорж, Ашигт малтмал, газрын тосны газрын Хуулийн хэлтсийн дарга Р.Энхтайван, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуяг, ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр, Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга С.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Г.Хоролмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 7

Бүгд: 44

84.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, шинжээч Б.Гоёсайхан, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхбат, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Буяннэмэх, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, мөн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Н.Бямбадорж, Ашигт малтмал, газрын тосны газрын Хуулийн хэлтсийн дарга Р.Энхтайван, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуяг, ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр, Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга С.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх

Ш.Ариунжаргал, референт Г.Хоролмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, С.Ганбаатар, Б.Жаргалмаа, Ц.Цэрэнпунцаг, Ц.Мөнхцэцэг, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Барилга хот, байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Д.Сарангэрэл нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	31
Татгалзсан:	17
Бүгд:	48

64.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, мөн газрын Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга С.Мөнхнасан, Монголын иргэний агаарын тээвэр хувьцаат компанийн захирал Н.Цэгц, “Эрчис ойл” төрийн өмчит хувьцаат компанийн захирал З.Ширзана, менежер Х.Эрдэнэбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга С.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны

асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, М.Оюунчимэг, Х.Булгантуяа, О.Цогтгэрэл, Ж.Батсуурь, Б.Бейсен, Т.Аубакир, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, мөн газрын Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай, “Эрчис ойл” төрийн өмчит хувьцаат компанийн захирал З.Ширзана нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 50 минут үргэлжилж, 13 цаг 24 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 11 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 14 цаг 11 минутаас 14 цаг 27 минут хүртэл хуралдааныг даргалав.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 1 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./14:47/

Уг асуудлыг 14 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Долоо. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Байнгын хороо боловсруулсан/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 17

Бүгд: 48
64.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:03/

Уг асуудлыг 15 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимэдсүрэн, мөн газрын хуулийн мэргэжилтэн Б.Мөнхтогтох, Ү.Алтаншагай, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн О.Мөнхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 18.2.1 дэх заалтын “энэ хуулийн 19.4, 19.6-д нийцүүлэн гүйцэтгэсэн” гэснийг “боловсруулсан” гэж өөрчилж, 18.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.2.7.Төслийн үйл ажиллагаанд шаардлагатай Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдох тусгай болон энгийн зөвшөөрлийг тодорхойлсон байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 25.2.6 дахь заалтын “үнэлэх” гэснийг “үнэлэх, шаардлага хангаагүй бол энэ хуулийн 25.2.7-д заасан хугацааны дотор оролцогчид мэдэгдэх;” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 27.1.6 дахь заалтын “хамтарч оролцохгүй байх” гэснийг хасаж, 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.1.7 дахь заалт нэмэх:

“27.1.7.сонгон шалгаруулалтад оролцогчид нь Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасны дагуу харилцан хамааралгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 29.1 дэх хэсгийн “зээлдэгчийн” гэснийг “санхүүжүүлэгчийн” гэж, 29.2 дахь хэсгийн “Монгол Улсын хууль болон түншлэлийн гэрээнд заасан эрх, үүргийн дагуу оролцоно” гэснийг “холбогдох хууль, түншлэлийн үндсэн болон дагалдах гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 20
Бүгд: 44
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 39.3 дахь хэсгийн “байгууллагаас” гэсний дараа “зөвшөөрөл” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 20
Бүгд: 44
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 50.1.3 дахь заалтын “төслийн баримт бичгийн үнэ” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 21
Бүгд: 44
52.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд зааснаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл санаачлах,” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн саналыг хэлэлцэх,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээнд заасныг үндэслэн” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлээр” гэж өөрчилж, мөн зүйлийн “холбогдсон харилцааг” гэсний дараа “Газрын тухай,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 22
Бүгд: 44
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Төслийн 1 дүгээр зүйлийн “төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээнд заасныг үндэслэн” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлээр” гэж өөрчилж, мөн

зүйлийн “холбогдсон харилцааг” гэсний дараа “Газрын тухай,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 20
Бүгд: 44
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах саналыг дэмжихгүй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 23
Бүгд: 44
47.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 23
Бүгд: 43
46.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах саналыг дэмжихгүй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 23
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4. “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төсөлд доор дурдсан агуулгатай 3, 4 дэх заалт тус тус нэмэх:

“3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимэдсүрэн, мөн газрын хуулийн мэргэжилтэн Б.Мөнхтогтох, Ү.Алтаншагай, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн О.Мөнхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх

Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 21

Бүгд: 43

55.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан нарын 3 гишүүн 2021.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Цогтсайхан, ахлах шинжээч Р.Батчимэг, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь, мөн зөвлөлийн Тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн газрын дарга Г.Нарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч М.Оюунчимэг, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь нар хариулж, тайлбар хийв.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Д.Батлут, Т.Доржханд, С.Чинзориг, Ц.Цэрэнпунцаг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1-ийн 3.1.20 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.20.“бохир ус” гэж хүн амын ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанаас бий болсон, эсхүл тухайн нутаг дэвсгэрээс хурын ус зайлуулахад үүссэн шингэн хаягдлыг” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4-ийн 10.1.10 дахь заалтын “журам,” гэснийг мөн 10.1.12 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4-ийн 10.1.13 дахь заалтыг 10.1.12 дахь заалт болгон өөрчилж, тус заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.12.энэ хуулийн 3.1.14-г заасан хангагчийн үйлчлэх хүрээг тогтоох журам батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт болон 16.2.7 дахь заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7-ийн 20.4 дэх хэсгийн “хорооноос” гэснийг “хорооны тогтоосноос” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг 2 дугаар зүйл болгон өөрчилж, тус зүйлийн 2-ын 8.1.2 дахь заалтын “системийг” гэснийг “барилга, байгууламжийг” гэж, мөн зүйлийн 4-ийн 10.1.1 дэх заалтын “үнэ тариф” гэснийг “тарифыг” гэж тус тус өөрчилж, 10.1.1 дэх заалтын “тухайн орон нутагт мөрдүүлэх” гэснийг, мөн заалтын “тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифыг” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1-ийн 3.1.19 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.19.”саарал ус” гэж ямар нэгэн ялгадасгүй зөвхөн ахуйн бохир усыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтад “3.1.22” гэсний дараа “, 3.1.23” гэж, 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон өөрчилж, тус зүйлд “9.9” гэсний дараа “9.12” гэж, “10.2 дахь” гэсний дараа “хэсэг, 22 дугаар зүйлийн 22.2 дахь” гэж, “судалгаа” гэж” гэсний дараа “9.13 дахь хэсгийн “зөвлөлийн” гэснийг “хорооны” гэж,” гэж, “8.1.7” гэж” гэсний дараа “10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалтын дугаарыг “10.1.13.” гэж” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “12.1 дэх хэсгийн” гэснийг “12.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.18 дахь заалтын” гэж, мөн зүйлийн “8.1.7” гэснийг “8.1.8” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2-ын 5.1.9 дэх заалтын “орчин болон хот, суурины ус хангамж, ариутгах татуургын” гэснийг “орчны” гэж, “гишүүд” гэснийг “гишүүнтэй” гэж, “батална” гэснийг “батлах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “7.1.3 дахь заалтын дугаарыг “7.1.4” гэж,” гэснийг болон “9.8 дахь хэсэг” гэсний дараах “9.10,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг заалтын болон эшлэлийн дугаарыг өөрчилж, төслийн агуулга зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундрага нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Б.Энх-Амгалан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1, 7, 8, 9, 10, 11 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “эсхүл шаардлагатай” гэснийг “шаардлагатай” гэж өөрчилж, мөн зүйлийн “эрх олгосноос бусад тохиолдолд” гэсний өмнө “хуулиар” гэж нэмж, мөн зүйлийн “93 дугаар зүйлийн гарчгийн “захиргааны байгууллага” гэсний дараа “, түүний нийтлэг үүрэг” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “зүйл,” гэснийг, мөн зүйлийн 4, 5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “94 дүгээр зүйлийн 94.4 дэх хэсгийн “30” гэснийг “21” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Саналын томъёоллын 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 1 дүгээр зүйлийн “зүйл, хэсэг, заалт,” гэснийг “хэсэг,” гэж, мөн зүйлийн 2 дахь заалтын тайлбарын “зохицуулалтын” гэснийг “зохион байгуулалт, зохицуулалтын” гэж, 3 дахь заалтын 60.5 дахь хэсгийн “уг” гэснийг “тухайн” гэж, 4 дэх заалтын 64.6 дахь хэсгийн “хуульд заасан Засаг дарга” гэснийг “Засаг даргын хуульд заасан” гэж, 5 дахь заалтын тайлбарын “, цахим холбоос /эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулсан/-ын,” гэснийг “эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулсан цахим холбоосын” гэж тус тус өөрчилж, мөн тайлбарын “зөвхөн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Нийтийн сонсголын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр **Хууль зүйн** байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Арван хоёр.Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Н.Жамъянхүү, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Б.Жаргал, Цагдаагийн ерөнхий

газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Ж.Буянбат, мөн хүрээлэнгийн Шүүх шинжилгээний дүн бүртгэл, мэдээллийн газрын захирал Д.Мөнхбат, Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн А.Амгаланболд, Эдийн засгийн шинжилгээний газрын дарга Ө.Сэр-Од, Криминалистикийн шинжилгээний газрын дарга Х.Бат-Эрдэнэ, мөн газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн Б.Эрдэнэ-Очир, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Ламчин, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны хуулийн хэсгийн ахлах зөвлөх Б.Жамбал, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганхүрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, С.Бямбацогт, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Ц.Сэргэлэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “ажиллагааны” гэсний өмнө “, зөрчил шалган шийдвэрлэх” гэж нэмж, “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад” гэснийг “гэмт хэргийн улмаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалтын “Монгол Улсын хууль, Монгол Улсын” гэснийг “хууль тогтоомж болон” гэж өөрчилж, “хуульд заасан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 9.3, 9.5 дахь хэсэг тус тус нэмэх:

“9.2.Шинжилгээний байгууллага нь шинжилгээг шинжилгээний төрөл тус бүрээр урьдчилан мэдэх боломжгүй санамсаргүй тохиолдлоор хуваарилах программ хангамж ашиглан шинжээч, эсхүл шинжээчийн багт хуваарилна.”

“9.3.Энэ хуулийн 9.2-т заасан программ нь хуваарилагдах шинжээчийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг бүрдүүлж, дараах шаардлага хангасан байна:

9.3.1.шинжилгээний байгууллага шинжилгээ хийлгэх шийдвэр шинжилгээний объектыг хүлээн авсан даруй хуваарилалтыг хийх, хуваарилалтыг өөрчлөх боломжгүй хамгаалалттай байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд шууд өгөх боломжтой байх;

9.3.2.шинжилгээг хуваарилахдаа шинжээчийн мэргэжил, ажлын дадлага, туршлага, мэргэшсэн байдал, эрдмийн зэрэг, цол, ажлын ачаалал зэргийг харгалздаг байх;

9.3.3.цахимаар хийгдсэн хуваарилалтыг гагцхүү энэ хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, эсхүл шинжээч, шинжээчийн бүрэлдэхүүн солигдох нөхцөлд өөрчлөх бөгөөд уг өөрчлөлт нь хүний нөлөөллөөс ангид, ил тод, баримтжуулсан байх.”

“9.5.Энэ хуулийн 9.2-т заасан шинжээчид цахим программ хангамж ашиглан шинжилгээг хуваарилах журам болон энэ хуулийн 9.3-т заасан нөхцөл, шаардлагыг шүүх шинжилгээний төв байгууллагын дарга батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн, мөн зүйлийн Тайлбарын “шинжилгээ хийлгэхээр даалгах” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах” гэж өөрчилж, 9.4 дэх хэсгийн “Шинжилгээ хийлгэхээр даалгах эрх бүхий албан тушаалтан” гэснийг, “байгууллагын тэмдгээр” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн гарчиг, 11.1 дэх хэсгийн “түдгэлзүүлэх,” гэсний дараа “сэргээх,” гэж, мөн хэсгийн “саналыг” гэсний өмнө “ажиллана.

Зөвлөлийн” гэж, 11.3 дахь хэсгийн “тэмдэг” гэсний өмнө “хувийн дугаар бүхий” гэж тус тус нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 11.4.6, 11.5.3 дахь заалт нэмэх.

“11.4.6.тусгай мэдлэг эзэмшсэнийг гэрчлэх мэргэжлийн үнэмлэх, дипломтой байх.”

“11.5.3.хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 18

Бүгд: 42

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.9 дэх хэсгийн “11.5.1, 11.7.3, 11.7.4-т” гэснийг “11.7.3, 11.7.4, 11.7.5-д” гэж, “11.5.2, 11.7.1, 11.7.2, 11.7.5, 11.7.6, 11.7.7, 11.7.8-д” гэснийг “11.5.1, 11.5.2, 11.7.1, 11.7.2, 11.7.6, 11.7.7, 11.7.8-д” гэж тус тус өөрчилж, 11.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, Тайлбарыг 8 дугаар зүйлд шилжүүлэх.

“11.12.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах журам, маягтын загварыг батална:

11.12.1.мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн санг нийтэд танилцуулах, шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдэг, маягт ашиглах журам;

11.12.2.зөвлөлийн үйл ажиллагааны журам;

11.12.3.шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдэг, дүгнэлтийн маягтын загвар.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 20

Бүгд: 42

52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “амархан” гэсний өмнө “түргэн,” гэж нэмж 13.7 дахь хэсэг болгон шилжүүлж, 12.4.1 дэх заалтын “нийтийн” гэсний өмнө “олон” гэж нэмж, 12.4.3 дахь заалтын “дурсгалт зүйл болон түүх, соёлын” гэснийг “болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 21

Бүгд: 42

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “архив үүсгэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16.4 дэх хэсгийн “шинжилгээ даалгасан” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах” гэж тус тус өөрчлөх.

“16.3.Шинжээч энэ хуулийн 16.1-д заасны дагуу тогтоосон хугацаанд шинжээчийн дүгнэлт гаргах боломжгүй бол хугацаа дуусахаас өмнө шинжилгээний байгууллагын хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтанд хугацааг сунгуулах тухай хүсэлтээ өөрийн биеэр мэдэгдэж, хүсэлтээ тайлбарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.4 дэх хэсэг нэмэх:

“18.4.Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хуулиар хориглосноос бусад тохиолдолд шүүх, прокурорын зөвшөөрснөөр шинжилгээний дүгнэлтийг хийх журам, шинжлэх ухааны үндэслэлийн талаар хэргийн оролцогчоос бусад этгээдэд мэдээлэл өгч болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтын “мөрдөгч” гэсний өмнө “зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд,” гэж нэмж, 19.3 дахь хэсгийн “шинжилгээ хийлгэхээр даалгасан эрх бүхий албан тушаалтанд” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтанд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43

55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 22.3.5 дахь заалт нэмэх:

“22.3.5.экологийн шинжилгээний сан.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 20

Бүгд: 43

53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 24.5 дахь хэсэг нэмж, 24.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 24.3 дахь хэсгийн “ажлын шаардлагаар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 17

Бүгд: 43

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, “24.2.Шинжилгээний байгууллагын шинжээч болон бусад алба хаагч шинжилгээний байгууллагын шинжилгээний адилтгал, мэдээллийн санг бусад этгээдэд шилжүүлэх, хуулиар хүлээсэн чиг үүрэгтээ хамааралгүй зорилгоор ашиглахыг хориглоно.”

“24.5.Шинжилгээний адилтгал, мэдээллийн сангийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах хүрээнд шинжилгээний байгууллага шаардлагатай программ хангамж, техник хэрэгслээр хангагдсан байна.”

14.Төслийн 29 дүгээр зүйлийн гарчгийн “багаар” гэсний өмнө “шинжээчдийн” гэж нэмж, 29.2 дахь хэсгийн “шинжилгээ хийлгэхээр даалгах эрх бүхий албан тушаалтан шинжилгээ хийлгэхээр даалгах” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах нэгжийн дарга тодорхойлно. Бусадтай хамтран ажиллах журмыг шүүх шинжилгээний төв байгууллагын дарга батална” гэж, 29.4 дэх хэсгийн “шинжилгээ хийлгэхээр даалгах” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах” гэж тус тус өөрчилж, 29.1 дэх хэсгийн “хоёр, түүнээс дээш” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 19

Бүгд: 42

54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “саналаа дүгнэлтэд хавсаргана” гэснийг “дүгнэлтээ тусдаа гаргана” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 21
Бүгд: 42
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсгийн “нотлогдсон” гэснийг “тогтоогдсон” гэж, 33.6 дахь хэсгийн “тухайн нөхцөл байдалд” гэснийг “боломжит нөхцөлд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.6.3 дахь заалтын “эргэлзээтэй бол” гэсний дараа “байгаль орчинд нөлөөлөх байдлын” гэж нэмж, 38.1 дэх хэсгийн “хуулийн 38.5-д” гэснийг “хуульд зааснаас” гэж өөрчилж, 38.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“39.1.8.энэ хуулийн 40.1-д заасан сэтгэцэд учирсан хор уршиг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “Арван хоёрдугаар бүлэг/” гэсний дараа “Хүний” гэж, 40.2.1 дэх заалтын “энэ хуулийн” гэсний өмнө “хохилогч нь” гэж тус тус нэмж, 40.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 40.1 дэх хэсгийн “26.3 дугаар зүйл /Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/,” гэснийг, 40.2.4, 40.2.5 дахь заалтыг тус тус хасах.

“40.2.2.энэ хуулийн 40.1-д заасан гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэцэд түр зуурын, эсхүл байнгын шинжтэй өөрчлөлт орсон байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн “ажиллагааны” гэсний өмнө “, шүүхийн шийдвэр гүйцэтгэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42

61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсгийн “Шинжилгээний байгууллагын шинжилгээ даалгах эрх бүхий албан тушаалтан шинжилгээний хугацаа сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш” гэснийг “Яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах хугацааг сунгахдаа” гэж өөрчилж, 44.4 дэх хэсгийн “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42

54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсгийн “тусламж” гэсний дараа “, үйлчилгээ” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 45.1.5 дахь заалт нэмэх:

“45.1.5.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэрэглэгдээгүй болон хэрэглэхийг хориглосон эм тариа, арга хэрэгсэл хэрэглэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43

51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.1.Хүний биед шинжилгээ хийхдээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэрэглэгдээгүй болон хэрэглэхийг хориглосон эм тариа, арга хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 15
Бүгд: 43

65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийн гарчгийн, 48.1, 48.2, 48.3 дахь хэсгийн, 48.1.3 дахь заалтын “шинжилгээ хийлгэхээр даалгах” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах” гэж тус тус өөрчилж, 48.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 48.1.5 дахь заалтыг хасах.

“48.2.1.шинжилгээний хуваарилалтыг энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 14
Бүгд: 43
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4.6 дахь заалтын “этгээдэд” гэсний дараа “шүүх, прокурорын зөвшөөрөлгүйгээр” гэж нэмж, “шинжилгээ хийлгэхээр даалгах” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах” гэж өөрчилж, 49.2.1, 49.2.2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“49.2.1.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тавьсан асуултын дагуу шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой хийж, тогтоосон хугацаанд дүгнэлт гаргах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 55 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 55.1.3 дахь заалт нэмж, 55.1.7 дахь заалтын “шинжилгээний байгууллагын хэмжээнд онцгой дэглэм тогтоох,” гэснийг, 55.1.8 дахь заалтын “гамшиг, гамшгийн” гэснийг тус тус хасах.

“55.1.3.шинжилгээний байгууллага, шүүх шинжилгээний үйл ажиллагааг шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах хүрээнд шинжилгээний байгууллагыг шинжилгээний лабораторийн техник, тоног төхөөрөмж, программ хангамж, урвалж бодисоор шуурхай хангах, урвалж бодисын нөөцийг бүрдүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу шууд худалдан авах ажлыг зохион байгуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийн “тусгайлсан шалгуур үзүүлэлтийг” гэснийг “энэ хуулийн 56.4-т заасныг” гэж, 56.7 дахь хэсгийн “шалгалтыг таван жил тутамд авна” гэснийг “шалгалтад таван жил тутам хамрагдана” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 62.1-д заасан” гэснийг “Шинжилгээний байгууллагын алба хаагчийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 15
Бүгд: 43
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсгийн “хэрэг, зөрчилд холбогдсон” гэснийг “хэрэгт яллагдагчаар татагдсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 66 дугаар зүйлийн 66.1.2 дахь заалтыг доор дурдснаар өөрчлөн найруулах:

“66.1.2 гэм буруутай болох нь нотлогдож, шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт “хуульд” гэсний өмнө “; Цагдаагийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” гэж, төсөлд доор дурдсан агуулгатай 68.6 дахь хэсэг тус тус нэмж, 68.2 дахь хэсгийг хасах.

“68.6.Цогцост үзлэг хийх, зөөвөрлөх, задлан шинжлэх ажиллагааг гүйцэтгэсний нэмэгдлийг шүүх шинжилгээний алба хаагчид олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 15
Бүгд: 43
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 71 дүгээр зүйлийн 71.5 дахь хэсгийн “дээшлүүлэх” гэсний өмнө “, мэргэшил” гэж нэмж, “Сум, тосгоны” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 71.13 дахь хэсэг нэмэх:

“71.13.Шинжилгээний байгууллагын алба хаагчийн амь насыг заавал даатгах бөгөөд даатгалын төлбөрийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 15
Бүгд: 43
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 80 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 80.5, 80.6 дахь хэсэг нэмэх.

“80.5.Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь хэсгийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл шүүх шинжилгээг төрөл тус бүрээр шүүх шинжилгээний төв байгууллагын даргын баталсан түр журмаар хуваарилна.

80.6.Сэтгэцэд учирсан хор уршгийг үнэлэх, хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгуулахтай холбоотой Шүүх шинжилгээний тухай хууль болон дагалдах бусад хуулийн зохицуулалтыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 72 дугаар зүйлийн 72.9 дэх хэсгийн “хэмжээг” гэснийг “хэмжээ болон энэ хуулийн 72.6, 72.7-д заасан үнэлгээ, зардлын хэмжээг” гэж өөрчилж, 72.3 дахь хэсгийн “онцгой тохиолдолд” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “дүгнэлт гаргах” гэсний дараа “болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шинжилгээ хийж, дүгнэлт гаргах” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “шинжилгээний байгууллагад 18-аас” гэснийг “хууль сахиулах, шинжилгээний байгууллагад 15-аас” гэж, 54.4 дэх хэсгийн “шинжилгээний байгууллагад 15-аас” гэснийг “шинжилгээний байгууллагад 12-оос” гэж тус тус өөрчилж, 54.2 дахь хэсгийн “улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй,” гэснийг хасах Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан үг хэлэв.

Ажлын хэсэг саналаа татан авсан тул дээрх саналаар санал хураагаагүй болно.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “шинжилгээний байгууллагад 18-аас” гэснийг “шинжилгээний байгууллагад 10-аас” гэж, 54.4 дэх хэсгийн “шинжилгээний байгууллагад 15-аас” гэснийг “шинжилгээний байгууллагад 8-аас” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Ж.Буянбат нар үг хэлж, тайлбар хэлэв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 38
Бүгд: 43
11.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаан даргалагчаас дээрх санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Хоёр.Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсгийн “Албанд” гэсний өмнө “Шинжилгээний” гэж нэмж 55 дугаар зүйлд шилжүүлэх, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсгийн “хуулийн” гэсний дараа “14.7” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн “11.10” гэсэн дугаарыг “11.7” гэж, 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “хийж” гэснийг “хийлгэх” гэж, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “хувьд” гэснийг “хийхэд” гэж, 38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсгийн “материалын хувьд” гэснийг “материал нь” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “4.3

дугаар” гэснийг “24.3 дугаар” гэж, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийн “дарга нартай” гэснийг “даргатай” гэж, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийн “зүйн” гэснийг “зүй” гэж, “дарга нарт” гэснийг “даргад” гэж, 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсгийн “хэрэглүүлэх” гэснийг “хэрэглэх” гэж, 71 дүгээр зүйлийн 71.11 дэх хэсгийн “71.9-д” гэснийг “71.10-т” гэж, 71.12 дахь хэсгийн “хоёр” гэснийг “гурван” гэж, 73 дугаар зүйлийн 73.2 дахь хэсгийн “багийг нууцалж” гэснийг “багийн” гэж, 74 дүгээр зүйлийн 74.4 дэх хэсгийн “асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “болон” гэж, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсгийн “2022 оны 10 дугаар сарын 01-ний” гэснийг “2024 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж, 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсгийн “2022” гэснийг “2023” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан” гэснийг, 4.1.2 дахь заалтын “зэрэг” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “энэ тухай” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.4.4 дэх заалтын “бусад” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “энэ” гэснийг, Тавдугаар бүлгийн гарчгийн “төрлийн” гэснийг, 34 дүгээр зүйлийн Тайлбарын “мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг, 55 дугаар зүйлийн 55.1.8 дахь заалтын “бүх” гэснийг, 74 дүгээр зүйлийн 74.4 дэх хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг дараах “болон” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хүүхдийн сэтгэцэд учирсан”, “хүний сэтгэцэд учирсан”, “гэр бүлийн гишүүний сэтгэцэд учирсан” гэсний дараах “хор уршгийг” гэснийг “гэм хорыг” гэж, “тогтоож болно” гэснийг “тогтооно” гэж, “508.5, 508.6-д” гэснийг “508.5-д” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “, 508.6” гэснийг, “508.6.Энэ хуулийн 508.5-д заасан гэм хорыг арилгахдаа энэ хуулийн 508.4-г заасан журмыг баримтална.” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийн “Эрүүгийн хэрэг” гэсний дараах “шүүхэд” гэснийг хасаж, 2 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн “даалгана” гэснийг “хуваарилна” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “12.Шүүх шинжилгээний ерөнхий газар” гэснийг “13.Шүүх шинжилгээний ерөнхий газар” гэж, 2 дахь заалтын “12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24” гэснийг “13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26” гэж, мөн заалтын “13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25” гэснийг “14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27” гэж, 3 дахь заалтын “газрыг” гэснийг “ерөнхий газрын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “5.1.50, 5.1.51 дэх” гэснийг “5.1.55, 5.1.56 дахь” гэж өөрчилж, мөн хэсгийн “төрлийн” гэснийг, 3 дахь хэсгийн “төрлийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Арван гурав. “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Байнгын хороо боловсруулсан/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр тавьсан асуултад Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Д.Тогтохсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:21/

Уг асуудлыг 17 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Арван дөрөв.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулж, 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Д.Саруул, шинжээч Б.Төрбат, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл, Батлан хамгаалах яамны Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Жавзанжаргал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Т.Нарантунгалаг, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Батцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Х.Сүрэнхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга О.Одончимэг, Эрчим хүчний яамны Хуулийн хэлтсийн дарга Л.Мөнхжаргал, мөн яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох, Эрүүл мэндийн яамны Хуулийн хэлтсийн шинжээч Ш.Мөнгөнцэцэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын улсын ахлах байцаагч Э.Цэрэнчимэг, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, мөн газрын Захиргаа, удирдлагын газрын дарга В.Ганзориг, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Ж.Мөнх-Оргил, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хууль, эрх зүй, дотоод хяналтын газрын дарга У.Халиунаа, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэхийг хууль санаачлагч ирээгүй тул дараагийн хуралдаанаар хэлэлцэхээр хойшлуулав.

Уг асуудлыг 17 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Арган тав.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 3 гишүүн 2022.11.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа, Б.Энх-Амгалан, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, хууль санаачлагч Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	16
Бүгд:	41

61.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн урилгаар Ерөнхий боловсролын “Улаанбаатар Эмпати” сургуулийн 10, 11 дүгээр ангийн сурагчдын төлөөлөл, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны их сургуулийн багш, оюутнууд, Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Ч.Ундрам, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн урилгаар Ховд аймгийн оюутан, залуучуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн урилгаар Нийгмийн ардчилал, Монголын эмэгтэйчүүдийн холбооны орон нутгийн гишүүдийн төлөөлөл, Америкийн Нэгдсэн Улсын

Жеоржтауны Их Сургуульд суралцдаг оюутнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Энхболд, Ц.Туваан нарын урилгаар Төв аймгийн Мөнгөнморьт сумын сургууль, цэцэрлэгийн багш, ажилчдын төлөөлөл, мөн аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяагийн урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын гишүүд, “Парламентын боловсрол” хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын болон Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын ажилтнуудын хүүхдүүд Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 15 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 42 минут үргэлжилж, 76 гишүүнээс 49 гишүүн хүрэлцэн ирж, 64.5 хувийн ирцтэйгээр 18 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 34 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Занданшатар: Энэ өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 1-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 17 асуудал байгаа. Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, хэлэлцэх эсэх үргэлжилж хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Гуравдугаарт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

Тавдугаарт, нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн Газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлуудыг үргэлжилнэ.

Энэ 5 хуулиар бол намын бүлгүүд, Ардчилсан намын бүлэг болон Монгол Ардын намын бүлгүүд энэ 5 хуулиар завсарлага авсан байгаа. Тэгээд намын бүлгүүдийн саналыг сонсоод, үргэлжлүүлж хэлэлцэнэ.

Зургаадугаарт нь бол Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Дараа нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Дараа нь “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Найм.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явуулна.

Есдүгээрт, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуурга ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Арван нэг.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Арван хоёр.Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Арван гурав.Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.

Арван дөрөв.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Маргаашдаа орох байх. Энэ Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх. Нэн яаралтай өргөн мэдүүлсэн байгаа.

Арван зургаа.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, хэлэлцэх эсэх.

Сүүлд нь бол Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчидтэй танилцах асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа, Төмөрбаатарын Аюурсайхан нараас тус тус бичгүүд ирүүлсэн байна. Уншиж танилцуулья.

Салдангийн Одонтуяа гишүүн. Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4

дэх хэсэгт гишүүд энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гарах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдөр 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлэх саналаа үүгээр хүргүүлж байна. Зөвшөөрөл олгоно уу гэсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа.

С.Одонтуяа: Би Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ, Монгол Ардын намын дарга Оюун-Эрдэнэ, Монгол Ардын намаас Улсын Их Хуралд сонгогдсон гишүүдэд хандаж бас үг хэлнэ. Монгол Ардын нам сонгуулийн амлалт, мөрийн хөтөлбөрөө эрх зүйн шийдэл, хууль, журам болох учиртай. Үүнийгээ Улсын Их Хурлын чуулганд бид идэвхтэй оролцож хийх хэрэгтэй байгаа.

Гэтэл сүүлийн үед Улсын Их Хурлын чуулганд олонхын бүлэг ирцээ бүрдүүлж чадахгүй байна. Ирцээ бүрдүүлж чадахгүйгээс сүүлийн үед Байнгын хороод хуралдахгүй байна. Өнөөдөр улс орны асуудал ямар хүнд байгаа билээ. Ийм үед Монгол Ардын нам энэ өөрсдийнхөө үүрэг, хариуцлагыг ухамсарлаж, яагаад энэ улс орныхоо энэ хүнд хэцүү үед чуулгандаа оролцож, идэвхтэй ажиллахгүй байна вэ? Ялангуяа Газрын тухай хууль гэсэн амин чухал хууль хэлэлцэж байхад энэ танхимд 10 хүрэхгүй гишүүн байсан.

Тэгэхээр асуудалд бол ингэж хандаж бол болохгүй байна. Өнөөдөр би яагаад Монгол Ардын намын дарга Оюун-Эрдэнэд хандаж байгаа гэхээр энэ Улсын Их Хурлын гишүүдээ чуулганд нь суулгадаг болго, мөрийн хөтөлбөрийг нь хэрэгжүүлэхэд тэр ажилд нь оруул гэж хэлэх гэсэн юм.

Яагаад гэхлээр өнөөдөр энэ том мэт асуудалдаа хандахгүйгээр дандаа орон нутгийн асуудал, өөрийн удирдах ёс, ардчиллыг гажуудуулсан асуудалд Монгол Ардын намын дарга дандаа хуруу дүрж байна. Би хамгийн сүүлийн жишээ хэлмээр байна. Архангай аймагт яг хуулийн дагуу нутгийн өөрөө удирдах ёс, Нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага тухай хуулийн 56.5.1-д заасны дагуу иргэдийн хурал олонхоороо нэр дэвшүүлсэн хүнийг бүх шалгуур нь хангасан В.Мөнхбат гэж хүнийг Засаг даргаар томилуулахаар шийдвэрлэсэн байгаа. Санал оруулсан.

Гэтэл энийг ямар ч үндэслэлгүйгээр хуульд заасан ямар ч тэр шалгуур, үндэслэлийг хангаагүй гэдгийг заагаагүй хэр нь энэ хүнийг томилохоос татгалзсан байгаа. Энэ мэт нутгийн өөрөө удирдах ёс, тэр тухайн аймаг, орон нутгийн иргэдийн сонголтыг хүндэтгэхгүйгээр энэ мэт бусармаг үйл ажиллагаандаа орохоо болиоч гэдгийг би хэлмээр байна.

Өнөөдөр Монгол Ардын намын даргад ямар ч энэ эрх мэдэл бол дутаагүй шүү. Та нар эрх мэдлээр бол өнөөдөр хахаж байна. Тэгээд хахаж байгаа үедээ ингэж нэг аймгийн, нэг сумын, нэг орон нутгийн эрх мэдлийг битгий хязгаарлаж онигоонд ороод байгаач. Тэр орон нутаг ажлаа хиймээр байна. Архангай аймагт 10 гаруй суманд зудын аюул нүүрлэхсэн байна. Өнөөдөр иргэд өлсөж байна, иргэд даарч байна. Яагаад энэ мэт асуудалд оролцоод байдаг юм бэ? Бидэнд хийх ажил их байна, том ажлууд их байна. Энэ нүүрсний хулгайн ажлаа ярья. Өчигдөр тэр Засгийн газрын хурал дээр бараг тоо нь буруу ч байсан юм шиг ингээд өнгөрөөхгүй шүү та нар.

Энэ нүүрсний хулгайн асуудлыг чинь ард түмэн бүгдээрээ сонсож байна. Энийг эцэст нь хүртэл нь явна. Тэгээд энэ мэт асуудлаа яагаад ярихгүй байгаа юм?

Яагаад Газрын тухай хууль, 5-н багц хууль орж ирж байхад яагаад гишүүд хуралдаа суухгүй байгаа юм? Яагаад Байнгын хороод чинь хуралдахгүй байгаа юм? Одоо энэ асуудлаа цэг тавиад анхаараач ээ. Энэ намын бүлгийн дарга чинь аргаа барж байна. Улсын Их Хурлын дарга чинь аргаа барж байна. Энэ гадаадад зугаалдгаа больцгоо. Энэ хуралдаа сууцгаа. Тэр эрх мэдлээ хэрэгжүүл. Тэр нутгийн өөрөө удирдах ёсны ардчилал, хүний эрх тэр ард түмний сонголтод битгий халдаад бай гэдгийг бас дэд даргын хувьд хатуу хэлмээр байна.

Өнөөдөр улс орны байдал хүндэрчихлээ. Тэр дизель түлшгүйгээс бүх уул уурхай чинь зогсож байна. Бүх эдийн засаг, татвар төлөгчид чинь өнөөдөр хаалгаа барьж байна. Гэтэл энд инээдэм, ханиадам болгоод ингээд байж болохгүй юм.

Г.Занданшатар: Одоо Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн үг хэлнэ. Үндсэндээ адил үндэслэлтэй санал ирүүлсэн байна. Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн. Зочдоо эхлээд танилцуулчихъя.

Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын ажилтнуудын хүүхдүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүүхдүүд та бүхэндээ бас сурлагын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Одоо Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн үг хэлнэ.

Т.Аюурсайхан: Баярлалаа. Хэдхэн хоногийн өмнө Улсын Их Хурлаар мөнгөний бодлогоо батлуулсан Монголбанк бол Улсын Их Хурлын өмнө ажлаа хариуцдаг байгууллага. Тэгээд үүнтэй бас Нийгмийн даатгалын сантай

холбоотой бас Монголбанкны асуудал байна. Нийгмийн даатгалын сан бол 1 сая даатгуулагч, иргэд, хөдөлмөрчдийн мөнгө юм. 50000 ажил олгогчдын мөнгөн хөрөнгө, 460000 тэтгэвэр авагчдын мөнгөн хөрөнгө юм. Тэгэхээр энэ санг нэгдүгээрт эрсдэлд оруулсан энэ хүмүүсийн хариуцлагын асуудлыг ярих ёстой.

Хоёрдугаарт, энэ Монголбанкны эрх хүлээн авагчийг шалгах ёстой гэж үзэж байна. Улсын Их Хурлаас. Тэгэхээр энэ Капитал банкны 104.2 тэрбум төгрөг Нийгмийн даатгалын сангийн мөнгө Капитал банканд байж байгаад дампуурчихсан. Тэгээд энэ мөнгөнөөс нийтдээ 37 тэрбум төгрөгийг бага зэргийн мөнгөн хөрөнгө, тэгээд 25 тэрбумын 78 нэр төрлийн янз бүрийн хөрөнгүүдийг хурааж авсан. Шүүхийн шийдвэрээр. Тэгээд энэнээс болоод 8 удаагийн дуудлага худалдаа явагдаад энэ 17 тэрбумын 51 хөрөнгө огт зарагдахгүй байгаа. Хүн тоохгүй. Тэгсэн мөртөө Монголбанкны эрх хүлээн авагчид тэнчээнээс үнэ бүхий эд хөрөнгийг өөрсдөө хурааж, Монголбанкныхаа мэдэлд, захирлынхаа мэдэлд авч байна шүү дээ. Энэ үнэхээр байж болохгүй. Монголбанк тэр арилжааны банкныг дампууруулдаг, тэгээд тэр өмч хөрөнгийг нь дээрэмддэг. Энэ хуучин ийм асуудлууд байсан шүү дээ. Энэ үргэлжлээд явж байна шүү дээ.

Тухайлах юм бол энэ Сэлхийн зусланд “Замбуулин” village гээд хотхон байгаа. Алтны компани барьсан. Тэгээд өрөндөө Капитал банканд хураалгасан. Тэгээд энэнээс 3 ширхэг амины орон сууц, хаусыг Монголбанк удирдлагуудынхаа мэдэлд хураагаад авчихсан байна шүү дээ. Монголбанкны хөрөнгөөр тэнд нь их засвар, дотоод заслыг хийчихсэн байна шүү дээ. Тэгээд Тэргүүн дэд ерөнхийлөгч нь тэрэнд нь орчихсон. Одоо амьдраад явж байна гээд иргэд мэдээлж байна шүү дээ.

Гэтэл энэ санд хураагдсан мөнгө нь болохлоор борлуулагддаггүй, олон төрлийн ийм янз бүрийн юм авчихдаг. Тэгээд гол энэ хөрөнгийг нь Монголбанк завшаад ингээд авч болдог юм уу? Тийм учраас энийг Улсын Их Хурлаас би шалгах ёстой гэж үзэж байна. Шүүх дээр Капитал банкны энэ нэмэлт хөрөнгүүдийг тогтоох ажиллагаа хийгдэж байгаа. Хуулийн байгууллагууд энэ нуугдмал хөрөнгүүдийг ил болгох ажиллагаанууд хийгдэж байгаа. Тэгээд шүүхээр шийдсэн шийдвэр гүйцэтгэхийн байгууллага хурааж авсан энэ мөнгөн хөрөнгө хамгийн түрүүнд иргэд, хөдөлмөрчдийн мөнгө байхгүй юу.

Гэтэл тэн дээр энэ шийдвэр гүйцэтгэгчид Дэлгэрхүү гээд нөхөр байгаа. Тийм учраас энэ дээр Улсын Их Хурлаас би шалгах ёстой гэж бодож байгаа. Энэ сангийн хөрөнгөнд байгаа энэ эд хөрөнгийг эрсдэлээс гаргах ёстой гэж бодож байгаа. Яагаад энийг эрсдэлд хэн оруулсныг бас цааш нь ярих ёстой гэж бодож байгаа. Тэгээд ингэж цаашаа явахгүй бол энэ бол бас бага хөрөнгө биш шүү. 100 тэрбумын асуудал зөвхөн Нийгмийн даатгалын сан дээр. Тэгээд бусад Эрүүл мэндийн даатгалын сан дээр хэд байна? Бусад харилцагчдын ямар мөнгөн хөрөнгө байна? Тэгээд энэ дээр яахлаараа ингэж Монголбанкны эрх хүлээн авагчид дураараа аашилж, дур зоргоороо тэрийг нь авч, завшиж, зарцуулж байдаг юм?

Тийм учраас энэ дээр Улсын Их Хурлын дарга та хариуцлага сахилгыг дээд зэрэгт хүрч, энийг нэг мөр нэг тийш нь болгож, Улсын Их Хурлаас хяналт шалгалтын ажлын хэсгийг манай Нийгмийн даатгалын сангийн төлөөллийг оролцуулж байгаад байгуулж, ингэж байж бид нар энэ мөнгөө бас олж авмаар байна шүү дээ. Тэх. Тийм учраас энэ дээр та бас анхаарч өгөөч гэж ингэж хүсэж байна.

Г.Занданшатар: Эдийн засгийн байнгын хороо ажлын хэсэг байгуулж, энэ Монголбанк, Капитал банк, эрх хүлээн авагчтай холбоотой асуудлыг шалга.

Хэлэлцэх асуудалдаа орёе. Энэ нь Монголбанктэй холбоотой олон гомдлуудыг нэгтгээд ер нь шалгах нь зүйтэй байх. Одоо хэлэлцэх асуудалдаа орно.

Нэг.Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар хэлэлцэх эсэхийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр уг асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл завсарлага авсан. Завсарлагатай холбогдуулж, завсарлагын хугацаа бас дуусгаад энэ Газрын ерөнхий хуулиа хэлэлцэж байж Кадастрын хууль, газрын бусад хуулиуд хэлэлцэх логик дарааллын хувьд байгаа учраас бусад хуулиуд дээр бас 4 хоногийн завсарлага Ардын намын бүлэг авчихсан. Энэнтэй холбогдуулаад өнөөдөр хэлэлцэнэ. Одонгийн Цогтгэрэл гишүүн үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Гишүүддээ шинэ 7 хоногийн мэндийг хүргэе. Өнгөрсөн Баасан гаригт газрын багц хуулиуд, тэр тусмаа Газрын ерөнхий хууль болоод Газар чөлөөлөлтийн тухай хууль дээр Ардчилсан намын бүлгээс завсарлага авсан. Энэ дээр хэлэлцэх эсэх явж байгаа болохоор үзэл баримтлалын шинжтэй хэд хэдэн зүйлүүд байгаад байгаа юм. Газрын хуулийн үндсэн үзэл баримтлал нь бүгдийг төвлөрүүлсэн, босоо болгосон, түрүүн Одонтуяа гишүүний хэлээд байгаа санаанууд ч энэ дээр маш ихээр гарсан. Орон нутгийн эрх мэдлийг Улаанбаатар хотод, төвд төвлөрүүлсэн ийм үзэл санааны шинжтэй асар олон зүйлүүд энд яваад байгаа юм. Энэ чинь бид нарын нөгөө орон нутгийн

өөрөө удирдах ёс гэдэг өнгөрсөн 30 жилд баримталж ирсэн зүйлийг ийм нэг хууль орж ирэх бүхэнд үндсэндээ хуулийн хавчуурга, зүйл, заалт байдлаар дандаа ийм зүйл, заалтууд орж ирсээр байгаад энэ улс чинь Улаанбаатар төвтэй, босоо удирдлагатай, төвлөрсөн ийм улс болж хувирч байна. Энэ асуудал дээр бас Ардчилсан намын бүлгээс завсарлага авсан. Дахиад бүлгийн гишүүд ч ерөнхийдөө ийм байр суурьтай байгаа.

Тэгээд дараа дараагийн хэлэлцүүлэг болоод олон зүйлүүд дээр энэ бүгдийг санал санаачилга гаргаад бас цаашид анхаараад явж таарах байх.

Нөгөө талд нь, нөгөө асуудал нь Газар чөлөөлөлтийн тухай хууль. Газар чөлөөлөлт гэдэг хуульд ч гэсэн дахиад хувийн өмчийг хуулиар хамгаална гэдэг энэ эрх зүйн тогтолцоог бид нар энэ барилга байшин, структурыг бариад явж байгаа байж яг хуулийн хүрээнд хэрхэн иргэн санал нэгдээгүй байсан ч гэсэн газрыг нь хэрхэн улсын эрх ашиг, нийтийн эрх ашиг гэдэг нэрийн дор хэрхэн чөлөөлж болох вэ гэдэг ийм үзэл санаатай хууль орж ирж байгаа. Энэ дээр Ардчилсан намын бүлгээс бас завсарлага авсан. Энэ завсарлага, ер нь энэ асуудалтай холбогдуулаад Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын Хууль, эрх зүйн хэлтэс Үндсэн хууль зөрчсөн эсэх байж болох тухай дүгнэлтийг энэ дээр эхлээд бас гаргаач.

Тэгэхдээ хуулиа цаашаа, газар чөлөөлөлтийн хуулиа хэлэлцээд явдгаараа бас явна биз. Бид нар бас бүлгээс Улсын Их Хурлын Хууль, эрх зүйн хэлтэст бас өнөөдөр хандъя гэж бодож байгаа. Энэ дээр эхлээд энэ хэлэлцүүлгийн явцад дүгнэлтээ гарга. Үндсэн хуулийн зөрчил энд чинь байгаа юм биш биз дээ? Хувийн өмчийг хуулиар хамгаалахгүй болчихож байгаа юм биш биз дээ? Хувийн өмчийг хуулийн хүрээнд дээрэмдэж авч болох

тухай зүйл заалт энд чинь орчихсон юм биш биз дээ гэдэг ийм санал, байр сууриудтай Ардчилсан намын зүгээс байгаа.

Тэгээд энэ хуулиуд нь бас дахиад цааш Улсын Их Хурлын хуулийн тухай, дэгийн тухай хуулийнхаа дагуу хэлэлцэгдээд явна биз. Тухай тухайн үед нь бас байр сууриудаа илэрхийлээд явцгаана.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяагийн урилгаар Ерөнхий боловсролын “Улаанбаатар Эмпати” сургуулийн 10, 11 дүгээр ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилт, сайн сайхныг хүсье.

Эрдмийг хичээлээр, эрлийг сургаар гэдэг. Сайн хичээж, сайн сурцгаагаарай. Амжилт хүсье.

Одоо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хууль, эрх зүйн лавлагааг Байнгын хорооноос шийдвэрлүүл. Улсын Их Хурлын намын бүлгээс бас санал гаргавал шийдвэрлэж болохоор байгаа. Тэгээд Улсын Их Хурлын Тамгын газар Байнгын хороодоор хэлэлцэх үед хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа Цогтгэрэл гишүүний хэлсэн тэр Үндсэн хуулийн зөрчилтэй эсэх асуудлыг хууль, эрх зүйн лавлагаа гаргах үүрэг, чиглэл өгч байна. Наад хууль дээрээ харчхаж байгаач та нар.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байгаа. Ажлын хэсгийг оруулъя. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Ажлын хэсгийн гишүүд Бэгзжавын Мөнхбаатар Барилга хот байгуулалтын

сайд, Хаянгаагийн Болорчулуун Хүнс, Хөдөө аж ахуйн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Гантөмөрийн Түвдэндорж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Анандын Энхманлай, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Цогтын Баярбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Борисын Буяннэмэх, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхбаатарын Цогтгэрэл, Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга Батдэлгэрийн Нямдорж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Цэвэлмаагийн Ихбаяр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Кадастрын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Баянтүмэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга Раднаабазарын Ганхуяг, Ашигт малтмал, газрын тосны газрын Хуулийн хэлтсийн дарга Рагчаагийн Энхтайван, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Гомбодоржийн Болормаа. Болормаа байхгүй юм байна тээ?

Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Базаргүрийн Гоёсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Найдангийн Бямбадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн

Баасандоржийн Энхбат, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн Дэндэвийн Энхтуяа.

Энэ Сангийн яамныхан яагаад байхгүй байгаа юм? Санжаадорж даргаа. Мижиддоржийн Санжаадорж дарга энэ Кадастрын хууль ч тэр, Газрын ерөнхий хууль ч гэсэн ер нь үл хөдлөх хөрөнгийн татвар чинь улсын төсвийн орлогын бараг 10 хувь нь байдаг. Бусад улсуудад. Одоо энэ газрын хууль энэний чинь, энэ кадастр чинь татвараас бараг үүссэн. Олон улс оронд. Тэгээд яг ийм чухал юм хэлэлцэхэд энэ танай Төсвийн орлого, Татварын газрынхан яагаад байхгүй байна? Одоо энэ Улаанбаатарын түгжрэл, утаа олон асуудлыг шийдэх үндэс чинь энэ кадастр, татвартай холбоотой шүү дээ. Энийг бид нар яаралтай шийдэх хэрэгтэй байгаа юм. Энэнтэй уялдуулж. Та тэр Татварын газрын улсуудаа дууд. Танай Татварын бодлогын газрын мэргэжилтэн Энхбатыгаа дууд.

Одоо санал хураалт явуулна. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Энэ ажлын хэсэг танилцуулсан. Ажлын хэсэг бол дараагийн 5 хууль дээр үндсэндээ адилхан байгаа.

Байнгын хорооны саналаар Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Газрын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны

байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Адъяаа гишүүн суугаарай. Санал хураалт. Энэ эхний санал хураалт учраас бүртгэл, төстийн санал хураалтыг явууллаа. 14 гишүүн санал хураалтад оролцоогүй байна. Бүртгэлийнхээ санал хураалтад оролцоорой. Санал хураалт явуулна. Одоо Байнгын хорооны саналаар төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

37 гишүүн дэмжиж, 84.1 хувийн саналаар санал дэмжлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд орёё.

10.57 цаг

Хоёр.Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр уг асуудлаар Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга

Дуламдоржийн Тогтохсүрэн 4 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Тогтохсүрэн дарга үг хэлэх үү? Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр Монгол Ардын намын бүлэг завсарлага авсан. Энэ бол их чухал ач холбогдолтой хууль. Ер нь энэ Газрын тухай багц хуулийг Улсын Их Хурал нэлээн сайтар хэлэлцэж, олон талаас нь хэлэлцэж, шийдэх ёстой. Уг хуулийн төслийг Монгол Ардын намын бүлэг хэлэлцээд, төслийг хэлэлцэх эсэхийг бол дэмжих нь зүйтэй. Тэгээд Улсын Их Хурлаас ажлын хэсэг гараад нэлээн нухацтай хэлэлцэх, иргэд, олон нийт, хэрэглэгчдийн санал хүсэлтийг бас нэлээн сайн авч тусгах шаардлагатай гэж үзсэн.

Тийм учраас Монгол Ардын намын бүлгийн завсарлагын хугацаа дууссан тул хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцүүлж өхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд нэр, овог, ажил, албан тушаал нь мөн адил. Түрүүчийн хуультай. Багц хуулиуд учраас. Дараагийн 4 хуулиа ч гэсэн үндсэндээ завсарлагын хугацаа дууссан гээд тооцоод шууд явчихъя. Тэгж тохирлоо. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот

байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай гээд нийт 15 хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

37 гишүүн дэмжиж 84.1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд орно.

11.01 цаг

Гурав дахь асуудал. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

2012 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр уг асуудлаар Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн ажлын 4 хоногийн завсарлага авсан. Завсарлагын

хугацаа дууссан байна. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Тогтохсүрэн гишүүн түрүүн үг хэлж дууссаныг мэдэгдсэн.

Ийм учраас одоо санал хураалт явуулна. Ажлын хэсгийн гишүүдийг протоколд тусгая. Түрүүчийнхтэй мөн адилаар. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих санал хураалт явуулья.

37 гишүүн дэмжиж, 84.1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд орё.

11.02 цаг

Дөрөв.Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн Газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Ажлын хэсгийн гишүүд түрүүчийнхтэй мөн адил. Овог, нэр, ажил, албан тушаал мөн адил. Энэ асуудлаар 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл ажлын 4 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан үг хэлэх үү? Үг хэлэхгүй. Түрүүн үг хэлэхдээ завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдсэн. Хууль, эрх зүйн лавлагаа гаргах шаардлага болон завсарлагаар хэлэлцсэн асуудлуудаараа дүгнэлтээ хэлсэн. Ийм учраас үргэлжлүүлэн хэлэлцье.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. Үг хэлэх, дэмжсэн, дэмжээгүй гишүүн байна уу? Алга байна. Санал хураалт явуулья. Байнгын хорооны саналаар нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн Газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

37 гишүүн дэмжиж, 84.1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд орно.

11.04 цаг

Тав.Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Барилга, хот байгуулалтын сайд Бэгзжавын Мөнхбаатар танилцуулна.

Б.Мөнхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Газрын төлбөрийн тухай хууль 1997 онд Улсын Их Хурлаар баталсны дагуу газрын суурь үнэ, төлбөртэй холбоотой харилцааг зохицуулж ирсэн бөгөөд бусад хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор нийт 29 удаа нэмэлт, өөрчлөлт орсон юм.

Газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо жил бүр өсөн нэмэгдэхийн хэрээр газрын төлбөр төлөгчийн бааз суурь нь өргөжиж, төр өөрийн өмчийн газраа бүртгэл, зураглалд хамруулан түүнээс орлого олох, эргээд газрыг хамгаалах, нөхөн сэргээх, санхүүгийн үүсвэрээр хангагдах бодит боломж бүрдэж байна. Тухайлбал, 1998 онд улсын хэмжээнд нийт 283000 Га газар эзэмшигч, ашиглагч бүртгэлтэй байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар зургаан зуун жаран гурван мянган нэг зуун дөчин таван мянган газар өмчлөгч, 486099 газар эзэмшигч, 2232 газар ашиглагч бүртгэлтэй байна.

Мөн улсын хэмжээнд газрын төлбөрийн орлогоос улсын төсөвт нийт 1.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж байсан бол 2021 онд өссөн дүнгээр 112.6 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Газрын төлбөрийн тухай хуулийг 1994 онд батлагдсан Газрын тухай хуулийн үзэл баримтлал, агуулгатай нийцүүлэн 1997 онд баталсан бөгөөд тодорхой хугацаанд зорилтоо бүрэн хангаж, газрын суурь үнэ, төлбөртэй холбоотой харилцааг зохицуулж ирсэн боловч газрын төлбөрийг зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, инфляцын түвшинтэй уялдуулан тогтоох, улмаар газрын төлбөрийг эдийн засгийн хөшүүрэг

болгон ашиглахтай холбоотой асуудлыг бүрэн зохицуулахад учир дутагдалтай байгаа юм.

Иймд Газрын төлбөрийн тухай хуулийг Татварын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нийцүүлэх, Газрын ерөнхий хууль болон Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан боловсруулах, хуулийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа зөрчил дутагдлыг арилгах, зах зээлийн нийгэмд шаардлагатай нийцүүлэн улам боловсронгуй болгох замаар уг хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулах шаардлага бий болж байна.

Газрын тухай хуулийн төсөлд дараах асуудлыг бид тусгасан. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Газрын төлбөрийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа газрын суурь үнэлгээтэй холбоотой харилцааг олон улсын жишгийн дагуу Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаж, Газрын төлбөрийн тухай хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагатай харилцааг дутуу тодорхойлсныг илүү өргөн хүрээнд тодорхойлсон. Газрын төлбөрийн хувь, хэмжээг тодорхой хязгаарт багтаан нэмэгдүүлж, энэ хязгаар дотор багтаан хөгжлийн онцлог, хүн ам, газар ашиглалтын байдалд нийцүүлэн газрын төлбөр хэд байхыг тухайн орон нутаг өөрөө шийдвэрлэдэг байх зохицуулалтыг мөн уг тусгасан.

Энэ зохицуулалттай холбогдуулан Татварын ерөнхий хуульд газрын төлбөрийг Засгийн газар тогтоодог байсан заалтыг хасаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоодог байхаар нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төслийг боловсруулахдаа төрийн өмчийн газрыг аливаа хэлбэрээр

ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ямар нэгэн байдлаар төлбөр төлдөг байх, төлбөрийн бааз суурийг өргөтгөх замаар улсын төсөвт газрын төлбөрийн орлогоос орох орлогыг нэмэгдүүлэх зарчмыг баримталсан. Газрын болон татварын асуудал эрхэлсэн байгууллагууд хоорондоо эрх үүрэг, оновчтой болгож, газрын төлбөр, татварын мэдээллийг нэгдсэн тогтолцоог байгуулах, дундын мэдээллийн сангаар дамжуулан төрийн болон бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох, газрын төлбөр, татварыг ногдуулах, төлбөр хураах, хяналт тавих, маргаан шийдвэрлэх зэрэг олон асуудлыг нарийвчлан тодорхойлсон.

Хууль зөрчсөн этгээдэд ногдуулах, хариуцлага, хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг мөн тусгасан. Хууль хоорондын харилцан уялдаагүй байдлыг шийдвэрлэхийг зорьсон. Төлбөр төлөгчийн бааз суурийг өргөтгөх, төлбөр ногдуулалт, барагдуулалтыг цахим болгох, дундын мэдээллийн сангаар дамжуулан харилцан мэдээлэл солилцдог байх харилцааг зохицуулснаар төрийн үйлчилгээ түргэн шуурхай, төлбөр төлөгчдөд хүндрэлгүй, хялбар цаг хэмнэх нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн хуулийн төсөлд газрын төлбөр тооцох үзүүлэлт, төлбөрийн хувь, хэмжээ, газрын төлбөр ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх, төвлөрүүлэх, тайлагнах, хяналт тавих талаар тодорхой зохицуулалтыг тусгасан болно.

Энэхүү хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Г.Занданшатар: Одоо төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Гомпилдоогийн Мөнхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Газрын төлбөрийн тухай хууль нь 1997 онд батлагдсан бөгөөд тодорхой хугацаанд зорилтоо бүрэн хангаж, газрын суурь үнэ, төлбөртэй холбоотой харилцааг зохицуулж ирсэн боловч газрын төлбөрийг зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, инфляцын түвшинтэй уялдуулан тогтоох, улмаар газрын төлбөрийн эдийн засгийн хөшүүрэг болгон ашиглах, төлбөрийг тооцох үзүүлэлт, хувь хэмжээг тогтоох, хөнгөлөлт, төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, хяналт тавихтай холбоотой асуудлыг бүрэн зохицуулахаар энэ хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаараа газрын төлбөр нь зах зээлийн үнэлгээнд тулгуурлан татварын суурийг өргөжүүлэх, татвар тэгш, шударга, үр ашигтай байх зарчмыг хэрэгжүүлж, газрын төлбөрийг бүрэн төвлөрүүлдэг болох, газрын төлбөр ногдуулах, төлбөр төлөх харилцаа ил тод, энгийн, ойлгомжтой, хүнд сурталгүй болох нөхцөл бүрдэнэ гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг D-Parliament.mn сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.6 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы

нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд нэр, овог, ажил, албан тушаал өмнөхтэй нь мөн адил. Багц хууль. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Жигжидийн Батжаргал гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Батгөмөрийн Энхбаяр асуулт асууна.

Б.Энхбаяр: Газрын төлбөрийн тухай бие даасан хууль орж ирж байгааг би бол хэлэлцэхийг нь дэмжиж байгаа. Ер нь газар бол хүний хувийн өмчийн, ер нь өмчийн хамгийн суурь. Хамгийн үнэтэй баялаг. Тэр дундаа хувийн өмчийн газар гэдэг бол үнэлэгдэхгүй ийм үнэ цэнтэй зүйл. Үр хүүхдэдээ хэдэн үе дамжиж өвлүүлэх хамгийн баталгаатай хөрөнгө. Газар бол устдаггүй, шатдаггүй, нурдаггүй, сүйрдэггүй ганц хөрөнгө. Тэр утгаараа энэ бол л хамгийн үнэтэй. Энэ үнэтэй баялгаа бид ихээхэн үнэ цэнгүй байлгаж байгаа. Тэр нь юун дээр вэ гэхээр би газрын төлбөр буюу татвар дээр хэлэх гэж байгаа юм. Энэ үнэтэй байлгах гол үндэс нь юу вэ гэхээр газрын үнэлгээ тогтоох аргачлал байгаад байгаа юм. Бид газрынхаа үнийг ер нь тогтоохдоо юуг харгалзаж авч үздэг вэ гэж? Одоогоор бид ганцхан үндэслэл

харгалзаад байгаа юм. Тэр нь байршил. Байршил, байршил, байршил.

Тухайлбал, өнөөдөр Улаанбаатар хотын газрын татварыг бид нар Улаанбаатар хотыг 4 бүсэд хувааж төлбөрийг нь авдаг. Ингэхдээ тухайн газар дээр үйл ажиллагаа явуулж байгаа нэг зорилго, агуулга гэхээсээ илүү зүгээр махчлах гэж хэлэх үү дээ. Зүгээр 4 хуваачихсан. Улаанбаатар хотоо. Тэгээд А, Б, В, Г.

Гэтэл энэ яг газрын үнэлгээ, төлбөрийг тогтоодог улс орнуудад бол шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бол тогтооход бол нийтдээ 90 гаруй шалгуураар газрын үнэлгээг тогтоодог юм байна лээ. 90 гаруй. Байршил орно. Тухайн үйл ажиллагаа явуулж байгаа нь нийгэмд чиглэсэн буянтай үйл байна уу, ашгийн төлөө байгууллага байна уу. Дуу чимээ, дуу чимээ. Төмөр замд ойр байна уу? Жишээлбэл, манай энэ 26 дугаар хорооны Баянмөнгөл хороолол гэхэд хажуугаар нь төмөр зам шөнөжин явж байгаа байхгүй юу. Энэ дуу чимээ. Тэр газар хөдлөлтөд тогтвортой байна уу, үгүй юу. Тухайлбал, Улаанбаатар хотын манай Баянзүрх дүүрэг Сансар хавийн газар бол Улаанбаатар хотын газар хөдлөлтөд хамгийн тэсвэртэй ийм бүс нутаг байгаа. Яагаад гэхээр яг дор нь маш том ургаа хад байдаг. Ургаа хад байдаг.

Тийм учраас газар хөдлөлтөд хамгийн тэсвэртэй бүс нутаг бол энэ сансрын энэ хавь. Тийм учраас энийг харгалздаг. Бас тэр үнэлгээнд. Ингээд ийм олон хүчин зүйлүүдээр дамжиж байж газрын үнэ бодитой тогтоогддог. Ингэж бодитой тогтоогдсоны үндсэн дээр тэр газраас зүй зохистой буюу тэр татварыг, хэмжээг тогтоодог.

Ингэж тогтоохдоо цаашдаа энэ газрын орж ирж байгаа төслөөр орон нутгийн иргэдийн хурлуудад эрх хэмжээг

шилжүүлж байгаа юм байна. Өөрөөр хэлбэл нөгөө газрын аргачлалаар, Засгийн газраас баталсан аргачлалын дагуу тэр хэмжээг тогтоох эрхийг иргэдийн хуралд олгож байгаа юм байна. Би энийг маш их дэмжиж байна. Энэ бол жинхэнэ өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх гэж байгаа, нөгөө төсөв хөрөнгийн хуваарилалтыг оновчтой болгох гэж байгаа ийм арга хэмжээ байна гэж ингэж үзэж энэ хуулийн хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа.

Г.Занданшатар: 83, Сандагийн Магнайсүрэн. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

С.Магнайсүрэн: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яам Магнайсүрэн. Өнөөдөр газрын төлбөрийг тооцохдоо газрын суурь үнэлгээний зэрэглэл, бүсийг харгалзаж тогтоож байгаа. 2018 оны 6 сарын 20-ны өдөр Засгийн газрын 182 дугаар тогтоол батлагдаад, хуучин бол ерөөсөө нийслэлийн хэмжээнд ганцхан бүс байсан бол өнөөдөр энэ тогтоолоор 16 бүс болоод, 16 бүс нь 16 төрлөөр тогтоогдож байгаа. Энэ газрын төлбөрийг тогтоохдоо мэдээж бүс, зах зээлийн үнийн мэдээнд шинжилгээ хийх, тэгээд түүн дээр газрын үнэд нөлөөлөх хүчин зүйлүүдийг харгалзах, энэ дотроо дэд бүтэц, бусад асуудлуудыг тооцоолж, ингэж суурь үнэлгээг тогтоож байгаа.

Ерөнхийдөө 500 гаруй мянган нэгж талбарт улс орны хэмжээнд төлбөр ноогддог гэж ингэж тойм тоогоор үзэх юм бол 2021 онд 21 оны баталгаажсан мэдээгээр 112.6 тэрбум төгрөгийн орлого улсын төсөвт орж ирсэн. Өнөөдрийн бид нарын энэ оруулж ирж байгаа төслөөр бол доод тал нь 22.2 тэрбумаас 458.8 тэрбум төгрөгийн орлого олох ийм бололцоотой байгаа.

Гол онцлог бол бид нар энэ интервалынхаа суурь үнэлгээнд ноогдож

байгаа газрын төлбөрийн интервалыг, дээд интервалыг нь 2 дахин өндөрсгөж орж ирээд, энэ дотор бол нөгөө орон нутгийн иргэдийн төлөөлөгч, аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал маань газрын төлбөрөө тухайн орон нутаг дээр тогтоох тэр эрхийг нь олгосон. Хуучин бол ганцхан хот, тосгоны эдэлбэр газар дээр интервалтай байгаад тэр дээр нь иргэдийн хурал тогтоогоод Засгийн газар төлбөрийн хэмжээ тогтоодог ийм хуулийн зохицуулалтыг энэ удаа Засгийн газар биш Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь тогтоох нь оновчтой юм гэж үзээд энэ оруулж ирж байгаа.

Ингэд Иргэдийн Төлөөлөгчдийн хурал бол бүгдээрээ дээд интервалаар тогтооно гэж үзвэл 458.8 тэрбум төгрөг орно. Хамгийн доод интервалаар тогтоолоо гэж үзэх юм бол 22.2, дунджаар бол 240.5 тэрбум төгрөгийн орлого бол улсын төсөвт орох юм гэсэн ийм тооцооллыг бид нар оруулж ирж байгаа.

Суурь үнэлгээний бүсчлэлийг Энхбаяр гишүүний асуусанчлан 16 бүс болгоод хотын 1 дүгээр зэрэглэлээс авхуулаад хамгийн захад нь 16 дахь бүс, тэгээд тэр нь 16 төрлөөрөө ингэж 2018 онд шинэчилсэн ийм тогтоолоор ингэж зохицуулагдаж байгаа. Цаашдаа бид нар ер нь 3 жил тутамд энэ газрынхаа суурь үнэлгээгээ шинэчилж явж байя гэсэн ийм концепцыг бас оруулж ирж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Энэ Газрын тухай хууль дээр бол гишүүд онцгой анхаараарай. Монгол Ардын намынхан ялангуяа онцгой анхаараарай. Та нар энийг уншихгүй байна шүү. Нүдний булай болоод энэ Монголын ард түмний чинь яг тусгаар тогтнолын тухай хууль шүү. Тэгээд

энэ дээр бол тодруулж асуух 4 асуулт байна. Татварын хувь хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн хурлын бүрэн эрх болгохоор зааж оруулсан юм байна. Ямар зарчмыг барьсан юм бэ? Миний бодлоор энэ хууль бол татварын асуудлыг 6 яаманд тараагаад өгчихсөн. 360 хэдэн суманд тараагаад өгчихсөн юмаа нэг улс байна даа. Unitary-ны улс байна даа. Буцаагаад хянаж байна гэж ойлгосон. Энэ зарчмыг надад хэлж өгөөч.

Хоёрдугаарт, төрийн өмчийн газрыг дур мэдэн ашигласан хариуцлагын заалтууд энд байгаа юу? Жишээ нь төрийн өмчийн газруудыг бүгдийг нь тэр сургууль, цэцэрлэг, эмнэлэг, тэгээд төрийн өмчийн бүх өмчийн газрууд дээр бол зүгээр л найр хийсэн. Энэ гурван 10 жил, 30 жил бол эрх баригчид бүгдээрээ хагартлаа баяжсан. Дандаа газраар баяжсан. Энэ дээр хариуцлага байгаа юу?

Дараагийн 3 дахь асуулт. Төслийн 7.4-т стандартын шаардлага хангаагүй ариун цэврийн байгууллагыг барьсан бол газрын төлбөрийг 2 дахин өсгөж тооцно гэжээ. Энэ стандарт байх хэрэг юу байгаа юм? Стандартын шаардлага хангаагүй бол. Ийм хууль эрх зүйн акт байдаг юм уу? Стандартын шаардлага хангахгүй бол төлбөрөө төлчихөд болно гэж байна шүү дээ. 2 дахин өсгөхөд болно. Стандартыг зөрчиж болдог юм уу? Ингээд зөрчөөд 2 дахин өсгөсний дараа нөгөө зөрчиж байгуулсан байгууллага аяндаа өөрөө алга болчих юм уу? Миний энэ 2 асуултад хариулаарай.

Дараагийн асуулт төслийн 7.1.5. Би өнөөдөр энэ хэлэлцэх эсэхийг нь дэмжихийн төлөө энийг ярьж байгаа юм шүү. Яагаад гэвэл одоо байгаа хууль нь дээрмийн хууль байгаа учраас. Одоо байгаа хууль нь ард түмний эсрэг хууль учраас. Одоо байгаа хууль нь газрын наймаачин, улс төрчдөд зориулсан хууль

учраас дэмжих гээд би энэ болгоныг яриад байгаа юм.

Дараагийн асуулт 7.1.5.Ашигт малтмал ашиглах зориулалттай газрын төлбөрийг 0.2-4 хувиар гэж заасан байгаа. Энийг 3 point-оор би нэг тодруулъя даа. Миний энэ point болгон дээр хариулбал буян болно доо. Ашигт малтмалын хайгуул хийх газрын төлбөр авахгүй юм уу? Нэгдүгээр асуулт. Та яагаад гэвэл та нар тэр 6.2-оо нэг унш даа. Энэ дотор хайх үйл ажиллагааг тусгасан байгааг анхаараарай. 6.2 би яг тодруулж асууж байна шүү. Би зүйл, заалт, хуудастай нь ярьж байна.

Хуудас 2. Газрын төлбөрийг 0.2-4 хувиар тогтооход баримталсан зарчмыг тайлбарлаж өгөөч. Та нар чинь энэ дээр, үзэл баримтлал дээр газрын үнэлгээг олон улсын жишигт ойртуулна гэж байгаа. Хаанахыг баримталчихсан юм? Яг ямар зарчим барьсан юм? Надад тэр олон улсынх нь зарчимтай нь хэлж өгвөл бүр сайн шүү.

Дараагийн асуулт. Кадастрын тухай хуулийн төслийн 21 дүгээрт заасан байгаа. Та нар төслийн 21-ийг хараарай. Ашигт малтмал хайх, ашиглах газрын зах зээлийн үнийн талаар тодорхой бус, ямар ч тодорхойгүй байгаа. Энэ чинь ер нь ашигт малтмалын энэ дандаа ашигт малтмалынх нь лоббитой орж ирдэг. Энэ хууль дээр арай нэг наашаагаа ард, иргэдэд зориулсан болов уу гэж би горьдож байгаа учраас та нар нэг анзааргагүй байж байгаад ийм алдаа хийчихсэн болов уу гэж бодоод, сайхан сэтгээд миний энэ асуултуудад хариулж өгч тус болно уу.

Г.Занданшатар: Магнайсүрэн Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

С.Магнайсүрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яам Магнайсүрэн. Газрын

төлбөрийн хувь, хэмжээг хуучин бол зөвхөн хот, суурины эдэлбэр газрын төлбөрийн хувь хэмжээг 2 дахин буюу 0.1-1-ийн хооронд буюу 10 нэгжийн хүрээнд Иргэдийн Төлөөлөгчийн хурал нэг тогтоодог. Бусад зохицуулалт дээр Засгийн газар татварын хуулиараа Засгийн газар тогтоох ийм эрх олгосон хуулийн зохицуулалттай байсан. Энэ удаа орж ирж байгаа Газрын төлбөрийн хуулийн онцлог нь бол Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулаад, Засгийн газар тогтоох биш, 10 нэгж байсан интервалыг 20 нэгжийн 2 дахин том тийм интервалын хүрээнд тухайн орон нутгийн буюу аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь өөрсдийнхөө нутаг дэвсгэрийн онцлог байдлаас шалтгаалж, харгалзан үзэж, газрын төлбөр тогтоох бололцоотой болгож ингэж хуулийн төсөл орж ирсэн.

Энэ нь болохоор нэгдүгээрт орон нутгийн 2020 оны 12 сард баталсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай уялдуулаад орон нутгийн эрх хэмжээг бас тодорхой түвшинд өргөжүүлж өгсөн ийм зарчим орж ирсэн. Энийг бид нар бол удаан хугацаанд бол санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулахтай ярилцаж байж энэ зарчим бол орж ирж, хэлэлцэгдэж байна.

Төрийн өмчийн газрыг дур мэдэн ашигласан тохиолдолд хариуцлага байгаа. Өөрөөр хэлэх юм бол тэрийг Газрын ерөнхий хуулийн төслөөр шууд хорьж байгаа. Хэрвээ ийм асуудал илэрсэн тохиолдолд тухайн орон нутгийн удирдлага шууд газрыг чөлөөлүүлэх арга хэмжээг авахаар. Ингээд энэ тохиолдолд нөгөө дур мэдэн ашигласан этгээд тухайн газар дээр учруулсан хохирол чөлөөлөхтэй холбоотой гарсан зардлыг бүрэн хариуцах ийм зохицуулалт орж ирсэн. Дээр нь Зөрчлийн хуульд бас бид нар тодорхой арга хэмжээ тусгахаар ингэж оруулж ирсэн

учраас ийм асуудлыг бүрэн шийдсэн гэж ойлгож болно.

Стандартын шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж барьсан бол төлбөрийг өсгөж тооцохоор орж ирсэн. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль дээр энэ заалт мөн үйлчлээд явж байдаг. Монгол Улсын нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдоод энэ зохицуулалт мөн энэ хуулийн төслөөр орж ирж байгаа гэдгийг бол бас хэлье. Манлай тэр ашигт малтмалтай холбоотой бусад асуудал дээр.

Г.Занданшатар: 85. Товч тодорхой хариулна шүү.

А.Энхманлай: Ганбаатар гишүүний асуултад хариулья. Энэ ашигт малтмалын зориулалтаар газар ашиглаж байгаа тохиолдолд энэ хуулиар бол 0.2-4 хувиар тооцож, орон нутгийн иргэдийн хурал нь шийдвэр гаргаж, ингэж газрын төлбөрийг тогтоохоор хуульчилж өгсөн. Энэ бол Кадастрын тухай хууль дээр бид бүхэн бол нэгж талбар бүрээр газрын үнэлгээг бүртгэнэ гээд заачихсан байгаа. Энэ нь бол нэгж талбар гэдэгт бол аль ч ангиллын газар, өөрөөр хэлбэл энэ ашигт малтмалын зориулалтаар ашиглаж байгаа газрууд бүгд хамаарагдаж байгаа гэж ойлгож болно.

Ер нь бол олон улсад бид бүхэн бас энэ олон улсын туршлагыг энэ Кадастрын хууль дээр аль болох ашиглах, энийг авч хэрэгжүүлэхээр ингэж зорьсон байгаа. Учир нь юу вэ гэвэл олон улсад мөрдөж байгаа газрын зах зээлийн үнийн аргаар энэ газрын үнэ, үнэлгээг зөв тооцож гаргах, мөн энэ газрын үнэлгээнд нөлөөлдөг хүчин зүйлүүдийг маш зөв тооцож гаргах ийм шаардлага байгаад байгаа. Энд бол бид бүхэн бол 2 агуулгаар авч үзэж болно. Байгаль, уур амьсгалын нөлөөлөлтэй хүчин зүйл дээр юу гэж тооцох юм бэ? Энд бол газрын гадаргуугийн налуужилт, газрын

чичирхийлэл цэвдэг, мөн газрын үржил шимтэй байдал, агаарын бохирдол, хөрсний бохирдол гээд ийм хүчин зүйлүүд хамаарч байгаа юм.

Нийгэм, эдийн засгийн хүчин зүйл гэж байгаа. Энд бол хүн амын тоо, боловсролын үйлчилгээний хүртээмж, эрүүл мэнд, төрийн үйлчилгээ, худалдаа үйлчилгээ, хамгийн гол нь байршилтай холбоотой асуудлууд байгаа. Тэгээд энэ нь хүчин зүйл нь бол 42 хүчин зүйлээс хамаарч байгаа. Энэ бол бас олон улсад мөрдөж байгаа хүчин зүйлүүд. Тэгээд энэ ажлыг хүний оролцоогүйгээр Камасистемээр хийнэ гэж байгаа. Энэ бол компьютерын тоног төхөөрөмжийг ашиглаад тухайн газраас тооцох үнэлгээг бүсчлэл нь өөрөө автоматаар гарна. Мөн үнэлгээнүүдийг нь заагаад өгчихөд саяын иргэдийн хурлынхаа тогтоолыг, итгэлцүүрийг оруулаад, газрынхаа суурь үнийг орлоод өгөхөд тухайн газарт тохирох газрын үнэ гарч ирнэ. Зах зээлийн үнээ бас энд цуг оруулж ингэж бодохоор зохицуулж олон улсын туршлагаудыг нэвтрүүлсэн.

Мөн цаашдаа газрын үүнийг олон нийтэд нээлттэй болгох бас олон улсын зарчмыг бас энэ хуулийн төсөлд орж ирсэн байгаа. Зарим улсууд бол ихэвчлэн газрын үнийг нээлттэй зарлах хууль гэж бүр тусдаа байдаг. Тэгэхээр энэ Кадастрын шинэ хууль маань батлагдсанаар газрын үнийг бид бүхэн хуулийн дагуу олон нийтэд нээлттэй зарлаж, энэ газрын үнээр зөвхөн төр газрын татвараа хураахаас гадна, бусад арилжаа, барьцаанд тавигдах. Мөн хамгийн гол бид нарын төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ болох нөхөн олговрын хэмжээг зөв тооцож гаргахад энэ хууль бас маш чухал хууль байгаа юм.

Тэгэхээр энэ хуулиараа бол олон асуудал, газрын үнэ, үнэлгээ, татвар хураамжтай холбоотой олон асуудал

шийдэгдэх ийм үндэслэл бүрдэх юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Нуршаад байх юм. Яг асуултад тодорхой дугараад, тодорхой хариулаад байхаач. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн. Түр байж байгаарай. Зочид танилцуулаадахъя.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Хүмүүнлэгийн ухааны сургуулийн багш, оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Хүндэт оюутнууд, багш та бүхэнд эрдмийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Би энэ хуулийг хэлэлцээд явах нь зөв гэдэг дээр байр суурь байгаа. Тэгэхдээ хэлэлцэх эсэх дээр бас тодруулаад асууж байгаа хэдэн асуулт маань. Би уг нь, мань мэт нь ерөнхий асуугаад, ард иргэдээ төлөөлж байгаа ард иргэдэд учирч байгаа зовлонг ярина. Та бүхэн их нарийвчилсан 6-гийн тэдийн тэд гэж яривал уг нь бол буян болно. Гэтэл мань мэт нь их тодорхой тэдийн тэд гэж асуугаад та нар маань их ерөнхий ярих юм. Тэгээд би асууж байгаа юм нь байна шүү дээ. 6.2-т хайх үйл ажиллагаа тусгасан байгааг анхаараач. Энэ дээр ашигт малтмалын хайгуул хийх газраас төлбөр авахгүй ийм утга санаа явчхаад байна. 6.2-ыг надад тайлбарлаж өгөөч л гэж хэлсэн.

Дараад нь Кадастрын тухай хуулийн төслийн 21 дээр ашигт малтмал хайх, ашиглах газрын зах зээлийн үнийн талаар яг тодорхой ингэж үнэлгээ авсан юм, ингэж үнээ бол тэгж тодорхойлж байгаа юм. Жорк үнэлгээгээр үнэлж байгаа юм гэдэг юм уу ийм юм тодорхой байвал их буян болно. Тэгээд.../минут дуусав./

Г.Занданшатар: Хэн хариулах уу? Тодорхой хариулахгүй бол хэрэггүй. Тэр

мэргэжилтэн хариул. Энхманлай тодорхой хариул л даа. Тэдийн тэд гээд асуугаад байхад, тэгээд тойроод л тэгэх гэж байгаа, нийгэм, эдийн засгийн хүчин зүйл энэ тэр гээд. 85. Энхманлай. Ажлаа мэддэг юм уу, мэддэггүй юм уу чи ер нь?

А.Энхманлай: Ганбаатар гишүүн асууж тодруулж хариулья. Энэ 6.2 дахь заалт бол газрын тос, уламжлалт бус газрын тос хайх, олборлох үйл ажиллагаа явуулж байгаа газрын төлбөрийг тогтоохдоо бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцөлийг баримтална гээд заачихсан байгаа. Өөрөөр хэлбэл энэ бол арай өөр зохицуулалт.

Өөрөөр хэлбэл ашигт малтмал биш. Энэ бол бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тусгайлсан энэ газрын тостой холбоотой үйл ажиллагааг олборлох, хайх ийм зорилгоор бол газрын төлбөрийг бүтээгдэхүүн хуваах гэрээний зарчмаар тогтооно гэж байгаа юм. Харин энэ 7.1.5-д заасан ашигт малтмал ашиглах зориулалттай газрын төлбөрийг бол иргэдийн хурал 0.2-4 хувиар тооцож, энэ газрын төлбөрийг тооцно гэж байгаа юм. Кадастрын тухай хуулийн 21 дүгээр зүйл дээр бол нэгж талбар бүрээр газрын зах зээлийн үнийг тогтооно гэж байгаа юм. Энэ нэгж талбар гэдэг нь тухайн олгогдсон газар орж байгаа юм. Тэрнээс биш зориулалтаас бол ер нь хамаарахгүй. Ашигт малтмал ч байсан адилхан. Мөн үйлчилгээ.../минут дуусав./

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Үнэхээр Газрын тухай хууль бол Үндсэн хуулийн дараа орох Монгол Улсын иргэн бүр өмчтэй байх, хөрөнгөтэй байх энэ асуудлыг шийдвэрлэсэн том хууль гэдгийг гишүүд бүгдээрээ хэлж байна. Би бас иргэн бүрд хамааралтай болов уу, иргэн бүр энэ

хариултыг хүлээж байгаа болов уу гэж бодсон хэд хэдэн асуултыг бас асууя гэж бодож байна. 2008 онд Монгол Улс иргэнд газар өмчлөх тухай хуультай болсноороо 0-18 хүртэлх насны бүх иргэн газартай болсон байдаг. Цахимаар газар эзэмших эрхээ авсан байдаг. Газар эзэмших гэрчилгээгээ гардан авсан байдаг.

Өнөөдрийн байдлаар яг Монгол Улсын нийт хэчнээн иргэн энэ хуулийн дагуу газар эзэмшиж байна вэ гэдэг асуулт байна. Энэ газар эзэмшиж байгаа иргэд энэ хууль батлагдсанаар ямарваа нэгэн газар эзэмшиж байгаа эрхэд нь өөрчлөлт орох уу, үгүй юу гэдэг асуултыг би асуумаар байна.

Өөрөөр хэлэх юм бол жишээ нь Бадарчийн Жаргалмаа гэдэг хүн Дундговь аймагт газар эзэмшиж болох тэр зохицуулалт ч гэсэн бас энэ хуулиар үүссэн байдаг. Тэгвэл одоо иргэдийн газар эзэмших эрх нь байгаа юу, үгүй юу? Эдгээр газар авсан иргэд маань газрын төлбөрөө хэрхэн яаж төлж байгаа вэ? Яг жишээ нь энэ жишгээр газар авсан иргэдийн маань газрын төлбөрийн асуудал хэрхэн яаж шийдэгдсэн байдаг юм? Хэрвээ өнөөдөр энэ иргэн газраа эзэмшээгүй байвал ямарваа нэгэн байдлаар улсад хураагдах энэ байдал үүсэх үү, үгүй юу? Монгол Улсын ямарваа нэгэн хууль иргэнээ хохироохгүй, эдийн засгийн ямар нэгэн хохирол учруулахгүйгээр үйлчлэх ёстой. Тэгвэл энэ хууль ямар өөрчлөлт орох вэ гэдэг зүйлийг асууя.

2021 онд өссөн дүнгээрээ 838 тэрбум 856 сая төгрөгийг улсын төсөвт газрын эзэмшсэн байдлаас шалтгаалан төвлөрүүлжээ. Тэгвэл энэ хууль батлагдсанаар улсын төсөвт бүрдүүлэх газрын төлбөрийн төлбөр, мөнгө ямарваа нэгэн байдлаар нэмэгдэх үү, үгүй юу гэдэг асуудлыг асууя.

Өнгөрсөн жилүүдэд Монгол Улс бас газрын нэгдсэн санг бүрдүүлж чадсан гэж тооцож байгаа, үзэж байгаа. Нэгдсэн сангийн бүрдүүлэлт ер нь ямар хэмжээнд байна? Энэ зөвхөн хөдөө орон нутаг дотор отрын, бэлчээрийн асуудал биш, Улаанбаатар хотод хүртэл орц, гарцын асуудлаар иргэн хоорондын маргаан үүссэн байх ийм нөхцөл байдал маш ихээр байдаг. Энэ асуудлыг газрын нөөцийн сан бүрдүүлж чадсанаараа бид шийдвэрлэж чадсан уу, үгүй юу? Яг Газрын төлбөрийн тухай хуулийг уншаад үзэхээр ямарваа нэгэн хариуцлагын тухай асуудал байхгүй. Шүүхээр шийдвэрлэ л гэсэн ийм зүйл, заалт байна. Хэрвээ газрын төлбөрөө ямарваа нэгэн байдлаар төлөөгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээх вэ гэдэг асуулт. Би шууд жишээн дээр ярья. Энэ “Нарс” зуслангаас надад бас ийм бичиг ирсэн байгаа.

Өөрөөр хэлэх юм бол Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулдаг хүүхдийн зуслан байгаа. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа явуулах ерөнхий шаардлагын, стандартын дагуу насанд хүрэгчдэд зориулсан үйлчилгээ, амралт сувиллын газар согтууруулах ундаагаар үйлчлэх цэг, салбар нь хүүхдийн амралт, зуслангийн хамгаалалтын бүсээс 500-аас доошгүй метр зайд байрлана гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллуулж байгаа цөөн зуслангуудын нэг. Одоо тэр “Нарс” зуслан ойн сан бүхий газар байрладаг тул газрын төлбөрийг 2 дахин нэмэгдүүлсэн дүнгээр хураалгана гэсэн ийм заалттай учраад төлбөрөө төлж чадахгүй, үйл ажиллагаагаа явуулж чадахгүй байна. Нийгмийн өмнө хариуцлагаа хүлээн хүүхдүүдийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулж байгаа биднийг энэ газрын төлбөрийн асуудлаас чөлөөлж өгөөч гэсэн нэг ийм хүсэлт удаа дараа ирж байгаа.

Одоо орж ирсэн Газрын төлбөрийн тухай хуулийн төслийн 9.1.1-д төрийн

болон орон нутгийн өмчийн бүх шатны боловсролын байгууллага, асрамжийн газрын үндсэн үйл ажиллагаа явуулах зориулалттай газарт ноогдох төлбөрийг 100 хувиар чөлөөлнө гэсэн ийм заалт орж ирж байна. Хүүхдийн зуслан үүнд хамаарах уу гэдэг асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: 85. Энхманлай.

А.Энхманлай: Жаргалмаа гишүүний асуултад хариулья. Газар өмчлүүлэх тухай хууль, мөн Газрын тухай хуулиуд хэрэгжиж эхлээд 20 гаруй жил болж байна. Энэ хугацаанд бол Монгол Улсын хэмжээнд нийтдээ 660 гаруй мянган иргэн газар өмчилж авсан. Мөн 486000 газар эзэмшиж байгаа, 6600 орчим бол газар ашиглаж байгаа гэсэн ийм нэгдсэн бүртгэл байгаа.

Тэгэхээр энэ Газрын тухай хуулиар бид бүхэн бол газрын төлбөр, одоогийн газрын төлбөр тооцож байгаа хэсгүүд дээр бол нийтдээ 158 тэрбум төгрөгийн газрын төлбөрийн ногдуулалтыг манай байгууллагаас үүсгээд ингээд 110 гаруй тэрбум төгрөгийн бол гүйцэтгэлтэй явагдаж байгаа.

Ер нь бол цаашдаа энэ хууль батлагдсанаар бид бүхэн 458 тэрбум төгрөгийн хүртэл дээд хэмжээг бол улсын төсөвт төвлөрүүлэх бол ийм боломж нөхцөл бол бүрдэж өгч байгаа.

Газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр бид нар газрын мэдээллийн санг бүрдүүлэх, газрын нэгдмэл санг бүрдүүлэх ажлыг бол газрын харилцааны холбогдолтой 7 программ хангамжийг байгуулаад энэ дээрээ бол энэ бүх мэдээллүүдийг бүрдүүлээд, удирдлага, зохион байгуулалт, мөн хууль хэрэгжүүлэх ажлыг бол хэрэгжүүлээд ажиллаж байна.

Газрын шинэ хууль хэрэгжсэнээрээ, газрын төлбөртэй холбоотой хууль

хэрэгжсэнээр тодорхой хариуцлагууд бол мэдээж хүлээгдэнэ. Энд бол ямар ч байсан газрын ногдуулалттай холбоотой маргаан гарах, хариуцлагын асуудал гарвал газрын асуудал эрхэлсэн энэ хуулийн дагуу Газрын маргаан таслах зөвлөлийн хүрээнд шийдэгдэнэ. Газрын төлбөр хураалт, төлөлттэй холбоотой маргаан үүсвэл энийг бол Татварын ерөнхий хуулийн дагуу бол холбогдох маргааныг бол шийдэхээр ингэж зохицуулсан.

Мөн газрын төлбөрөө 2 жилийн хугацаанд төлөөгүй байгаа тохиолдолд газрын эрхийг цуцлах талаар холбогдох, шийдвэр гаргасан субъектэд энэ Татварын ерөнхий газраас мэдэгдэл хүргүүлэхээр ингэж бас хуульчилсан байгаа.

Тэгэхээр бол энэний дараа бол мэдээж эрх нь цуцлагдахаар газар дээрх үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламжийг чөлөөлөх ийм харилцаа бол үргэлжлээд явагдана. Энэ асуудлуудтай холбоотой иргэдээс гомдолтой байгаа бол шүүхийн журмаар шийдвэрлэхээр ингэж хариуцлагын асуудлыг бол тусгаж өгсөн.

Сонгинохайрхан дүүрэг дээр байрлаж байгаа “Нарс” зуслангийн тухайд бол бидэнд бас гомдол ирсэн байгаа. Хуулийн төсөлтэй холбогдуулаад. Энэ хуулиар бол төрийн өмчийн зөвхөн сургууль, цэцэрлэг, орон нутгийн өмчийн мөн сургууль, цэцэрлэг, боловсролын байгууллагууд, хүүхдийн зуслан, асрамжийн газруудыг бол газрын төлбөрөөс 100 хувь чөлөөлж өгч байгаа.

Харин өмчийн хэлбэр нь хувийн болоод ирэх юм бол чөлөөлөгдөхгүйгээр ингэж зохицуулж өгсөн. Тэгэхээр бол энэ асуудлыг бол мэдээж цаашид хууль хэлэлцүүлэх шатанд бол мэдээж хэлэлцээд ингээд шийдэх бололцоотой асуудал гэж үзэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 81, Мөнхбаатар сайд хариулна.

Б.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүний асуулт бас нэмэлт мэдээлэл өгье. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 489000 иргэн, хуулийн этгээд 7.6 сая Га газрыг эзэмшиж байгаа. Өмчлөл бол 600 гаруй мянган иргэн газар өмчилж байгаа. Та газар өмчлөх эрхээ аваагүй бол Дундговь аймагт хуулийн дагуу бас хүсэлт өгөөд өмчлөх эрх нь бол нээлттэй байгаа.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Энэ хуулийг үзэл баримтлалын хувьд бол хэлэлцэхийг дэмжиж байгаа. Гурван асуулт байна.

Нэгт энэ газрын өмчлөлийн асуудал дээр энэ санал, гомдол их ирж байгаа. Иргэдээс. Тэгээд энэ хэлэлцүүлгийн хувьд бол иргэдээс аль хэр санал, гомдол, тэр нийтийн сонсгол хэдэн удаа хийсэн юм? Иргэдийн саналыг яаж тусгасан юм? Тодорхой тоо, хэдэн иргэдээс ямар санал, хүсэлтүүд ирсэн нь яаж тусгагдсан юм? Энэ дээр тодорхой тоо, баримт байна уу? Тодорхой юм байвал хэлээд өгөөрэй.

Хоёрт, энэ кадастрын зураглалаа бид нар бол Монгол Улс бол 100000-ны зураглалтай. 25000-ны зураглал бол талд нь бараг л хийгдсэн юм байна. Тэгэхээр энэ 100000-ны зураглал гэдэг бол алдаа гарах магадлал бол өндөртэй. Нэг алдаа гарах юм бол 10-15 метр ер нь алдаа гардаг ийм юм байна. Тэгэхлээр энэ зураглалаа сайн нарийсгаж, хийж авч байж бид нар энэ хуулийг хэрэгжүүлэхгүй бол. Ялангуяа энэ хотын төв, энэ өндөр үнэтэй энэ “А” зэрэглэлийн бүсэд бол 10,15 метрийн газрын маргаан гэдэг чинь бол том маргаан шүү дээ.

Тэгэхлээр энэ зураглал дээр анхаарч энэ кадастрын зураглалаа нарийсгаж

25000-ны зураглал гүйцэд хийх тал дээр энэ ямар ажил хийгдэх юм? Энэ хууль хэрэгжээд эхлэхэд энэ хууль, энэ кадастрын 25000-ныхаа зураглалаар хийгээд дуусчихсан байх юм уу? Энийгээ яаж төлөвлөж байгаа юм бол гэж.

Гуравдугаарт, энэ тусгай хамгаалалттай, дархан цаазтай газрын энэ ашиглалт бол замаа алдсан байгаа шүү дээ. Ялангуяа энэ Богдхан уулаа бид нар чинь хамгийн эртний л дархан цаазтай газар гээд байдаг. Энэ дээр ялангуяа энэ парк тэр олон нийтийн зориулалттай ашиглах тэр ашиглалт дээр бол гаднын байгууллагуудтай хамтарч ажиллаж байгаа. Их Хурлын хувьд бол, миний хувьд бол энэ байгаль хамгаалах консерваци бүлгийг ахалж байгаа. Тэгээд энэний хүрээнд бол бид нар энэ “Ай Си Си Эф” гээд олон улсын байгууллага эд нараас мэргэжилтнүүд авчраад энэ Улаанбаатар хот руу хамтраад энэ Богд уул, Байгаль орчны яамтай хамтраад энэ Богдхан уулын ашиглалтыг, үүний менежментийг сайжруулах тал дээр ажиллаж байгаа юм. Тэгээд тэд нарын гаднын мэргэжилтнүүдийн бас энэ Богд уулын ашиглалтыг харчхаад, өнөөгийн нөхцөл байдлыг харчхаад толгой сэгсрээд. Энэ дархан цаазтай уулыг ингэж ашиглах гэж дээ.

Цаашдаа ер нь энэ чинь бид нар цаашид яаж, ямар бодлоготой явах юм? Энэ тал дээр, газар ашиглалтын тал дээр яаж анхаарах юм гээд санал, бодол илэрхийлээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр цаашид энэ хууль зөрчөөд явчихсан юмнууд байдаг бол энэ хууль гарснаар энэ чиглэл рүү энийг засаж залруулах, сайжруулах чиглэлээр ямар ажлууд хийгдэх юм гэсэн ийм 3 тодорхой асуулт байна.

Г.Занданшатар: 83, Санадгийн Магнайсүрэн.

С.Магнайсүрэн: Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яам Магнайсүрэн. Газар өмчлөлтэй холбоотой асуудал, энэ 5 багц хуулийн хүрээнд Газар өмчлөлийн тухай хуулийн төсөл цуг орж ирж байгаа. Сая өнөөдөр хэлэлцэх эсэхийг нь шийдчихлээ. Ер нь бол иргэн, гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн зориулалтаар, 2 зориулалтаар өмчилж байсан. Бид аж ахуйн зориулалтыг нь болиулж, гэр бүлийн хэрэгцээнд нь оруулна. Тэгээд Монгол Улсын иргэн 18 насанд хүрч байж өмчлөхөөр ийм шинэ концепц орж ирсэн. Гол нь өмчилсөн газар нь хот, суурины эдэлбэр газар байх ёстой.

Хоёрдугаарт, инженерийн дэд бүтэц бүхий төлөвлөлттэй газар л өмчлүүлье. Тэгээд тэрийгээ эдийн засгийн эргэлтэд оруулах тэр бололцоонуудыг нь Газрын ерөнхий хууль болон Өмчлөлийн хуультайгаа уялдуулж ингэж шууд, шуурхай шийдвэрлэхээр хамгийн дээд тал нь бид нар 30 хоногийн дотор Жишээлбэл, өмчилсөн газраа зориулалтыг нь өөрчлөөд, тухайн бүсчлэлийн дүрэмд нийцүүлэн ашиглана гэхэд болохоор ингэж бид нар хуулийн төсөл оруулж ирсэн. Энэ хуулийн төслүүдийг бид нар жил гаруй хугацаанд хэлэлцсэн. Олон нийтийн дунд ч бид нар зохион байгуулалт хийсэн.

Ер нь бол нийт 21 аймгийн хэмжээнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хариуцаад сумуудаараа хэлэлцүүлэг хийгээд, манай хариуцсан агентлаг зохион байгуулалтад оролцоод хэлэлцүүлгүүд хийсэн. Манай яам бол аймгуудын дунд бүсчилж хийгээд, дээр нь төвд бол бүх яамд, төрийн бус байгууллагууд, эрдэмтэн, судлаачдын хүрээнд хэлэлцүүлгүүд хийсэн. Энэ хэлэлцүүлгийн дүнг үзэх юм бол зарим аймгуудад 5, 6 удаа ингэж сумдаа бүсчилж хийсэн байна лээ. Хамгийн доод тал нь 2-3 удаа хийсэн байна лээ. Ингээд нийт тоон мэдээг нь авч үзэх юм 40 орчим мянган

иргэн оролцсон. Тэр хэлэлцүүлгүүдэд. Бидний төвд хийсэн хэлэлцүүлэг дээр 3000 орчим хүн оролцсон.

Санал бол бид нар 2000 гаруй саналаас яг хуулийн төслүүддээ суулгасан саналыг бол бид нар 450 саналыг бол авч суулгасан. Ихэнх саналууд бол туссан, зарим нь бол давхцаж байсан ийм саналууд байсан. Цахимаар болон бусад хэлбэрээр бид нар хангалттай саналыг авч, ингэж оруулж ирсэн гэж ойлгож болно.

Өнөөдрийн байдлаар бид нар 25000-ны зураглалыг бүрэн хийж чадаагүй байж байгаа. Сүүлийн 2, 3 жил бид нар улсын төсөв дээр төсвийн эх үүсвэрийн хомсдолоос болоод энийг шийдэж чадахгүй байгаа. Ер нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад бодлогын баримт бичгүүдэд бол 100 хувь 25000-ны зураглалтай зургийг хийлгэнэ, хангана гээд орчихсон. Тэгээд бид нар өнөөдөр хараахан шийдэж чадаагүй явж байгаа.

Бас гаднын зээл тусламж гээд ярихаар бид нар бас Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр бас танилцуулаад зарим талаар энийг өөрсдийн төсвөөр, өөрсдийн хүч хөрөнгөөр хийх нь зүйтэй гэсэн ийм чиглэл авсан учраас бүрэн хийж чадаагүй. Сүүлийн 2, 3 жил энэ зорилго маань тасалдаад өдийг хүрсэн.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай асуудал дээр Газрын ерөнхий хуульд зааснаар Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн төсөл удахгүй орж ирнэ. Ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанаар орно гэж мэдээлэлтэй байгаа. Энэ орж ирж байгаад манай хуулийн төслийн хэлэлцүүлэг, ажлын хэсэг дээр ажиллаж байх явцад цогцоороо орж ирж байж энэ бол бүрэн болно гэсэн ийм саналууд Байнгын хорооны гишүүд Байнгын хороон дээр олон гарсан. Энийг өмнөх хурал дээр Байгаль орчны сайд ойрын хугацаанд оруулж ирнэ гэсэн. Хууль

зүйн сайд болоод Барилга, хот байгуулалтын сайд, Байгаль орчны сайд 3 хамтраад үзэл баримтлалыг нь батлаад эхний төслүүд бэлэн болсон байж байгаа. Энэ ойрын хугацаанд орж ирнэ.

Ер нь зүгээр тоон товч мэдээ хэлэх юм бол 4953 нэгж талбар энэ тусгай хамгаалалттай газар нутагт нийт байгаа юм. Ингээд 43 тэрбум төгрөгийн төлбөр ноогдуулаад, 15 орчим тэрбум төгрөг төлөгддөг юм байна лээ. Гүйцэтгэлээр нь харах юм бол. Одоо манай төслөөр бол доод тал нь 4.3 тэрбум, дээд тал нь 86.4 тэрбум төгрөгийн төлбөр ноогдохоор бид нар ийм төсөл орж ирсэн байгаа. Тэгээд нөгөө интервалын.../минут дуусав./

Г.Занданшатар: Одоо Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асуулт асууна.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Газрын тухай хууль, тэр дотор энэ Газрын төлбөрийн хууль бол бас Монгол Улсын эдийн засгийн эргэлт, тэгээд хүн амын нийгмийн харилцааны гол хуулиудын нэг. Энэ хууль дээр манай Улаанбаатар хотын гишүүд бидний хувьд бас бас анхаарал тавин хэлэх чухал зүйлүүд байгаа юм.

Өнөөдөр бид нар эмнэлэг, сургууль, цэцэрлэг зэрэг нийтийн зориулалттай байгууламжууд, тэдгээрийн хөрөнгө оруулалтыг хийхээр төсөл, санал оруулж байгаа ч Улаанбаатарт нийтийн эзэмшлийн 1 ч газар байхгүй байгаа. Өнгөрсөн жилүүдэд хэн нэгэн эрхтэн дархтан, эсвэл хэн нэгний буруу шийдвэрийн улмаас Улаанбаатарын бүх газар цөөнхийн гарт нэгэнт оччихсон байгаа. Компаниуд, эсвэл цөөхөн хувь хүмүүс. Тэгэхээр энэ байдлыг бид нар арилгах ёстой. Ерөөсөө Монголын нийгэм дэх баялаг, эдийн засгийн болон бусад баялгууд бол маш шударга бус хуваарилагдсан. Тэгш бус байдал гүнзгийрч байна. Улаанбаатар хотод хүн амын төвлөрөл өндөр байгаа ч бид нар

нийтийн зориулалттай байшин, барилга барих боломжгүй болчихоод байна.

Тийм учраас газрын төлбөрийг мөн Газар өмчлөлийн хуулийг яах аргагүй эргэн харах шаардлагатай. Тийм учраас энэ хуулийн төслийг бол үзэл баримтлалыг дэмжиж байна. Тэгэхдээ бас энэ асуудлууд байна. Энэ газрын төлбөрийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний өмчлөх эрх, бусад эзэмших, ашиглах эрхтэй холбогдуулан тодорхой хэмжээгээр өөрчлөх шаардлагатай.

Тухайлбал, иргэнд иргэний хувийн өмчийн хэрэгцээний газруудын төлбөрийг нэмэхгүйгээр гэдэг юм уу. Тухайн улсын хэмжээнд газар эзэмшигч, ашиглагч компаниудын төлбөрийг нэмэх ийм боломж байна уу, үгүй юу? Өөрөөр хэлбэл, газрын төлбөрийг шударга хуваарилах. Нэгэнт иргэдийн маань 600 орчим мянган иргэн л газраа өмчлөөд авчихсан байна. Бусад иргэд бол газраа өмчилж аваагүй байна.

Гэтэл одоо энэ бид нарт байгаа 2021 оны дүнгээр бол нийтдээ 486000 газар эзэмшигч компаниуд байна. 2232 ашиглагч нар байна. Эд нарын газрын эзэмшиж байгаа төлбөрийг нэмэх шаардлагатай. Ингэж байж бид нар нийгмийн шударга, тэгш байдлыг дэмжих гээд байна. Ингэж байж Монгол Улсын эдийн засагт газрын үр шимээс хөрөнгө төсөв орж ирнэ. Тийм учраас энэ хуулийн төсөлдөө газрын төлбөрийг шударга, хүртээмжтэй байлгах, нийгмийн шударга ёсны үүднээс нэмэх тухайд, зохицуулах тухайд ямар дэвшилттэй заалт орж байгаа юм бэ?

Хоёрдугаарт нь түрүүн Ганбаатар гишүүн асуугаад бас хариулт нь тодорхойгүй байгаад байна. Энэ газрын төлбөр тогтоох асуудлыг яагаад орон нутагт нь өгч байгаа юм бэ? Монгол Улс бол нэгдмэл улс. Монгол Улсын нэгдмэл байдлыг хэмжих, нэгдмэл байдал, аюулгүй

байдлын гол нэг асуудал бол яах аргагүй газар байдаг. Тэгэхээр газар өмчлөлийн болон төлбөрийн хуулиуд дээр энэ орон нутагт эрх мэдэл өгч байгаа нь ямар үндэслэл, концепцоор ингэж өгч байгаа юм бэ? Тэгэхээр аймгуудад өгөхөөр энэ аймгуудын газрын юу. Тэгээд тухайн аймгийн эдийн засгийн онцлог, уул уурхайтай эсэхээс хамаараад маш ийм ялгаатай байдал үүсэх юм биш үү? Энэ дээр Монгол Улсын тэр нэгдсэн бодлого зөв, нэгдмэл байх ёстой гэдэг тал дээр энэ хууль санаачлагчийн зүгээс ямар байр сууриа илэрхийлж байгаа юм бэ?

Дараагийнх нь Монгол Улсын Үндсэн хуулийн 6.4 дээр төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэж, тухайн газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлсөн байдлаар ашиглах юм бол хурааж авна гэсэн заалт байдаг. Тэгвэл энэ газрын төлбөрийн хууль болон газар өмчлөлийн хуулиудаар газар өмчлөгч болон ашиглагч иргэд, аж ахуй нэгжид ямар үүрэг хариуцлага ноогдуулж байгаа вэ? Нийтийн сайн сайхны төлөө тухайн газрыг ашиглахтай холбоотойгоор үүргүүдийг ер нь ноогдуулж байгаа юу, үгүй юу? Эдгээр асуултыг хууль санаачлагчаас асууя.

Г.Занданшатар: 83 Сандагийн Магнайсүрэн. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

С.Магнайсүрэн: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья. Барилга, хот байгуулалтын яамны Магнайсүрэн. Улаанбаатар хотын газрын төлбөрийн асуудал эрс, ер нь бол өөр болно гэж ойлгож болно. 2018 онд Засгийн газрын тогтоолоор бид нар суурь үнэлгээг нь тогтоосон. Хуучин бол бүсгүй. Энэ Улаанбаатар хот дангаараа 1 тойрог байсан бол одоо 16 тойрог болоод, 16 тойрог дээрээ гэр бүлийн хамтын хэрэгцээнд нь ямар байх вэ, 1 дүгээр тойрогт нь ямар байх вэ, 16 дугаар тойрогт ямар байх вэ?

Жишээлбэл би 1 дүгээр тойргийг нь авч үзэх юм бол 1 метр квадрат газрын үнэ бол Улаанбаатар хотын бүсийн 1 дүгээр тойрогт бол 81800 1 метр квадрат. Тэгээд нөгөө 01-2 хувиараа тооцохоор зэрэг хамгийн багадаа 81 төгрөг, дээд тал нь 1636 төгрөг. Ер нь бол зүгээр гэр бүлийн хэрэгцээний газрууд бол төлбөрөөс чөлөөлөгдөж байгаа. Ногдуулалтын байдал нь бол ийм байгаа юм.

Тэгээд төсөвт байгууллага, нийтийн зориулалттай орон сууц, худалдаа үйлчилгээ гээд 16 төрлөөр ноогдуулж байгаа нь газрын төлбөр оновчтой, тухайн асуудал газар дээрээ бодитой болсон гэж ингэж үзэх бүрэн бололцоотой гэж ойлгож болно. Орон нутагт ингээд газрын төлбөрийн хуулиар бид нар 10 төрөл, 10 чиглэлээр газрын төлбөрөө ноогдуулаад, интервалыг нь өсгөөд, тэгээд энэ интервалыг хуульчилж өгөөд, энэ хүрээнд нь аймаг, Нийслэлийн засаг дарга өөрийнхөө орон нутаг дээр газрын төлбөрөө тогтоох ийм эрхийг бол өгсөн. Энийг бол Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль шинэчлэн батлагдаж батлагдсан. Үүн дээр орон нутгийн төсөв, албан татвар, төлбөр хураамжийн асуудлыг орон нутгийн чиг үүрэгт хамааруулж өгсөнтэй уялдуулсан.

Дээр нь тухайн орон нутаг төсөв бүрдүүлэхтэй холбогдуулаад энэ эрхээ нөхцөл байдлаасаа уялдуулаад шийдвэрлэх тэр өргөн боломжийг нь бол олгож өгье гэсэн ийм төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үндсэн санал яваад, тэгээд бид нар энэ дээр зөвшилцөөд ер нь шинэ хуулийн концепцын шинэ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Нийслэлийн эрх зүйн байдлын хууль болоод Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийн энэ концепцын хүрээнд энэ бололцоо, боломжтой гэж үзэж, ингэж оруулж ирсэн байж байгаа юм.

Газрыг хурааж авах зохицуулалтууд бол бий. Жишээлбэл, төлбөр дээр бол 2 жил дараалаад энэ төлбөрийн өртэй, тэрийгээ төлөөгүй бол хариуцлага хүлээхээр орж ирсэн. Газрын ерөнхий хуульд энэ зохицуулалтыг оруулж өгсөн. Ер нь бол Газрын ерөнхий хуулиар энэ газрыг хязгаарлагдмал эрхээр ашиглаж байгаа болон газар ашиглагч этгээдийн үүрэг хариуцлагыг нэлээн тодорхой тусгаж өгсөн. Шаардлагатай бол бид нар газрын энэ багц хуулиар болон Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр ийм зохицуулалтуудыг оруулж ирсэн байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. “Парламентын боловсрол” хөтөлбөрийн хүрээнд Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газрын ажилтнуудын хүүхдүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүндэт хүүхдүүд та бүхэндээ сурлагын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүдийн өмнөөс.

Асуулт, хариулт болчихсон тийм ээ? Хариулт болчихсон уу? Одоо Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Газрын төлбөрийн хуулийг үзэл баримтлалынх нь хувьд бол дэмжиж байгаа. Хэд хэдэн асууж тодруулах зүйлүүд байна. Газрын үнэлгээнд чинь ер нь өөрчлөлт орох юм уу гэдэг асуудал нэгдүгээрт байна. Та нар 10 мужлалыг 20 болголоо гэж яригдаж байна. Энэ ер нь ямархуу байдалтай томъёологдож хийгдэв гэдэг асуудал байгаад байна гэж.

Ер нь бол газар ч тэр, хүн ам ч тэр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хуваагдаж байгаа. Тийм учраас энэ Засаг

засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчилж батлахдаа биднүүс сумыг ер нь засаг захиргааны үндсэн нэгж нь байх юм гэж үзэж, тэрийг эдийн засгийнх нь хувьд, үйлчилгээнийх нь хувьд нэлээн чадавхжуулах ийм бодлого бариад, энэ газрын төлбөрийг сумын төсөвт ордог байхаар зохицуулалт юмнуудыг нь дагасан хуулиар нь хийчихсэн. Энэ газрын төлбөрийн орлого бол яах аргагүй орон нутгийн төсвийн орлого.

Тийм учраас одоо энэ газрын төлбөрийн хуулиар маш олон хөнгөлөлт ороод ирчихжээ. Тэгэхээр энэ хөнгөлөлтүүдийг төвлөрсөн төсвөөс орон нутгийн төсөвт өгөх юм уу? 5 жил 100 хувь чөлөөлөөд, 5 жил 50 хувь чөлөөлөөд ингээд явна гээд байна. Энэ чинь орон нутгийн эдийн засгийн чадамжийг тодорхой хугацаанд бас идэвхжүүлж чадахгүй барьчих гээд байгаа нэг ийм асуудал харагдаад байх юм. Энэ үүнийг юу гэж ойлгож байна вэ гэж нэг ийм зүйл.

Хоёр дахь зүйл зам шугам сүлжээний хийгээд ашигт малтмалын газрын чинь төлбөрийн интервал дэндүү хол уу? 0.2-4 хувь ч гэж байх шиг. 1500-15000 ч гэж байх шиг. Тэгэхээр үүнийг ер нь та нар яаж ойлгож энэ интервалыг хийв гэдэг энэ асуудал байна.

Дараагийн асуудал энэ ашигт малтмалын олборлох, ашиглах бүхий газар гэж яриад байх юм. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайд нь ногдуулдаг ийм хэлбэрээр ямар ч эргэлзээгүй энэ хуульдаа оруулах бололцоо байгаа юу? Үүнийг юу гэж ойлгож байна вэ? Ашигт малтмалын төрлөөс хамаарсан төлбөрийн хувь хэмжээ, интервал байж болох уу? Орон нутаг, эрх мэдлээ хэрэгжүүлэх гэхээр зэрэг ашигт малтмалын газар гэсэн ганцхан зүйлээр л яригдаж байгаа. Тэрнээс нүүрснийх үү,

алтных уу гэдэг асуудал байхгүй болчихоод байгаа байхгүй юу.

Гэтэл наад эрчим хүчний нүүрсийг чинь бодоод газрын төлбөр ногдуулахаар бага ногдуулсаар санагдаад байдаг. Алтыг нь бодохоор зэрэг ахиу тавимаар санагдаад байдаг. Ингээд орон нутгууд чинь бас нэлээн тийм дундыг харсан хувилбар буюу боломжоо алдаад байгаа ийм зүйлүүд байгаад байгаа юм. Энийг та бүхэн юу гэж харж байна вэ гэж? Уул нь өмнөх төлбөрийн хууль юмнуудад хамгийн ойр хот тосгоны газрын төлбөрөөс хэд дахин гэдэг юм явдаг байсан юм.

Тусгай хамгаалалттай газар нутаг дээр чинь ч, ашигт малтмалын газрын төлбөр дээр чинь ч. Одоо тийм юм байхгүй. Тэгэхээр зэрэг мужлал нь мэдээж алслагдаад явчихаар зэрэг үнэ нь багасаж байх ёстой. Газрын суурь үнэлгээ чинь. Энэнээс нь бодолт, тооцолт хийхээр зэрэг би наад газрын төлбөр дээр чинь зарим газрууд дээрээ бууралт үүсгэх гээд байгаа юм биш биз дээ? Дам дамаа энэ ашигт малтмалын газар, наад тусгай хамгаалалттай газар нутгууд энэ тэр дээр чинь хамгийн ойр тэр хот, тосгоны газрын үнэлгээгээр нь тооцдог аргачлал юмаар бодох бололцоо бий юу? Эсвэл та нар энэ 2 тохиолдлоо өндөрсгөж, үнэлгээ тооцсон асуудал байна уу? Үүн дээрээ нэг хариулт өгөөч гэдэг ийм зүйл байна.

Энэ төлбөрийн хууль унш .../минут дуусав./

Г.Занданшатар: 83, Сандагийн Магнайсүрэн Барилга хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

С.Магнайсүрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ газрын үнэлгээний бид удаан хугацаа, 10 гаруй жил энэ газрын үнэлгээ, суурь үнэлгээ, бүсчлэлийг шинэчлээгүй байж байгаа. 2018 онд Засгийн газрын тогтоолоор 16 бүс бүс

болгоод, хөдөө аж ахуйн ангиллын газар бол бүр 31 тойрогтойгоор ингэж бүсчилж, шинэчилж тогтоосон. Энэ бүсчлэл суурь үнэлгээнээс төлбөрийн интервалыг тооцож, интервалаар тодорхой тогтоож, тооцох учраас бүсээсээ хамаараад төлбөрийн ногдуулалт янз бүр болж байгаа юм. Жишээлбэл, Улаанбаатар хот бол 1 дүгээр бүсэд өөр, бүр зах руу өөр тийм ээ? Энэ бол тогтоогдсон.

Тэгээд бид нар Кадастрын хуулийн төсөл дээрээ оруулж ирэхдээ 3 жил тутам энэ юугаа шинэчилж байя. Өөрөөр хэлэх юм бол Газрын ерөнхий хуульд заасан мэдээллийн системийн мэдээлэлдээ үндэслээд хот суурин газарт 3 жил тутам, бусад суурин, бусад газарт нь 5 жил тутам шинэчилж байя гэдэг ийм юуг хуульчилж оруулж ирж байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Газрын төлбөрийн орлого бол бид тооцож үзэхэд ямар ч тохиолдолд орон нутагт дунджаар авч үзэхэд бараг нэлээд нэмэгдэж байгаа. Ер нь зүгээр саяын таны хэлдгээр ямар байдлаар тогтоох вэ гэдгийг бол орон нутаг өөрөө нөгөө бүсчлэлээс, тойргоос нь хамааруулж ингэж ногдуулалт нь ноогдож байгаа учраас тэрийгээ бодож орон нутаг тогтоох эрх нь байгаа юм.

Тэгээд саяын таны хэлдгээр ашигт малтмал, зам, шугам сүлжээний газрыг өндөр тогтоодог нь орон нутагт л эрхийг нь өргөн л олгосон ийм л концепц. Орлогоо тооцно, бүсчлэлээ тооцно, аж ахуйн нэгжийнхээ тоог, нэгж талбарынхаа хэмжээ энэ тэр гээд бүх зүйлийг тооцож байх учраас энэ концепцыг л орон нутагт өөрөө асуудлаа шийдэх. Дээр нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн шинэ хүчин төгөлдөр үйлчилж байгаа шинэ хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын хууль эд нартай уялдуулж ингэж оруулж ирсэн ийм зохицуулалт байгаа юм.

Ашигт малтмалтай холбоотой асуудлаар ер нь хайгуулын лиценз бол лицензийнхээ төлбөрөөр явна. Хайгуулын лицензтэй талбайд бол бид нар тэр гэрээ бол хийхгүй байгаа.

Ашигт малтмал ашиглах лиценз авсан тохиолдолд тодорхой хугацааны дараа Газрын ерөнхий хуулийн төслөөр 30 хоногийн дотор тухайн орон нутагтаа хандаад, тэгээд ашиглах гэрээгээ байгуулж байгаа. Энэ тохиолдолд таны яг түрүүний хэлсэнчлэн өөр зохицуулалттай. Хамгийн ойрхон хот, сууринаар нь ингэж тооцдог байсан тооцооллыг нь Сангийн яамтай ярьж байгаад өөрчилж ингэж орж ирсэн.

Өнөөдрийн байдлаар улсын төсөвт бол нэг 27.7 тэрбум төгрөг өнөөдрийн хүчин төгөлдөр хуулиар 2 дахин нэмэгдүүлж ингэж олгодог байсан. Төлөлт нь 25.5 тэрбум төгрөг ордог юм байна лээ. Арай бага тасалддаг нь энэ ашигт малтмалын юу юм билээ. Одоо хүчин төгөлдөр бид нарын оруулж ирж байгаа төслөөр болохоор зэрэг дээд тал нь 96.8 тэрбум төгрөг орно гэж тооцож байгаа. 4-өөр тооцвол. Хамгийн доод тал нь 0.2-оор тооцвол 3.3 тэрбум төгрөг орно гэж ингэж тооцож байгаа.

Ер нь ямар ч тохиолдолд орон нутагт энэ хөнгөлөлт, чөлөөлөлтөөс гадна саяын орлогуудыг тооцоод үзэхэд л орон нутагт бид нар бололцоотой нэмэгдэнэ гэсэн ийм тооцоолол хийсэн. Нарийн тооцооллыг бас Сангийн яамнаас бас тодруулж хэлэх байх.

Г.Занданшатар: 85.

А.Энхманлай: Батжаргал гишүүний асуултад тодруулж хариулъя. Ашигт малтмалын зориулалтаар газар ашиглаж байгаа тохиолдолд газрын төлбөрийг бид бүхэнд тооцох итгэлцүүрийг тогтоож өгч байгаа. Энэ итгэлцүүр бол өмнө нь бол

0.1-1 хувийн хооронд орон нутгийн иргэдийн хурал тогтоохоор байсан. Одоо бол 0.2-4 хувь гээд 4 дахин өсчөж байгаа юм. Энэ итгэлцүүл дотроо орон нутаг маань өөрөө алт бол 4 хувиар байдаг юм уу? Өөр бусад төрлийн ашигт малтмалууд байвал 0.1 хувиар тогтоох эрхийг нь нээгээд өгчөж байгаа юм.

Өөрөөр хэлбэл дотроо бүсчлэлээ өөрсдөө баталж байгаа. Бүсчлэл дээрээ харж байгаад аль бүс нутгаас нь ямар төрлийн ашигт малтмал олборлодог юм, тэндээс ямар хэмжээний ашиг олдгийг харж байгаад орон нутагт нь ийм давуу байдал, эрхийг бол олгож өгсөн.

Манай систем дээр бол энийг зах зээлийнх нь үнэ, тухайн газраас олж байгаа ашгийг нь гаргаад, зурагжуулаад, бүсчлэлийг нь гаргачихсан. Энийг өөрсдөө ашиглаж болно. Өөрсдөө бас дотооддоо орон нутаг болон өөрийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй байдаг учраас орон нутагт энэ эрхийг нь бол өгсөн. Тэгээд хязгаар нь бол энэ 0.2-4 хувь хүртэл итгэлцүүрийг өөрчилж болно.

Үндсэн суурь үнийг бол Засгийн газраас 3 жил тутам шинэчилж өгөөд байхаар ингэж хуульчилсан байгаа юм.

Г.Занданшатар: Болсон уу Батжаргал гишүүн? Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ хууль бас давуу юм байгаад байгаа юм. Уул нь хуучин хуульд байдаг байсан. Гэхдээ бид зам, шугам сүлжээний газраас нэг ч төлбөр авч байгаагүй. Яг үнэнийг хэлэхэд. Одоо үүнийг авах нь. Орон нутгийн төсөвт орж байгаа учраас. Тийм учраас энэ цаад байгууллагуудынхаа төсөв тал дээр нь суулгах, барих юмнуудаа улсын хэмжээнд нэгдсэн бодлогоор зохицуулж үүргээ хүлээх ёстой шүү. Тэгээд нэг хэсэг нь худлаа, үнэн яриад төлбөр төлдөггүй явдал

бол байгаад байдаг. Наад ашигт малтмалын төрлөөс хамаарсан татвар, газрын төлбөр ногдуулах эрх чинь орон нутагт үүсэж өгөхгүй байгаа.

Ашигт малтмалын газар гэсэн энэ л ангиллаараа явах ёстой. Тэрнээс алт уу, нүүр үү, жонш уу гэдгээр тооцогддог юм байхгүй байгаад байгаа юм. Энэ хуульдаа наадхыгаа харин хэлэлцүүлгийн явцад тодотгож өгөх хэрэгтэй. 1 өгүүлбэр юмаар гэж. Энэ хуулийг уншиж явсан чинь тэр биднүүсийн ярьж заншсанаар бол эзэмшүүлсэн газрын, гэр бүлийн хэрэгцээнд нь өмчлүүлсэн газрыг төлбөрөөс чөлөөлж байгаа юм уу?

Г.Занданшатар: 83 Сандагийн Магнайсүрэн.

С.Магнайсүрэн Батжаргал гишүүний асуултад тодруулж хариулья. Барилга, хот байгуулалтын Магнайсүрэн. Гэр бүлийн хэрэгцээний газар чөлөөлөгдөж байгаа. 07, 035, 05 сумд, өрх энэ газрууд. Дээр нь өмчилсөн газар. Өмчилсөн газар бол төлбөрийн зохицуулалтад орохгүй. Энэ үл хөдлөх хөрөнгө гээд татварын зохицуулалтад орж байгаа. Зам, шугам сүлжээтэй холбоотой асуудлаар ер нь мэдээллийн санд бүртгэл ер нь тааруудуу байдаг юм байна лээ. Энийг бид нар бүрэн бүртгэлтэй мэдээллийн сандаа бүрэн авна гэж тооцож байгаа. Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар 43 сая төгрөг л улсын төсөвт ноогддог юм байна лээ. Бид нар зам, шугам сүлжээний газраа бүрэн мэдээллийн санд бүртгэж авна гэж тооцоолол тооцоод, энийгээ тооцоолоод өнөөдрийн оруулж ирж байгаа төслөөрөө үзэх юм бол хамгийн багадаа 40.8 сая төгрөг. Ихдээ.../минут дуусав./

Г.Занданшатар: Тэгээд ер нь энэ Мөнхбаатар сайдаа, Магнайсүрэн даргаа энэ Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуульд энэ төвлөрлийг сааруулах,

түгжрэлийг бууруулах энэ засаг төрийн бодлого яаж шингээсэн бэ? Үл хөдлөх хөрөнгийн татвар, газрын төлбөрийн хувь хэмжээ чинь олон улсын жишгээр бол энэ төвлөрлийг сааруулдаг хамгийн гол механизм шүү дээ. Тэгээд газрын харилцааны асуудлаар. 1.5 сая километр хавтгай дөрвөлжин газар нутагтай мөртөө Улаанбаатарт дах хүн амын бараг тал хувь нь шахцалдаад, түгжрээд, төвлөрөөд байгаа чинь энэ газрын харилцаатай, Улаанбаатар хотын газар зохион байгуулалт, газрын наймаа, хариуцлагагүй бүх ажилтай салшгүй холбоотой шүү дээ. Энийг яаж зохицуулах юм? Газрын хуулиар? Энэ юмыг л өдөржин, 2 өдөржин, 3 өдөржин гишүүд асуугаад байгаа. Бусад хотуудад хотын төвийн газрын төлбөрийн хэмжээ ямар байна? Нийслэл хотын төлбөрийн хэмжээ ямар байх ёстой юм? Тэгээд иргэдийн төлөөлөгчдийн хурал дунд нь хаяад ингээд ийм гэнэт сэрсэн юм шиг л юм болчхоод байна шүү дээ энэ чинь. 81. Их Хурал шийд гээд хаячхаж байгаа юм уу? Сүхбаатар сайдаас санал авсан юм уу? 81, Бэгзжавын Мөнхбаатар сайд хариулна.

Б.Мөнхбаатар: Их Хурлын даргаа асуултад хариулья. Ер нь бол бидний барьсан юм бол саяын шинээр хийсэн шугам сүлжээнд л үндсэндээ мэдээ мэдээллийн нэгдсэн санд бүртгэгддэггүй байгаад байдаг байсан. Тэгэхээр Улаанбаатар хотод ингээд шугам сүлжээ өөрийн бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгаа шугам сүлжээг нэгдсэн бүртгэлтэй болж мөнгө авна гэдэг бол ер нь цаад утгаараа Улаанбаатар хотыг үнэтэй л болгоё л гэж байгаа юм. Бүсчлэлийг гаргаж ирж, 1 дүгээр бүсээс нь илүү өртөг, хамгийн захын бүс рүү нь бага өртөгтэй байлгана гэдэг бол Улаанбаатар хотыг ер нь цаанаа бол үнэтэй болгох л концепт явж байгаа. Ер нь Улаанбаатар хот маань бол бүх юм л үнэгүй байдаг учраас энэ чиглэлийг бол илүү барьсан байгаа юм.

Тэгээд орон нутагт бид нар бас газар олгох процессыг ер нь төвлөрөлтэй, түгжрэлийн ч ажлын хэсэг байгуулагдаж байна, ипотекийн зээлээ ч бид нар уяж байгаа. Бид нар энэ утгаараа орон нутгуудад бас илүү хүн очиход газар олголтоосоо өгсүүлээд, газар өмчлөх хуулийн эрхээ газар өмчлөлийнхөө баталж өгөхдөө хүртэл орон нутагт нь өмчлөлийг илүү баталж өгч, Улаанбаатар хотод газар өмчлөх газрыг бодлогоор бид нар зохицуулж, багасгаж өгөх зэрэг энэ асуудлуудыг бол энэ хуулийнхаа ер нь цогц, багц хуулийнхаа бол концепцуудад бид нар бол суулгасан байгаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулья. Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрэм, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан, хөгжил цэцэглэлтийг хүсэн ерөөе.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу? Шатарбалын Раднаасэд, Даваажанцангийн Сарангэрэл нарын гишүүдээр тасаллаа.

Ш.Раднаасэд: Тэгээд зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Тэгэхдээ түрүүн бас Их Хурлын дарга цухалзуулаад авлаа. Энэ орон нутагт байгаа ард иргэдийн эзэмшлийн өмчлөлийн газрууд дээрх төлбөрийн хэмжээг Улаанбаатар хотод байгаагаас бас өөрөөр тогтоодог байх хэрэгтэй байна.

Ялангуяа энэ татвар бол төлбөрөөс чөлөөлөх газрууд явж байгаа юм. Тэгээд эдэлбэр газар дээрээ бид нар яг төлбөр авах юм уу, авахгүй юм уу? Одоо бол энийг

гишүүд голцуу эзэмшлийн газрууд дээр яваад байна. Энэ төлбөрийн ангиллыг өшөө нарийвчилж, өшөө олон болгох ёстой юм болов уу л гэж харагдаад байгаа юм. Тэгж байж энэ төвлөрлийг багасгана, төвлөрлийг сааруулна, бүр алслагдсан бүс нутагт үр тариа болон бусад хүнсний ногоо тарьж байгаа талбайд бол төлбөр бүр авмааргүй санагдаад байх юм. Улаанбаатар хотоос алслагдсан байна шүү дээ. Улаанбаатарт ч ижилхэн, тэр Говь-Алтай аймагт ч ижилхэн, Баян-Өлгий, Увсад ч ижилхэн. Ингээд аваад эхлэхээр л ингээд төв рүүгээ бөөгнөрөөд, зах зээл рүүгээ бөөгнөрөөд, эндээ л бөөгнөрөөд байгаа байхгүй юу. Тэгээд эдэлбэр газрын авч байгаа энэ төлбөрийн хэмжээг өшөө олон болгох л ёстой юм болов уу гэж.

Дээрээс нь бас нэг санал байна. Энийг зүгээр Их Хурлын дарга, Эдийн засгийн байнгын хороогоор явж байгаа байх. Бид нар энэ газрын хуультай холбоотой бүх асуудлыг бүх Байнгын хороод дээр чиглэл чиглэлээр нь хэлэлцмээр байгаа юм. Үндсэн хууль, Иргэний хууль, тэгээд Газрын хууль гэсэн ийм зарчмаар юм явж байгаа. Энэ бол суурь. Одоо энэ Газрын хуультай холбоотой, сургууль, цэцэрлэгийн газартай холбоотой, энэ боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагуудтай холбоотой газрын асуудал дээр нь ямар байх юм? Энийг нь холбогдох Байнгын хороо нь. Тэгээд Иргэний хуульд заасан суурь хөдөлдөггүй хэдэн зохицуулалтууд хүртэл энэ рүү ороод ирчихсэн байгаа шүү дээ. Бусдын эзэмшлийн газрыг ашиглах, дамжин өнгөрөх энийг нь болохоор энэ Хууль зүйн байнгын хороогоор ярьдаг юм уу?

Тэгээд энэ бэлчээрийн газартай холбоотой, хадгалан, тариалангийн газартай холбоотойг Хүнс, хөдөө аж ахуй ярьдаг юм уу гээд. Бүх Байнгын хороо дээрээ энийг бүр нэг бүрчлэн сайн ярих ёстой юм болов уу л гэж харж байгаа юм.

Энд зүгээр асуусан болоод, хариулсан болоод өнгөрөөд явах биш. Ер нь энэ хуулиудыг багцаар нь шинэчлэх нь зөв. Тэр цаг нь ч болсон. Сүүлийн 20 гаруй жил ерөөсөө хүрээгүй. Жижиг жижиг нэмэлт өөрчлөлт хийсээр байгаад хаана юу байгаа нь мэдэгдэхээ больчихсон. Тэгээд энэ газарт гарч байгаа бид нар өнөөдөр энэ газартай холбоотой маргааны үндэс юу байгаа юм? Энийг бас таслах гэж оролдох хэрэгтэй байгаа юм л даа. Энэ газар олголттой холбоотой.

Дээрээс нь энэ төлбөртэй холбоотой асуудал. Засгийн газрын тусгай хэрэгцээнд авчихсан боловч яг төлбөр төлдөг үү, төлдөггүй юу? Өшөө энэ газартай холбоотой зүйл бол маш их нарийсна шүү. Энэ Улаанбаатар хотын төвлөрөл, энэ хот, төв суурин газруудын төвлөрлийн асуудлыг бид нар зөв, зохистой хийхийн тулд энэ газраар нь дамжиж их нарийн зохицуулалт хийе.

Түүнээс бид нар гудамж, замын зохицуулалт, машин техникийн татвар, зам харгуй гэдгээрээ нэг их төвлөрлийг 100 хувь шийдэж чадахгүй байгаа байх. Энэ түгжрэлийн чинь үндэс ерөөсөө л энэ бөөгнөрөл шүү дээ. Тун удахгүй энэ зуслангийн газар чинь бид нарын хувьд бас асуудал болно. Яг ижил. Хэдэн зуун тэрбумаар нь тэр уулын мухарт булчихсан. Зуны 3 сар ашигладаг. Ингээд л энэ байшин бариад хаячихсан. Айл болгон.

Тэгэхээр энэ газрын төлбөртэй холбоотой энэ зохицуулалтыг нарийвчилж хаанаас суллаад, хаанаа чангалах юм гэдэг юмаа сайн хийхгүй бол энд 5 багц асуудал дээр л аваачаад л тогтоочоод байгаа байхгүй юу даа. 5 бүсчлэлд хуваагаад л. Тэгээд зам, шугам сүлжээний газрын төлбөртэй болгох нь бас зөв ч юм уу, буруу ч юм уу? Энэ Улаанбаатар хотын дэд бүтцийг хувийн хөрөнгөөрөө тэлээд, орон сууцаа барьж байгаа бол тэн дээр бид нар замын төлбөр гээд, дэд бүтцийн төлбөр

гээд дахиад тэр байшин, барилга барьж байгаа хүмүүсээс авах юм уу? Өөрсдөө төвлөрсөн шугамаасаа дулаан, цахилгаанаа хангаж чадахгүй байж байж гэх мэтчилэнгээр энийг нь дагалдах, холбогдох Байнгын хороодоор нэг бүрчлэн ярьж байж, дүгнэлт гаргаж байж явах ёстой юм болов уу? Энэ нэлээн сайн хэлэлцүүлэг хийх ёстой байх.

Ялангуяа энэ газар олголт ба авлига хээл, хахууль гэдэг сэдвээр. Газрын маргаантай холбоотой энэ гаргаад байгаа хүмүүсийн зовлон, жаргал нь юу байна? Энэ дээр орж ажилладаг энэ захиргааны хэргийн болон иргэний хэргүүд дээр явж байгаа энэ хэрэг. Гишүүдийн ширээн дээр ч маш их хэмжээний өргөдөл ирж байгаа шүү дээ. Дуудлага худалдаагаар авчихсан газрыг нь цуцлаад өөр хүнд өгчихсөн байгаа шүү дээ. Жишээлэх юм бол. Гэх мэтчилэнгээр энэ зүйлүүдийн.../минут дуусав./

Г.Занданшатар: Даваажанцангийн Сарангэрэл гишүүн үг хэлнэ.

Д.Сарангэрэл: Би үндсэндээ Раднаасэд гишүүний саналыг дэмжиж байгаа юм. Ер нь газар бол улс орны үндэс, ард иргэдийн ахуй амьдралын суурь. Тийм учраас энэ Газрын тухай хууль дээр Улсын Их Хурал нэлээн тийм ухаалаг, бодитой тал талаас нь хэлэлцэж ярьсан ийм байдлаар бол хандах ёстой гэж бодож байна. Ялангуяа Газрын тухай багц хууль ард, иргэдэд ээлтэй байгаасай гэдэг ийм хүсэл эрмэлзэл бол дүүрэн байна. Би нэг жишээ авъя. Тухайлбал, Хан Уул дүүргийн 11 дүгээр хороонд 1, 2, 3, 4, 5 дугаар хэсэгт 600 иргэний асуудал байгаа юм. Эдгээр хүмүүс 62 жил тэнд амьдарч байгаа. Өнөөдрийг хүртэл тэнд томоохон компаниудын асуудал шийдэгдсэн мөртөө энэ ард, иргэдийн асуудал ерөөсөө шийдэгдээгүй. Энэ хүмүүс газраа өмчилж аваагүй. Тэгээд 5 жилээр газар ашиглалтынх нь гэрээг сунгаад явдаг.

Үүнээс болоод энэ хүмүүс маань газраа эдийн засгийн эргэлтэд оруулж чаддаггүй. Газраараа барьцаа тавиад зээл авч чаддаггүй. Ийм хүндрэлтэй байгаа. 2015 онд хамгийн сүүлд сунгаад, түүнээс хойш энэ 62 жил тэнд амьдарч байгаа өөрсдийгөө унаган иргэд гэж нэрлэдэг юм хөөрхий. Энэ хүмүүсийн асуудлыг шийдэж өгөөгүй.

Тэгээд ер нь бол түвшин түвшинд нь энэ тойргоос сонгогдсон гишүүд асуудлыг бол тавиад явдаг. Газрын асуудал өөрөө 6 яамны хүрээнд асуудал нь зохицуулагддаг. Тийм учраас нэг нэг рүүгээ шидэх, асуудалд хойрго хандах.

Гуравдугаарт бол хууль эрх зүйн зөрчил байгаа учраас шийдэж чадахгүй байна гэдэг. Тэгэхээр Газрын багц хууль хэлэлцэж байгаа энэ үед энэ Зайсанд амьдарч байгаа жирийн 600 иргэний 62 жил амьдарч байгаа иргэдийн асуудлыг бол ээлтэйгээр өөрсдийнх нь хүсэн хүлээсэн байдлаар бол шийдэх ёстой гэж. Ер нь бол энэ иргэд маань түвшин түвшинд нь олон жилийн турш бол ингээд хүсэлтүүдээ өгөөд явсан. Би тухайлбал бодитоор хэлье л дээ.

11 дүгээр хорооны Засаг дарга Ариунтуяа, иргэн Нямсүрэн, Норовцэрэн, Лхагвасүрэн, Баярбат, Гансүх, Отгонхүү, Туяа, Нямтөгс, Балжинням. Хамгийн сүүлд бол Шарав овогтой Уламсайхан гэж. 1957 онд төрсөн цагаасаа хойш тэнд амьдарсан. Өнөөдрийг хүртэл асуудал нь шийдэгдээгүй.

Эдгээр хүмүүс юу хүсэж байгаа вэ гэвэл нэгдүгээрт, эхний ээлжид энэ хууль гараад хэрэгжих хүртэл газрынхаа гэрчилгээг 5 жилээр дахин сунгаж өгөөч. Газрын төлбөр энэ гэр хороололд амьдарч байгаа хүмүүст маш өндөр байгаа учраас 1 удаа энэ газрынхаа төлбөрийн асуудлыг бас чөлөөлж өгөөч гэсэн ийм хүсэлт тавьж байгаа.

Улмаар бол гуравт нь хуулийн хүрээнд, газар дээрээ нэг мөр гэрчилгээ авах. Улмаар эдийн засгийн эргэлтэд оруулах энэ боломжийг бүрдүүлж өгөөч гэсэн ийм хүсэлтүүдийг бол тавьж байгаа. Сая Магнайсүрэн дарга маань хэллээ. Тусгай хамгаалалттай газрын тухай энэ хууль, эрх зүйн зохицуулалтын асуудлыг Засгийн газар дээрээ яриад, багцаар нь оруулж ирнэ гэж. Энэ асуудлыг оруулж ирэхдээ би та бүхэнд бас өмнө нь ч гэсэн өгчихсөн байгаа. Дахиад би энэ бичгийг өгнө. Энэ Зайсанд амьдарч байгаа энэ 600 иргэний асуудлыг бид нар зохистой, иргэддээ ээлтэй байхаар шийдэх тал дээр та бүхнийг анхаарч өгөөч гэдэг хүсэлтийг би тойргоос сонгогдсон гишүүний хувьд тавьж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Газрын төлбөрийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг дэмжих тухай санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

31 гишүүн дэмжиж, 64.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна.

Энэ маш чухал Газрын багц тухай хуулиудыг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлээ.

Эдийн засаг, Хууль зүйн байнгын хороонууд бас хамт хэлэлцэнэ. Давхар хэлэлцээд явна. Хууль зүйн хувьд нэг, эдийн засгийн хувьд. Тэгээд төвлөрлийг сааруулах бодлогын хувьд ч гэсэн энийг онцгой анхаарч хэлэлцэх хэрэгтэй. Энэ хуулийн төсөл 2 удаа хойшилсон. Нэг нь сайд, хууль санаачлагч байхгүй байгаа учраас, нөгөөдөх нь энэ ирц хангалтгүй учраас.

12.21 цаг

Тийм учраас та бүхэнд хандаж хэлэх үг байна. Хүн хэдий ухаантай ч хэлэхээс нааш гэдэг. Улсын Их Хуралд нэр дэвшиж сонгогдсон та нөхөд бол ажлаа зүтгэж болгоё, бүтээе, босгоё, сэргээе гэж хичээж, чармайж байгаа нь тодорхой.

Гэхдээ нэгэнт бид хувь заяагаар холбогдсон болохоор цаг алдалгүй санал, бодлоо солилцож, ажил албаа түргэн шуурхай бүтэмжтэй болох бүх талын арга хэмжээ авах зайлшгүй чухал байна. Та нөхдийг бол сургах, номлох, эсвэл магтах, зэмлэх гээгүй. Одоо гишүүд анхааралтай сууж сонсмоор байна.

Ер нь би онцгой анхааруулж хэлье гэж бодож байна. Улс орны байдал хүнд байна. Жаргалтулгын Эрдэнэбат гишүүнээ та суу одоо. Үнийн өсөлт, валютын ханшийн өсөлт, орлогын хомсдол үргэлжилж байна. Энэ байдал мөддөө засрах шинжгүй байна. Ийм нөхцөлд иргэдээ төлөөлж, төрийн эрхийг барьж байгаа Улсын Их Хурлын гишүүд та биднээс олон зүйл шалтгаална. Үүнийг чин сэтгэл, зүрхээр мэдэрч, хуралдаа идэвхтэй оролцож, ажиллах хэрэгтэй байна.

Өнөөдрийн хуралдаан хэдэн минут хоцорч эхэллээ. Одонтуяа гишүүн,

Шатарбалын Раднаасэд гишүүн гээд олон гишүүнээ өглөө улс орны нөхцөл байдал, сахилга хариуцлага, ёс зүйн талаар хөндөж ярилаа. Олонхын бүлгийн гишүүдэд сануулж хэллээ. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14.1.1-д заасны дагуу ард иргэдээс ирүүлж байгаа санал хүсэлтийг Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын гишүүдэд анхааруулж хэлнэ гэсэн зарчмын дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44.4.16-д гишүүдийн нэгдсэн болон Байнгын хороодын хуралдаанд оролцсон ирцийн мэдээг сар бүр гаргаж олон нийтэд мэдээлэхээр заасан байдгийн дагуу 11 дүгээр сарын мэдээллийг танилцуулна.

Нэгдсэн хуралдааны 11 дүгээр сарын мэдээгээр Ширнэнбаньдын Адьшаа, Пүрэв-Очирын Анужин, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, Хавдисламын Баделхан, Буланы Бейсен, Гочоогийн Ганболд, Наянтайн Ганибал, Бадарчийн Жаргалмаа, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Дуламдоржийн Тогтохсүрэн, Чинбатын Ундрам, Содномын Чинзориг, Бямбасүрэнгийн Энх-Амгалан нарын гишүүд 1 ч удаа хоцроогүй, таслаагүй, эмнэлгийн чөлөө аваагүй, гадаадад бол орон нутагт яваагүй байна. 11 дүгээр сард.

Гэтэл 11 дүгээр сарын нийт 7 хуралдаанаас 1-3-ыг нь тасалсан 6 гишүүн байна. 1-6 хүртэл удаа хуралдаанаас хоцорсон 30 гаруй гишүүн байна. 12 дугаар сарын болон жилийн дүнгээр эдгээр гишүүдийг нийтэд зарлаж, мэдээлэх болно. Хуралдаанд хамгийн идэвхтэй оролцсон гишүүд бол Жигжидийн Батжаргал гишүүн байна. Хуралдаанд хоцроогүй, таслаагүй төдийгүй хуралдааныг эхнээс нь эцэст нь хүртэл сууж, асуултаа хариулж, бүгдийг нь сонсож байдаг. Гэтэл зарим гишүүд асуулт асуучхаад гараад явчихдаг.

Сүүлийн жилүүдэд ирц эрс сайжирч, чуулган цагтаа эхэлдэг болсон гэж бид бахархан тэмдэглэж байсан.

Дандаа 1 цаг орчим хоцордог байсан 12 он хүртэлх практикийг халлаа гэж бид тэмдэглэж байсан юм. Гэтэл сүүлийн 2 долоо хоногт олон гишүүд гадаад, дотоод явсан. Өвчтэй, чөлөөтэй байсан. Тэгээд дээр нь тасалсан шалтгаанаас болоод Улсын Их Хурлын чуулганы хуралдаан 30 гаруй минутаар хоцрох, санал хураалтууд саатах, асуудал хойшлох асуудал гарлаа.

Газрын тухай хууль энэ маш чухал хууль хэлэлцэж байхад энэ гишүүд чинь хаачихсан юм бэ гэж цөөнхийн бүлгээс шаардсан, ард иргэдээс, тухайлбал Defacto Жаргалсайхан иргэнээс хүртэл энэ гишүүд чинь энэ газрын наймаанд оролцчихсон юм уу, яагаад хуралдаа оролцдоггүй юм бэ гэсэн шаардлага тавьж байна.

Ийм учраас хуралдаан хангалттай ирцтэй эхэлсэн ч санал хураахад 10 гаруйхан гишүүн үлдсэн үзэгдэл гарлаа. Саналаа хэлчхээд өрөөндөө ороод бусад ажлуудаа цэгцлэх, дотоод сүлжээгээр хуралдаандаа сонсож, хардаг, сонгогчидтойгоо болон албаны уулзалт хийх шалтгаан гаргадаг гишүүд байдаг. Энэ бол бодит.

Гэхдээ энэ 10 хэдхэн хүн хууль хэлэлцэж байна гэж ард иргэд хараад байна. Газрын тухай хууль хэлэлцэх үеэр яг ийм байдал гарлаа. Энэ хуулийг хэлэлцэхээс зугтаж байгаа гишүүдийг ямар ашиг сонирхлын зөрчилтэй юм бэ гэж нийгмийн сүлжээнд ч гэсэн асуудал тавьж, надад шаардлага тавьсан. Үүнийг би ард иргэдээс тавьж байгаа шударга, зөв шаардлага гэж үзэж байна.

Тиймээс хуралдаандаа гишүүд тогтмол биечлэн сууж байх ёстой. Ёс зүй, сахилга хариуцлагаа сахиж, нийгэмд үлгэр дуурайл болох хэрэгтэй. Хуралдааны үеэр үлгэргүй байдал гаргаж, зүй зохисгүй үг хэрэглэдгээ болих хэрэгтэй. Бусдыгаа гутаан доромжлохоо болих хэрэгтэй. Хоосон маргалдах, баталгаагүй мэдээллээр

олныг төөрөгдүүлэх, хэт мэргэн хүн болох гэж оролдох нь өөрийнхөө болон парламентын нэр хүндийг унагааж байна. Гишүүд хэлэх үгээ урдаас сайн бэлтгэж байх хэрэгтэй байна Гарцаа юугүй чухал үндэслэлтэй саналаа хэлдэг болмоор байна. Бэлдээгүй зүйлийг дэмий ярьж цаг үрэх хэрэггүй байна. Өөр нэг чухал асуудал бол ард иргэдийн нүүрсний хулгай, Хөгжлийн банкны хэрэг зэрэг олны анхаарал татсан, хууль зөрчсөн, шударга ёсыг тогтоох шаардлагатай хэргүүдийг шалгаж тогтоох ажлыг шаардаж байгаа. Эдгээр ажлуудаар Улсын Их Хурал дээр хянан шалгах түр хороод байгуулсан. Тухайлбал, Хөгжлийн банкны түр хороог Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагааг шалгах түр хороог Гочоогийн Ганболд гишүүн, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэр, нийлүүлэлтийн асуудлыг шалгах түр хороог Учрал гишүүн ахалж ажиллаж байгаа. Энэ нүүрсний хулгайн энэ тэр олон асуудал ч гэсэн энэнээс цочин авч илэрсэн, яригдсан. Эдгээр хороодын үйл ажиллагаанаас ард иргэд бол бас ихийг хүлээж байна. Энэ төсвийн мөнгө, эх орны баялгийг тонон дээрэмдсэн, булхай луйврыг илрүүлнэ, шударга бус үйлдэлтэй хийх тэмцэл үр дүнд хүрнэ гэж хүлээж байгааг мартаж болохгүй.

Нөгөө талаар бид бол маш олон хууль баталж байгаа. Гэвч баталсан хуулийн зарим зүйл, заалт амьдралд нийцэхгүй байна гэсэн санал, хүсэлт ирж байна. Энэ хуулиар зохицуулах харилцаагаа уг углуулгаар нь бүрэн мэдэрч, бүрэн гүйцэд ханддаг болох хэрэгтэй байна. Хуулийн төслийн чанарт анхаарах хэрэгтэй байна. Өнөөдрийн энэ Газрын тухай багц хууль дээр ч гэсэн. Хууль санаачлагчид түүхий, дутуу төслөө Их Хурал учрыг нь олно биз гээд парламентын босго давуулж шийддэг байдлаа зогсоо. Эрдэмтэн, судлаачид, иргэдийнхээ саналыг авахгүйгээр яаран

хууль хуумгай төсөл өргөн барьдгаа болих хэрэгтэй байна. 80 гаруй зүйл заалттай, хуулийн төсөлд 90 гаруй шахам засвар, өөрчлөлт оруулсан талаар би энэ дээр хэлж байсан. 80 заалттай хуульд 90 өөрчлөлт орж байдаг. Ийм муу боловсруулсан хуулийн төслийн бөөс, хуурыг парламент түүгээд сууж байж байх ёсгүй.

Тэгээд тэрэн дээр нь тойроод маргалдаад сууж байх ёсгүй. Хууль батлахдаа дагасан маш олон хуулийн өөрчлөлтийг Улсын Их Хурлаар хэлэлцдэг нь маш их цаг авч байна. Сая Монгол Улсын 2023 оны төсвийг батлахад 103 хууль, 6 тогтоолд өөрчлөлт орсон. Энэ өөрчлөлтүүдийг цахим технологи ашиглаж, хуульдаа тусгадаг больё, Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулъя. Зарим өөрчлөлтийг бид өөрсдөө ингэж ард түмэн үнэмлэхүй эрх олгочихсон байхад шийдээд явах хэрэгтэй байна. Намын бүлгүүд ч гэсэн олон, цөөнөөрөө хуваагдах биш, оюун ухаан, ойлголт, зөвшилцлөөр нийтийн эрх ашгийн төлөө нэгдэж ажиллах шаардлагатай байна. Олноороо төр барих, цөөнхөөрөө сөрөх хоёрын аль аль нь Монгол Улсын эрх ашигт нийцэхгүй. Бидэнд Монголын ард түмэн энэ төрийн эрхийг итгэж атгуулсан гэдгийг өдөр тутам санаж ажиллах хэрэгтэй байна. Энэ үг бол үнэмлэхүй олонх болсон цөөнх болсон бүх намд хамаарна. Английн суут сэтгэгч Фрэнсис Бэкон намууд өөдөө гарахдаа тулгуураа олохыг бодох хэрэгтэй Оройд гараад тэнцвэрээ олох ёстой гэсэн үгийг би бас зориуд эшилж хэлмээр байна. Улс орныхоо өнөөдрийг бодолцож, маргаашийг харж, өөрсдийн үйл ажиллагаандаа үнэлэлт, дүгнэлт хийж ажиллацгаая. Гишүүн бүр дор бүрээ бодож ажиллая. Ард иргэдээ бодож, улс орны ашиг сонирхлоос илүү эрхэм зүйл байхгүй гэдгийг бодож, хувийн ашиг сонирхлоос ангид байж, төр ард түмнийхээ төлөө зүтгэх, өдөр болгон ухамсарлан санаж байх хэрэгтэй байна.

Монгол төрийн, Монгол Улсын нэр хүнд, хувь заяа та биднээс хамаарч байгаа шүү гэдгийг өдөр тутам санаж байх хэрэгтэй. Улсын Их Хурлын гишүүд бол бүхний дээр байгаа эрх мэдлийн бурхан тэнгэр бүхнийг шийддэг хүмүүс биш. Гэхдээ хэрвээ Улсын Их Хурлын гишүүнд ямар нэгэн эрх мэдэл байдаг бол ихээхэн эрх мэдэл байдаг гэж хүмүүс боддог. Энийг зөвхөн төрийн бодлогын ашиг сонирхлын үүднээс ашиглах ёстой гэдгийг сануулж хэлье.

Цаашдын хурал, үйл ажиллагаандаа өнөөдрийн, өчигдрийн, өнгөрсөн 7 хоногийн энэ ирцүүдээр оролцохгүй байхыг бид хатуу тэмдэглэж хэлж байна. Энэ оны эцэст бүх гишүүдийн ирцээр нь олон нийтэд мэдээлэл хүрнэ. Та бүхнийг итгэж сонгосон ард түмэнд чинь ажлыг чинь тайлагнах болно. Энэ төр ард түмний эрх ашгийг дээдэлж, чуулган үйл ажиллагаандаа идэвхтэй оролцохыг сануулж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Дараагийн асуудалд орно. Барилга, хот байгуулалтын сайд, яам ч гэсэн энийг анхаарч ажиллах нь зүйтэй шүү. Та нарт ч гэсэн хандаж хэлж байгаа.

Зургаа.Одоо Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг танилцуулна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Ц.Цэрэнпунцаг: Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хууль, төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулья. Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Отгоншарын Батнайрамдал, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Лхамсүрэнгийн Баярмандал, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Содномцэрэнгийн Мөнхнасан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Болдбаатарын Анхбаяр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлого хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Чулууны Хишигдалай, МИАТ төрийн өмчит компанийн Санхүүгийн, удирдлагын газрын захирал Нарангэрэлийн Цэгц, “Эрчис ойл” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Занаширын Ширзана, “Эрчис ойл” компанийн менежер Хүүхээгийн Эрдэнэбилиг.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Ширнэнбаньдын Адьшаа гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Дашдондогийн Ганбат асуулт асууна.

Д.Ганбат: Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгачихъя. Ер нь аливаа асуудал чухал, чухал биш, чухал хууль, чухалгүй хууль гэж байхгүй. Хууль л бол хууль. Бүх хууль бол чухал. Тэгээд Улсын Их Хурал хуралдаж чадахаа байлаа гээд гадна, дотноос янз бүрийн шүүмжлэл явж байна. Миний микрофоныг таслахгүй шүү. Урьдчилаад хэлчихье. Занданшатар даргаа. Өмнө нь таны наана чинь сууж байсан хүн, З.Энхболд таслаад байдаг байсан юм. Ер нь ард түмний амыг хаадаг хэн бэ? Хэн ч биш, хэн ч хаах ёсгүй шүү. Тэгээд Улсын Их Хурал бол эхлээд юу яана. Улсын Их Хуралтай бол ард түмэн хариуцлага тооцно. Ямар байгаатай нь. Бид нар бол Засгийн газартай хариуцлага тооцох ёстой. Энэ Улсын Их Хурлыг энэ Засгийн газрыг

ийм болгосон нөхдүүд нь бол энд байгаа хэдэн нөхдүүд шүү дээ. Энэ давжаа парламентыг давхар дээлтэй болгоод эцсийн эцэст ийм байдалд орж байгаа юм. Энэ хариуцлагаа хүлээх ёстой шүү нөхдүүд минь. Ялангуяа Улсын Их Хурлын дарга та. Манай энэ цөөнхийн хэд ч гэсэн.

Г.Занданшатар: Хурал тасалж, одоо явж явж ирээд хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт асуу. Газрын тухай хууль хэлэлцэж байна. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуультай холбоотой.

Д.Ганбат: Би сүүлийн 1, 2 секундэд оршил ярьж байгаад асуудаг хүн. Битгий ам хаах гээд байгаарай та. Энэ хуулийг яагаад ингэж оруулж ирээд байгаа юм бэ? Наадах чинь болохгүй шүү дээ. Энэ чинь хоригт орох гээд байгаа юм биш үү? Тэгээд онгоцны нийлүүлэлтийг ганцхан компани хийнэ. Төрийн өмчтэй Оросын Холбооны Улсын Роснефтийн. Ингэж хийхээр яах уу? Хоригт орох уу, орохгүй юу? Энэ дайн дажин чинь үргэлжилж байна. Европын холбоо энэ намай хойд хөршийг терроризм дэмждэг улс гээд зарлачихлаа. Энэ та нарт хамаагүй юу? Тэгээд өнөөдөр ямар байна? Дизелийн түлш чинь тасарчихсан, улс орноороо хүнд байдалд орчихсон байна. Энэ ганцхан орноос хараат байж болохгүй шүү дээ. Ганц компаниас. Тэр тусмаа төрийн өмчтэй компаниас. Энэ Монгол Улсын, Монголын ард түмний эрх ашиг хаана байна? Энийг юу гэж бодож байгаа юм?

Тэгээд л нэг л сайхан хямдхан болно, гоё сайхан болно гээд л байсан. Би хэлж л байсан шүү дээ. Деполтод орно. Улсын Их Хурал чинь Улсын Их Хурал биш болно. Засгийн газар чинь хэн хэлэх үү? Бас л одоо улам л буруу замаар явна. Ер нь хэлж ярих юмгүй бол ялзардаг. Хүн хэдий сайн ч хэлэхээс наашгүй, цаас хэдий сайн ч чичихээс наашгүй гэж Монгол ардын мэргэн цэцэн үг байна. Та нар хаагуур нь яваад байдаг юм? Тэгээд

өнөөдөр харанхуй, хөлдүү ийм засагтай болчихоод байна шүү дээ бид нар.

Тэгээд ард түмнийхээ хэлж байгаа, ярьж байгаа юмыг ерөөсөө сонсохгүй. Ийм ардчилал, ийм улс орон гэж юу байдаг юм бэ? Хэн нэгэнд тааруулаад л, аль болохоор олон компаниас эх үүсвэртэй, дотоодынхоо компанийг дэмжсэн ийм бодлого явуулахын оронд аль болохоор л хараат болгох гээд хичээгээд байх юм. Та нар. Тэгээд нэг сүрхий сайхан хямдхан бензин, тостой болно гээд байсан хаана байна? Байхгүй шүү дээ. Нөгөө нефтийн үйлдвэр нь хаана байна? Байхгүй. 24, 25 онд орно гэнэ. Сонгуулийн дараа орно гэж байна.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Улсын Их Хурлын гишүүн хариулна.

Ж.Ганбаатар: Ганбат гишүүний асуултад хариулъя. Хоригт орох асуудал бол байхгүй. Ер нь бол аливаа хориг гэдэг бол 2 сонголттой юм уу, эс үгүй бол 3 сонголттой байсан тохиолдолд Оросын Холбооны Улсыг сонгосон бол асуудал үүснэ. Түүнээс биш юу гэдэг юм, Хятад Ард Улсаас гэдэг юм уу, Солонгосоос гэдэг юм уу, Казахстан улсаас гэдэг юм уу ийм сонголт байхад нь зөвхөн Оросын Холбооны Улсыг энэ олон сонголтуудаас сонгочихсон бол энэ бол асуудал гэдгийг бид олон элчин сайд нартай уулзаад энэ асуудлыг. Энэ дээр бол ярьж байгаа нэг ч улс байхгүй. Тэр битгий хэл манай яамны зүгээс Америкийн Холбооны банк, Европын холбооны банктай асуудлыг ярьсан. Ямар ч асуудал байхгүй. Бид эндээс өөр сонголт байхгүй. Аваад ирсээр ирсэн. Та энийг бол өөрөө маш сайн мэдэж байгаа. Олон жил Их Хуралд суусан. Энийг хэлье.

Дизель түлшний хувьд асуудал үүссэн. Асуудал үүссэн гол шалтгаан бол Оросын Холбооны Улсын дотоод нөхцөл байдалтай холбоотой байгаа. Бид энэ

асуудлыг шийдвэрлэх хүрээнд олон ажлуудыг хийж байна.

Нэгдүгээрт, “Роснефть” компаниас дизель түлшийг нийлүүлэлтийг 60 хувь, бусад трейд компаниудаас 40 хувь нь нийлүүлэгддэг. “Роснефть” компанийн хувьд бол нийлүүлэлт хэвийн байгаа. Трейд компаниудын нийлүүлэлтийг Оросын Холбооны Улсын энэ Эрчим хүчний дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг гараад хязгаарлалт хийсэн. Энэ бол гол шалтгаан болж байна. Энийг нөхөхийн тулд Уул уурхайн яам ямар ажил хийж байна гэвэл бид Хятад улсаас дизель түлш импортолж эхэлж байна. Энэ маань ойролцоогоор 24000 тонн дизель түлш ачигдсан байна. 2 хоногийн өмнөөс эхлээд дизель түлшнүүд орж ирсэн.

Ер нь тэгээд бид бол 1 дүгээр ээлжид колонкуудыг дизельтэй байх асуудлыг тавьж байгаа. Энэ асуудал бас нэлээн нааштайгаар шийдэгдээд явж байна. Мэдээж нийтийн тэвэрүүдээ орон нутагт явж байгаа автобуснуудаа зогсоохгүй байх талаас нь асуудалд хандаж байна.

Мөн мэдээж уурхайнуудын асуудал байна. Тэгээд бага багаар асуудал сайжирч байна. Тэгэхдээ энэ бол өнөөдөр бидэнд тохиолдож байгаа асуудал биш шүү дээ. Ер нь бол тэгээд л дэлхий нийтээрээ Оросын Холбооны Улсаас дизель түшээ болон бензин шатахуунаа импортолдог улсуудад тохиолдож байгаа л бэрхшээл байгаа юм. Тэрнээс гадна дагаж явж байгаа бас жижиг асуудлууд байна. Зуны түлшнээс өвлийн түлшинд шилждэг улирал байна. Оросын Холбооны Улсын дотоод нөхцөл байдал дизель түлш дээр бол жилийн түүхэнд байхгүй нь жилийн бусад үеэсээ хамаагүй их хэрэглээтэй байна. Учир шалтгааныг нь та өөрөө мэдэж байгаа. Товчхон хариулахад ийм байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн

Ширнэнбаньдын Адьшаагийн урилгаар Ховд аймгийн оюутан залуучууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Оюутан залуучууддаа сурлагын өндөр амжилт, сайн сайхныг ч ерөөе. Гишүүдийн нэрийн өмнөөс. Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууна. 1 минут.

Д.Ганбат: Энэ давхар дээлтэй, баян тарган хүмүүс нэг иймэрхүү л юм яриад байдаг байхгүй юу. Тэгээд л бид нар л буруутай юм шиг, ард түмэн л буруутай юм шиг. Тэгээд юу вэ? Энэ хориг тавьдаг орнуудын өмнөөс хориг тавихгүй гэж хариулаад л. Үгүй ээ, тийм мэддэг, чаддаг болчихсон юм уу? Би бол гайхаж байна. Тийм л сүрхий юм бол яагаад дизелийн түлш нь тасарч байгаа юм? Тасрахгүй л байх ёстой шүү дээ. Яах гэж яам байгаа юм? Яах гэж сайд байгаа юм? Энэ ажлаа хийх хэрэгтэй шүү дээ. Өнөөдөр тасарсан уу? Тасарсан. Хүнд хэцүү байна уу? Байна. Одоо хариуцлага тооцох ёстой шүү дээ. Тэгсэн чинь л одоо юу вэ? Тэгдэг, ингэдэг, тийм байдаг, ингэж тасарч байх ёстой, ийм байдаг юм энэ тэр гээд. Өмнө нь зүгээр л хангагдаад л, нийлүүлэгдээд л ийм юм ярьдаггүй байсан шүү дээ. Бараг тасарчихсан байгаа нь гавьяа юм шиг. Ер нь энэ улс орон хариуцлага ярьдаг болмоор байна шүү. Хэн ч хариуцлага ярихгүй. Байх ёстой юм шиг, тэгэх ёстой юм шиг. Та цалин.../минут дуусав./

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд.

Ж.Ганбаатар: Тийм. Тан шиг чанга дуугараад муу үг хэрэглэвэл хэрэглэнэ л дээ. Би тэгэхдээ таны оронд, танаас бол би өөр хүн л дээ. Тэх. Танаас хамаагүй өөр хүмүүжилтэй, танаас хамаагүй өөр зан араншинтай. Та намайг ганц, хоёр үгээр дайрна гэвэл би таныг бол хэчнээн ч үгээр дайрч чадна шүү дээ. Би тан шиг биш.

Би танаас өөр. Өөр учраас тан шиг Их Хурлын танхимд муу үг хэрэглэхгүй. Та зөндөө л муу үг хэрэглэлээ шүү дээ.

Сонголт дээр, хориг дээр би танд чадах ядахаараа л тайлбарлалаа. Та өөрөө наад хуулиудаа уншаад сайн ойлгоорой. Дизель түлш дээр бол Оросын Холбооны Улсын дотоод нөхцөл байдал түүхэнд байхгүй өөр нөхцөл байдалтай байна. Үгүй ээ, ямар нөхцөлтэй юм гэвэл дайн байлдааны асуудал байна. Зэвсэгт мөргөлдөөний.../минут дуусав./

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Асуултаа асууя. Бид нар энэ Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бас чухал асуудал хэлэлцэж байна. Энэ нь өөрөө бас агаарын тээврийн хөлгийн энэ шатахууны хангамжтай холбоотой асуудал яригдаж байна л даа. Олон жил мэдээж “Сод Монгол” компани үүргээ гүйцэтгэж ингэж ирсэн. Одоо болохлоор “Эрчис ойл” гээд төрийн өмчит компани бас тодорхой хэмжээний ачаалал үүрэхээр орохын тулд нэмэлт, өөрчлөлт оруулж байна гэж бид нар харж байна. Бид нар Засгийн газрын зүгээс, уг нь бол төрийн өмчит компаниудыг аль болохоор цэгцлэх, энийг аль болохоор хувийн хэвшил рүү, хувьтай нь үүргийг нь гүйцэтгэх энэ бодлого барьж байгаа.

Гэхдээ нөгөө талаасаа дахиад төрийн өмчит компани энэ агаарын тээврийн шатахууны хангамж дээр орж ирнэ гэж байна л даа. Ингэснээрээ ямар эдийн засгийн үр дагавар гарах юм? Жишээлбэл, энийг гарч ирлээ гээд манай улсад агаарын тээврийн тийзийн үнэ яаж хямдрах юм? Зарим нэг яриагаар, салбарынхны яриагаар 10-15 хувиар онгоцны тийзийн үнэ хямдарна гэж байна. Бямбацогт сайдаа яг ийм тооцоо судалгаа гарсан юм уу? Яг “Эрчис ойл” гээд энэ

компани маань агаарын тээвэрт шатахуун нийлүүлэхээр үүрэг гүйцэтгээд ингээд ороход өнөөдрийн үйлчилж байгаа үнээс бүр 10-15 хувиар хямдарна гэвэл 2 гараа өргөөд дэмжихэд бэлэн байна л даа.

Яагаад гэвэл тийзийн үнэ бол үнэхээр өндөр байгаа юм манай дээр. Тэгээд энэ дээр 1 дүгээрт би салбарын сайдаас хариулт авъя. Бямбацогт сайдаас.

Хоёр дахь нь Ганбаатар сайд та яг бодитой мэдээллийг хангаад өгчихвөл зүгээр байгаа юм. Яагаад гэвэл өнөөдөр Ганбат гишүүн, Ардчилсан намынхан маань дотроо асуудалтай учраас бухимдлаа энэ дотор оруулж ирээд л, гаргаад л байна л даа. Өөрсдөө ч гэсэн Байнгын хорооны ч хуралд ирдэггүй, чуулгандаа ч суудаггүй. Тэгэхээр одоо хаа хаанаа хариуцлагатай байх нь чухал. Би дуугарч байгаад маш их баяртай байна. Сөрөг хүчний дуу хоолой үгүйлэгдээд байна.

Тийм учраас та нар зөвд зөв, бурууд буруу дуугарах юмаа бол маш сайн хэлж байвал сайн байна. Тэгээд дизель түлш болон ер нь түлш хомсдоод байна, колонкуудад зарахгүй байна, зарвал хязгаарлалттай зарж байна. Хөдөө, орон нутагт бүр хүнд байна гээд иргэд бидэн рүү бичиж байна. Та бүхэн эрх барьж байгаа нам, олонх энэ асуудлаа олон сар ярилаа шүү дээ гээд хэлж байгаа юм. Тэгээд Ганбаатар сайд өглөө би бас асуусан, зөвхөн Оросын Холбооны Улсаас гэлтгүй Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас дизель түлш болон бусад түлш авч эхэлсэн гэсэн. Хэт хэмжээгээр авч байгаа юм? Одоо ингээд үүсээд байгаа энэ асуудал, энэ хомсдолд хязгаарлалттай өгөөд байгаа нь хэзээ яг зогсох вэ? Одоо яг нөөц ямар байгаа юм? Асуудал нь юун дээр байна? Хил, гааль юм уу? Эсвэл хойд хөршдөө бид нар бас энэ асуудал дээр “Роснефть” компаниар дамжуулаад хэл амаа олох дээр асуудал байгаад байна уу? Та бас яг бодит мэдээлэл өгөх хэрэгтэй байна. Тэгэхгүй

бол бүх юм сайхан байгаа юм шиг мэдээлэл өгөөд байдаг. Иргэд очоод шатахуун түгээх станцууд дээр авах гэхээр бас хомсдолтой хязгаарлалттай байгаа нь бодит үнэн байгаад байна л даа. Тэгэхээр энэ зүйлүүдийг бид нар бас бодитоор харж, хандаж хэлэх хэрэгтэй байна. Ер нь бол энэ агаарын тээврийн шатахууны хангамжийн асуудал бол үеийн үед асуудал дагуулдаг.

Гэхдээ манайх бас тодорхой хэмжээгээр нөөцөлдөг учраас ингэж хомсдох ч юм уу ийм асуудал бол үүсдэггүй шүү дээ. Тэгэхээр одоо энэ хувийн хэвшлийн 1, 2 компаниас гадна бусад компаниуд тэр дундаа төрийн өмчит компанид боломжийг нь нээж өгөөд нээлттэй болгочхож байна гэж ойлгож болох уу? Тэгээд энэ дээр эхлээд эдийн засгийн үр ашгийг нь хэзээнээс бид мэдэрч эхлэх юм? Энэ дээр хариулт авчхаад тодотгоё гэж бодож байна.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Оюунчимэг гишүүн их чухал чухал асуулт асуулаа. Мэдээж өрсөлдөөн бий болно. Түүнээс биш “Роснефть” гэж компанийн давамгайлсан зүйл бол байхгүй. Энэ хуульд тийм үг, өгүүлбэр ч байхгүй. Зүгээр яах вэ, бөөний нийлүүлэгч гэхлээр ганцхан “Роснефть” ч биш. Хятадын тал ч байж болно, Газпром ч байж болно. Маш олон нийлүүлэгч нар байгаа шүү дээ. Манайхан “Роснефть” манайд нэлээн нийлүүлэлт нь, хэмжээ нь их учраас шууд “Роснефть”-тэй холбож яриад байгаа юм. Богинохон учраас хурдан явъя. 12 сараас эхлээд ер нь цаашдаа яах вэ гэдэг асуултад хариулахад дизель түлшний сарын нийт хэрэглээ 80000 тонн Монгол Улсынх. “Роснефть” компани энэ трейд компаниудын нөхөлтийг хангаад 83000 тонныг нийлүүлнэ гээд бид гэрээ байгуулчихсан. Тэгэхлээр 12 сараас бол дизель түлш бол харьцангуй жигдэрнэ.

Дээрээс нь бид нар Хятадаас аваад эхэлчихсэн байгаа. Өмнө нь яагаад Хятадаас авдаггүй байсан гэдэг гол шалтгаан байна. Энэ юу байсан бэ гэвэл өмнө нь бол Хятадын дизель түлш бол үнэтэй. “Роснефть” компанитай өрсөлдөх боломж бол хомс. Хятад өөрөө хамгийн том импортлогч болсон гэдгийг бас танд хэлье. Өнөөдрийн байдлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 18000 тонн дизель түлш ачигдсан байна. Танд би түрүүн сарын хэрэглээг нь хэлсэн. Мөн Оросын Холбооны Улсын газар нутаг дээр 21000 тонн дизель түлш ачигдаад яг замдаа явж байна. Тэгэхлээр та бүхэн энэ тоонуудаас логикоор нь ойлгочих байх гэж бодож байна.

Ер нь Оросын хилээр орж ирэх процесс удаан байгаа. Бас асуудал нь Орос дотор төмөр замын хангамж, хүртээмж, ачаалал бас бусад жилтэй харьцуулахад маш их хэмжээтэй байна. Ингээд өрсөлдөөн бий болоод, билетийн хүний хувьд бол Бямбацогт дарга бол ерөнхий хариулчих байх. 1 компани давамгайлна гэсэн ойлголт бол байхгүй. Өнөөдөр бол нэг ойролцоогоор 1200000-2000000 төгрөг бол хямдхан байгаа. Энэ “Эрчис ойл” компани болоод хувийн компаниудын юу бол хямдхан байгаа.

Цаашдаа “Роснефть” компаниас 246 доллар хямдруулна гэсэн ийм захидлыг бол аль хавар ирүүлсэн юм байна лээ. Гэхдээ хуулийг хүлээж байгаа гэсэн үг. Хэрэв хууль батлагдсан тохиолдолд бид буцаад тэр 246 доллароор хямд авах тэр боломжийг бид сэргээж, өшөө сая төгрөгөөр ч юм уу хямдруулах боломжийг хайж ажиллана. Баярлалаа.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт. Зам, тээврийн хөгжлийн сайд.

С.Бямбацогт: Оюунчимэг гишүүн бас чухал асуудал хөндлөө. Өнөөдөр Монгол Улсад нисэж байгаа агаарын

тээврийн зорчигч, ачаа тээврийн үнэ тариф бол дэлхийн зах зээлийн үнээс өндөр байгаа өндөр байгаа. Өндөр байгаа нэг шалтгаан бол шатахууны үнэ. Өнөөдөр онгоцны түлш дэлхийн зах зээл дээр Сингапурын бирж дээр 1 тонн нь 1100 орчим доллар, Монголд үндсэндээ 1700 орчим доллар хувийн компаниуд нийлүүлж байгаа. “Эрчис ойл” төрийн өмчит компанийн байгуулаад өнөөдөр 1 тонн шатахууныг 1350 орчим доллароор нийлүүлж байна. Өөрөөр хэлэх юм бол хувийн компаниудаас онгоцны түлш нийлүүлж байгаа компани бас дунджаар 350-400 доллароор хямдхан. Дэлхийн зах зээлийн онгоцны түлшний бол 1 тонн 1100 орчим. Сингапурын биржийн үнэ.

Тийм болохоор бид нар явал Сингапурын биржийн үнэ рүү дөхүүлсэн үнэтэй шатахуун хэрэглэх вэ? Өөрөөр хэлэх юм бол өнөөдөр хувийн компаниуд нийлүүлж байгаа хүнээс 500 орчим долларын хямдхан шатахуун нийлүүлэх юм бол билетийн үнэ маань бас тодорхой хэмжээгээр буурах бололцоотой. Нэг үндэслэл. Өнөөдөр нийт онгоцны нислэгийн зардлынх нь 28-46 хувь нь шатахууны зардлын үнэ болж байгаа. Шатахууны зардлын үнэ.

Тийм болохоор 1 тонн шатахуунаа бид нар 300-500 орчим доллар буулгаад байх юм бол энд билетийн үнэ бол 8-10 гаруй хувиар буух бололцоотой гэж харж байгаа. Энэ бол бас хангалттай биш ээ. Тэгэхэд тийзийн үнийг буулгахад шатахууны үнийг буулгах асуудал бол нэгдүгээр үндсэн бодлого.

Хоёрдугаарт нь бид нар энэ төмөр замаар зорчиж байгаа зорчигч тээвэр дээр нийтийн тээврийн хот хооронд зорчиж байгаа зорчигч тээвэр дээр нэмэгдсэн өртгийн албан татвараа төлдөггүй, авдаггүй. Тэгвэл агаарын тээвэрт бид нар 10 хувийн нэмэгдсэн өртгийн татвар төлж байгаа. Энэ нэмэгдсэн өртгийн албан

татварыг бас нийтийн тээвэр болон төмөр замын зорчигч тээвэртэй адилхан нэмэгдсэн өртгийн албан татваргүй болгочих юм бол тийзийн үнэ дахиад 10 орчим хувиар буурах бололцоотой болно.

Гуравдугаарт нь бид нар Улаанбаатар хотын нийтийн тээвэрт жилдээ 180 орчим тэрбум төгрөгийн татаасыг төлж байгаа улсаас. 200 тэрбум төгрөгийн автобус компани орлого олдог. 200 тэрбум төгрөгийн орлогынх нь 20 тэрбумыг нь иргэд төлдөг. Үлдсэн 180 тэрбум төсвөөс, төрөөс төлдөг. Тэгвэл бас агаарын тээвэртэй биднүүс тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлэх юм бол өнөөдрөөс дотоодын нислэгийн тийзийн үнэ хямдарна. Тийзийн үнэ хямдрахаар тэрийг дагаад үндсэндээ бид нар орон нутагт нисэхгүй байгаа нислэгүүд сэргэнэ. Урьд нь 11 аймагт нисдэг байсан бол хоёрхон аймагт нисдэг болсон. Гаднаас жуулчид ирчхээд Улаанбаатараас түгжрэлээс гараад аялъя, амаръя, зугаалъя, хөдөө байгальд очъё гэхэд аймгууд руу явах гээд тэгэхэд Хөвсгөл рүү, Дорнод руу, Говь-Алтай руу, Завхан руу нисээд очъё, Хөвсгөл нуур үзье гэхэд онгоц байхгүй, явдаггүй. Ийм л байдалтай байгаад байгаа юм.

Тийм болохоор бас Монголд зочлох жил болж байгаатай холбоотой мөн орон нутгийн нислэг сэргээхтэй холбоотой. Үндсэндээ саяын хэлж байгаа 3 цогц арга хэмжээг авч байж тийзийн үнэ хямдарна. Тийзийн үнэ хямдрах юм орон нутгийн нислэг сэргэнэ. Мөн гаднаас жуулчид ирээд хүссэн газар руугаа онгоцоор аялах, зорчих бололцоо боломж бүрдэх юм. Тийм болохоор ганц энэ онгоцны түлшний үнэ буулгах гэж байгаа энэ улс 7.2 бол тийзийн үнийг буулгах нэг нөхцөл. Ингэж та бүхэн бас бодоорой. “Эрчис ойл” компани энэ “Роснефть” компанийн хамтарсан компани байгуулна. “Эрчис ойл” компани 60 хувь эзэмших юм байна лээ. “Роснефть” компани 40 хувь эзэмших юм байна лээ.

Ингээд хамтарсан компани нефть, онгоцны түлш оруулж ирэх юм бол онгоцны түлш өнөөдрийн байгаагаас 300-500 орчим доллар хямдрах ийм л бас бололцоотой гэсэн асуудлыг ярьж байгаа гэж ойлгож байгаа. Тийм болохоор энэ хэмжээгээр тийзийн үнэд нөлөөлнө л гэдгийг бас хэлье. Тонн тутамдаа.

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүн тодруулъя.

М.Оюунчимэг: Сая эдийн засгийн үзүүлэлтийг сонсоход бол энийг дэмжихэд бэлэн байна. “Эрчис ойл” компани өөрөө төрийн өмчит компани маань 60 хувь, Орос 40 хувь гээд тэгж байгаа юм байна л даа. Тэгээд энэ хуульд өөрчлөлт оруулснаар “Эрчис ойл” компани нь яг үйл ажиллагаагаа шууд явуулаад эхлэх юм уу? Одоо яг энэ компани хэдэн хүнтэй, байгуулаад үйл ажиллагаагаа явуулж байгаа юм уу, явуулаагүй юм уу?. Сая Бямбацогт даргын ярианаас үзэхэд одоогоор 1350 ам.доллараар нийлүүлж байгаа тэгээд энэ бол 350-400 орчим долларын хямдхан байгаа юм гэж байна.

Тэгэхээр одоогоор бол нийлүүлж эхлээгүй байгаа шүү гэж би ойлгож байгаа шүү дээ тээ? Эсвэл нийлүүлээд эхэлчихсэн байгаа юм уу? Эхэлчихсэн байгаа бол энэ хуульд нэмэлт, өөрчлөлт заавал оруулж байж энэ маань өөрчлөлт оруулах юм уу? Тонн тутмаас 246 ам. долларыг хямдруулах бололцоотой гэж хэлж байгаа юм байна. Одоо бол бас 300-350 хямдралтай нийлүүлж байгаа. Тэгээд энэнээсээ илүү дахиад 246 ам. доллароор тонн тутмаас дахиад хямдруулаад явах юм уу? Хэрвээ энэ тохиолдолд нефть бүтээгдэхүүн, дизель түлшний үнэ цаашаа.../минут дуусав./

Г.Занданшатар: 81 “Эрчис ойл” компанийн захирал Ширзана.

З.Ширзана: “Эрчис ойл” компанийн захирал Ширзана гишүүний

асуултад хариулъя. “Эрчис ойл” компани маань 20 оны 4 сард байгуулагдсан. Үүнээс хойш өнөөдрийн байдлаар бол 10 хүний үйл ажиллагаатай явагдаж байгаа. 8 сараас 9 сарын 2-ноос бол дотоодын агаарын тээврийн компаниуддаа бол агаарын түлшийг нийлүүлээд эхэлчихсэн байж байгаа. Яг өнөөдрийн байдлаар болохлоор “Эрчис ойл” компани маань нийт зах зээлийнхээ 60 хувийг бол нийлүүлээд явж байна. Хэрэгцээнийхээ 60 хувь нийлүүлж байгаа. Өнөөдөр зах зээлийн яг өнөөдрийн байдлаар бол Сингапурын биржийн үнэ дээр бол онгоцны тээврийн түлш нь бол 1100 доллартой байна. Монгол Улсад бол яг өнөөдрийн байдлаар “Эрчис ойл” компани бол 1300.../минут дуусав./

Г.Занданшатар: Тодорхой хариулчхаач. Тодорхой тэд тэд гээд хариулж болдоггүй юм уу? Ажлаа мэддэггүй юм уу? Тойроод л баахан улс төр юм яриад байх юм. Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: “Эрчис ойл” компанийн тонны үнэ 4400000 төгрөг байна, хувийн компаниудынх хамгийн бага нь 5500000 төгрөг байна. Эндээс зөрүү нь харагдаж байгаа. “Эрчис ойл” компани, цаашлаад энэ хууль батлагдсанаараа хамтарсан компаниа байгуулаад явна. Тэгээд энэ тохиолдолд би бас түрүүн хэлсэн тэр Оюунчимэг гишүүний асууж байгаа асуулт бол тэр 246 доллароор хямдрах боломжтой юм уу гэхлээр энэ хууль батлагдахыг бас бөөний нийлүүлэгч компаниуд бол хүлээж байгаа гэсэн үг. Тэгэхээр бид энэ дээр ажиллана гэсэн үг. Оюунчимэг гишүүнээ. Ажиллаад, 246 доллароор хямдруулна гэсэн тэр захидал дээр нь үндэслээд буцаад энэ 246 доллар хямдруулсан гэсэн энэ зүйлээ үргэлжлүүлээч гэдэг хүсэлтийг “Роснефть” компанид тавина. Тэр тохиолдолд дахиад 1 сая төгрөгөөр хямдрах боломжтой болох юм.

Ер нь бол зүгээр нэг компани шууд энд монопол болохгүй шүү дээ. Хямд үнэтэй агаарын түлш ороод ирсэн тохиолдолд тэгээд л хямд үнэтэйгээ нийлүүлээд л явах бүрэн боломжтой.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэлийн урилгаар Нийгмийн Ардчилал Монголын эмэгтэйчүүдийн холбооны орон нутгийн гишүүдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт эмэгтэйчүүдээ ажлын амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Гишүүдийн нэрийн өмнөөс.

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууна.

Х.Булгантуяа: Сая Оюунчимэг гишүүн бас нэлээд асуултуудыг нь асуучихлаа. Онгоцны тийзийн үнийн 25-40 хувь нь шатахууны үнэ тэгвэл эзэлдэг юм байна. Монгол Улсад дунджаар 50-60 хувь дэлхийн зах зээлийн Сингапурын биржийн үнээс илүү бид нар үнэтэй шатахуун өнөөдрийг болтол авч байгаа юм байна. Одоо ингээд бид нар хямдхан шатахуун, түлш хэрэглээд эхлэхээр ямар ч байсан 8-10 гаруй хувиар тийзийн үнэ буурна гэж би ойлголоо.

Дээрээс нь нэмээд миний бодлоор энэ 1500-1700-аар та бүхэн авч байгаа үнэ бол Улаанбаатар хотод авч байгаа байх тээ? Тэгэхээр хөдөө орон нутагт дахиад энэ тээвэрлэгдээд очихоор хэдэн хувиар нэмэгддэг юм бэ? Холын аймгуудын хувьд энэ тийзийн үнэ маш их өндөр байна гэж ярьж байгаа. Энэ нь ахиад Улаанбаатар хотод ирснээс цаашаага хэдэн хувь дээрээ очиж тийзийн үнэ дээр нөлөөлдөг юм бэ? Бусад улс орнууд ер нь энэ онгоцныхон шатахууны асуудлыг ер нь яаж шийддэг юм бэ? Төрийн өмчит компани байгуулж шийддэг юм уу? Эс үгүй бол хувийн хэвшлийнхний дунд ийм, ялангуяа Монгол

шиг өөрөө газрын тос эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүй улс орны хувьд ер нь яаж шийддэг юм бэ? Энэ дэлхийн улс орнуудын энэ асуудлыг нэгдүгээрт бас асуух гэсэн юм?

Одоо бол би зүгээр ингэж бодож байна л даа. Одоо бол бас огт өрсөлдөөн байхгүй биш байгаа. Тэрүүн рүү манай хэрэглээ харьцангуй бага учраас нэг их олон компани ордоггүй юм шиг байгаа юм. Олон компани ордоггүй юм шиг байгаа юм. Одоо төрийн өмчит компани байгуулаад хувийн хэвшилтэйгээ өрсөлдөөд үзье гэж байгаа юм байна. Хамгийн хямдхан үнэ, хэрвээ хувийн хэвшил нь гаргавал хувийн хэвшилээсээ авах юм байна. Төрийн өмчит компани нь өгөх юм бол төрийн өмчит компаниасаа авна гэсэн. Ингэж ойлгож байгаа шүү дээ. Зөв биз дээ тээ? Тэгэхээр хувийн хэвшил нь ч гэсэн үүн дээр өрсөлдөх боломжтой юм байна.

Гол сануулж бас хэлэх гэж байгаа нь бид нар чинь төрийн өмчит компаниудынхаа тоог цөөрүүлснэ, засаглалыг нь сайжруулъя гэж бас ярьж байгаа шүү дээ. Тэгээд энэ тал дээрээ та бүхэн маань энэ Төрийн өмчийн тухай, энэ Компанийн тухай хууль Улсын Их Хуралд бас орж ирсэн байна. Засаглалыг нь эхнээс нь сайн байлгах дээр, ил тод байлгах дээр бас энэ салбарын сайд нар та бүхэн маань бас анхаараарай. Бид нар энэ төрийн өмч компани болгоныг байгуулах дээр бодвол сайхан санаж л байгуулж байсан байх. Ямар нэгэн том асуудал шийдэх байх, төр улсад хэрэгтэй байх, түмэн олонд энэ төрийн үйлчилгээг үзүүлэх байх гэж бодож байгуулаад л. Эцэс сүүлд нь дандаа удирдлагууд нь авлигалын хэрэгтэй холбогдоод л янз янзын асуудалтай холбогдоод төрийн нэрийг, тэгээд л эрх баригч, нөгөө намынх нь нэр нь ч гэсэн хамтдаа хутгалдаад явчихдаг учраас үүн дээр бас та бүхэн маань анхаараарай. ТУЗ нь хэрхэн, яаж бас байгуулагдах гэж байгаа

юм бэ гэдэг ийм хэдэн асуудлыг тавих гэсэн юм.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар сайд.

Ж.Ганбаатар: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Манай ер нь агаарын түлшний нийт хэрэглээ ойролцоогоор 110000 хавьцаа байгаа юм. Гэтэл дотоодод сумласан нь ойролцоогоор 46000, 47000-ыг дотоодод сумладаг. Энэ юу хэлж байна гэвэл энэ Korean air-ын онгоц юм уу, эс үгүй бол Туркийн онгоц, энэ Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас ирж байгаа онгоцнууд Монголд сумлахгүй байна гэсэн үг. Дийлэнх нь. Мөн манай онгоцнууд бас дотоодоосоо сумлахгүй, гадаадад очоод сумлаад байгаа асуудал байна. Энэ юу хэлж байгаа юм гэвэл манай дотоод түлшний үнэ үнэтэй байгааг хэлж байгаа юм. Тийм учраас нийт хэрэглээнд 109000 байгаад байдаг, дотоодод сумласан нь 46000, 47000 байгаад байдаг. Тэгэхлээр бид бас судалгааг хийсэн. Булгантуяа гишүүнд хариулахад бол Сөүлд хэдээр сумлаж байна гэхлээр ойролцоогоор 3500000 төгрөгөөр сумлаад байгаа юм. Токиод бас 3500000, Германд 3900000, Станбулд 4000000, Алматад 5.5 сая, Бишкект 5700000 гээд.

Тэгэхлээр бусад улсууд бол энэ ялангуяа нисэхийн энэ онгоцныхоо түлшийг хямдхан байлгаж, их онгоц олон буулгахыг хүсдэг. Бууж байгаа онгоцнууд түлштэй биш, ачаатай, хүнтэй буулгахыг хүсдэг байгаа юм. Тэгэхээр дизель энэ онгоцны түлш хямдхан байснаараа бол юу вэ гэхлээр түлш ачаад нисээд байх биш, ачаа ачиж, хүн ачиж нисэх. Энэ хэрвээ манайд түлш хямдарсан тохиолдолд манайд бууж байгаа онгоцнууд бүгдээрээ манайхаас сумлах боломж бүрдэнэ. Эдийн засгийн хувьд бол ийм ач холбогдолтой болно. Монгол руу ачаа их ирнэ, Монгол руу жуулчин их ирнэ, Монголд ирж байгаа хүмүүсийн тоо нэмэгдэх нь гэж ойлгогдож

болно. Бусад асуудлуудын хүрээнд манай газрын дарга Анхбаяр дарга хариулна дарга. Юугаа өргөөрэй.

Г.Занданшатар: Ганбаатар сайд саяныхаагаа гүйцээгээд хариулчихвал. Яг хэдэн төгрөгөөр буурах вэ? Хэдээр? Буурна гээд тэгсэн шүү дээ. Тэр Япон, Солонгосын төвшнөөс доош буурна гэсэн шүү дээ. Яг хэдээр буурах юм? Энэ хууль батлагдсанаар хэдээр буурах юм? Гишүүд тэрийг сонирхоод байгаа.

Ж.Ганбаатар: 5500000 төгрөг байгаа. Хувийн компаниуд. Манайх бол 4400000 төгрөгөөр сумлаж байна. Тэгэхлээр энэ хууль батлагдсанаараа бид нар 246 доллароор хямдруулна гэдэг тэр захидал дээр ахиад ажиллана гэсэн үг. Тэгэх юм бол ойролцоогоор 800000-1000000 төгрөгийн хямдралыг хууль эцэслэн батлагдсанаараа. Манай яамны ажиллагаа цаад компанийн хариултаас шалтгаалаад бид хямдруулах бүрэн боломжтой гэж хариулъя. Ойлгогдсон байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Хэн нэмж хариулах уу? 83.

Б.Анхбаяр: Газрын тосны бодлогын газрын дарга Анхбаяр. Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Түүрүүн асуусан 1500-1700 долларын өртөгтэй байгаа гэсэн. Энэ болохлоор яах вэ, сар болгон өөрчлөгддөг үнэ. Энэ бол Сингапурын биржээс ирдэг. Энэ үнийг болохлоор бид нар хил нөхцөлөөр авч байгаа юм. Хил нөхцөл гэдэг нь юу вэ гэхлээр Наушик болон Сүхбаатар хил дээр авдаг. Эндээс наашаа тээвэрлэлтийн зардлууд, бүр нисэх онгоцны буудал дээр ирэх бас тээвэрлэлтийн зарлалууд бас нэмэгдэж яг сумлах нэгж үнэ маань бол гардаг. Дээрээс нь засаглалыг сайн болгох талаар асуусан. Засаглал гэдэг нь болохлоор 2020 онд анх “Эрчис ойл” компанийг бол Засгийн газраас байгуулсан.

Засгийн газраас байгуулахдаа бол Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн охин компани байдлаар байгуулсан байгаа. Тэгэхлээр газрын тос боловсруулах үйлдвэрийн төлөөлөн удирдах зөвлөл маань давхар “Эрчис ойл”-ын асуудлуудыг бол хамааруулаад явдаг. Үндсэндээ бол бид нар бас төрийн хэмнэлтийн асуудлыг бас тодорхой хэмжээнд авч үзэж, 9 гишүүнтэйгээр төлөөлөн удирдах зөвлөл маань “Эрчис ойл”-ын асуудлыг бас давхар хамаараад явж байгаа.

Г.Занданшатар: Яг хэдээр бууруулах вэ гэдгээ тодорхой.

Б.Анхбаяр: Түрүүн манай сайд маань бас тодорхой хэлсэн.

Г.Занданшатар: Яг хэдээр? Протоколд тэмдэглэж үлдэх ёстой. Чи яагаад хэлэхгүй байгаад байна? Яагаад үнэ хэлэхээс болгоомжлоод байгаа юм? Яг тодорхой сая тоо хэлчихлээ шүү дээ. 83 яагаад хариулахгүй байгаа юм бэ чи?

Б.Анхбаяр: Хамтарсан компани байгуулагдсанаар үндсэндээ бол бид нар цаашдын орж ирж байгаа бүтээгдэхүүн дээр улам үнийг бууруулах бодлого баримтална. Яагаад гэхлээр ер нь “Роснефть” гэдэг маань өөрөө үйлдвэрлэгч компани. Үйлдвэрлэгчийн үнээр ерөнхийдөө бас наашаа орж ирэх боломжтой болно гэсэн үг. Тэгэхлээр түрүүн сайдын хэлсэн 245 доллар бүр цаашлаад зах зээл сайжирсан тохиолдолд энэнээс ч бас буурах боломжийг бас бид нар Монголынхоо талаас бүрдүүлэх талаар хамтарч ажиллана. Хамтарсан компани байгуулагдсанаар 60 хувийг бол Монголын тал эзэмшинэ, 40 хувь бол “Роснефть” компанийнх гэдэг утгаараа бас саналын дагуу.

Г.Занданшатар: Хэдэн хувиар буурах юм бэ? Сая тоо хэлчхээд байна шүү дээ сайд чинь. Яг та нар болохоор ингэж.

200-500 доллар гэсэн шүү дээ. Яг мэргэжлийнх нь улсууд сүүлд нь сайд нартаа ингэж хэлүүлчхээд өөрсдөө үлдчихдэг байхгүй юу. Чи яг тоогоо хэлээд байх. Тэгэхлээр сайд нарт та нар л хэлж өгсөн байгаа шүү дээ. 200-500 доллар гээд хэлчихсэн. Сайд чинь хэлчихсэн. Одонгийн Цогтгэрэл гишүүн асууна. Дараа нь амыг нь асууна.

О.Цогтгэрэл: Шинэ нисэх буудлын шатахууны хангамжийг нэг компанид хамтарсан компанид монопол эрхтэй өгснөөр шатахуунаа хямд үнэтэй авах гэж байгаа юм гэсэн товчхон утга санаатай хууль орж ирж байна л даа. Тэгэхээр одоо энэ компани чинь үндсэндээ бараг 100 хувь монопол нийлүүлдэг юм байна. 1600-аар ч гэнэ үү. Хамтарсан компани байгуулаад монопол эрхээ өгчихөөр 200, 300, 500 доллароор хямдрах юм байна гэж байна.

Тэгэхээр энэ яг энэний цаана эдийн засгийн, миний ухаан хүрэхгүй байна л даа. Эдийн засгийн яг ямар утгатай байгаа юм? Одоо зүгээр 100 хувь нийлүүлээд, өгч байсан үнээсээ монопол эрх өгчихөөр хямдруулъя гэдэг чинь энэ эдийн засгийн санал уу, улс төрийн санал юм уу энэ? Одоо өгөөд ашиг олоод явж байгаа үнээсээ монопол эрхээ өгчихөөр чинь хямдруулъя. Энэ чинь тийм эдийн засгийн ямар ч, та нар онгоцны үнэ, тийз хямдарна гээд байна. Эдийн засгийн утга энэ чинь харагдахгүй байна шүү дээ. Одоо 100 хувь нийлүүлж байгаа компани.

Тэгэхээр энэний чинь цаана Монгол чинь өөрөө далайд гарцгүй, авто замаар хоёрхон улстай хиллэдэг. Авто зам, төмөр замаар хэлдэг. Үлдсэн ганц зам нь агаарын зам. Агаарын замыг нь дахиад нэг хөршдөө бэлэглэж байгаа юм биш үү? Түлшгүй хэдэн онгоцтой болох гээд байгаа юм биш үү? Тэр рүү хийх түлшийг саяын хоёр хөршийн маань нэг нь мэддэг. Энэний чинь цаана яг эдийн засгийн утга ер нь байна уу?

Дахиад дээрээс нь агаарын тээврийг либералчилна гэдэг том мөрийн хөтөлбөрт танай намын мөрийн хөтөлбөрт болоод засгийн чинь мөрийн хөтөлбөрт байгаа. Аливаа салбарыг либералчилна гэдэг чинь энэ салбарт оролцож байгаа оролцогчдыг өрсөлдөөнийг нь нэмж, илүү чөлөөтэй болгоно гэсэн утга санаа цаана нь явж байгаа. Тэгэхээр нэг олон улсын санхүүд орж байгаа, хоригт орж байгаа улсын 1 компани хамтарсан худалдааны компани байгуулаад улам энэ чинь тийм чөлөөлөлтийн эсрэг монополийн тухай зүйл яригдаад байна шүү дээ. Нөгөө мөрийн хөтөлбөрийн либералчлал энэ тэр гээд олон зүйл чинь хаачихав?

Тэгээд эндээс ганц, хоёрхон бараг ганцхан асуулт л байгаад байна л даа. Энэний цаана миний хувьд зүгээр энэ эдийн засгийн ямар ч утгагүй байна. Зүгээр л улс төр юм уу? Өөр зүйл үнэртэж байна. Та нар яг бодит байдлыг хэлээч. Ингэж монопол Монголын агаарын орон зайд ямар ямар улс, ямар онгоц нисэхийг, нисэх, нисэхгүй байхыг бараг шийдэх энэ эрхийн тухай яриад цаана нь яваад байна уу? Нөгөө талдаа энэний цаана тийм бусад шатахуун түлш дээр ийм дарамт шахалт байгаа юм уу? Ингэвэл хямд өгнө гээд байгаа юм уу? Ингэхгүй бол шатахуун өгөхгүй гээд байгаа юм уу? Ингэхгүй бол шатахуун өгөхгүй гээд байгаа юм уу? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар сайд хариулна. Энэ компанид 100 хувь одоогоор хангаж байгаа юм байхгүй Цогтгэрэл гишүүнээ. Би танд 9 сарын 1-нээс 10 сарын 31-ний хооронд энэ 2 сарын хугацаанд “Мэргэ ван” гэж компани 29 хувийг нь нийлүүлсэн байна. Энэ “Авиашин фүел” гэж компани 24 хувийг нь нийлүүлсэн байна. Үлдсэнийг нь “Эрдэс ойл” компани нийлүүлсэн гэсэн үг. 47, 8 хувь байх шүү. Тэгэхлээр өнөөдөр энэ компани монополюор 100 хувь нийлүүлээд

байгаа юм бол байхгүй. Тэрнээс гадна өрсөлдөөд л оруулж байгаа юм. Жинхэнэ таны хэлж байгаа либералчлал бий болж байгаа энэ дотор. Өрсөлдөөн бий болж байгаа юм. Нийлүүлж байгаа компани 1 биш. Танд би нийлүүлж байгаа компаниудыг нь хэлье. “Роснефть”, “Газпром”, “Янсик”, Ди Ви ойл, Гүнвор, Trafigura.

Эдгээр компаниудаас авч байна. Авах бүрэн боломж бий. Айн? Бүгд Оросоос. Үгүй, тэгээд яагаад хямдхан нисэж болохгүй? Бид нар яагаад байна шүү дээ хямд онгоцныхоо түлшийг хямд нийлүүлээд, билетийнхээ үнийг буулгуулах ажил хийж байж энэ чинь бодитойгоор хямдарна гэж байна шүү дээ. Энэ яагаад танд өөр сонсогдож байгаа юм? Та харин яагаад, та ер нь бол энийг маш сайн ойлгох ёстой хүн. Ардчилсан нам дотроос бол хамгийн сайн ойлгох ёстой хүн нь та. Тэгэхлээр би хэлж байна шүү дээ. Энэ чинь харин бол монополийг задалж байгаа юм. Өмнө нь харин монопол байгаад билетийн үнэ өндөр, орон нутгийн онгоцнууд нисэхэд хүндрэлтэй байсан, манай онгоцнууд гадаадад очоод сумладаг байсан бол энийг чинь харин бид задалж байна шүү дээ. Танд би бол энэнээс өөрөөр яаж ойлгогдохыг би бол ойлгохгүй байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн, сайд хариулъя.

С.Бямбацогт: Цогтгэрэл гишүүн бас ойлгох ёстой. Мэдээлэл бас багатай байж магадгүй. Урьд нь монопол болоод хэтэрхий өндөр үнэтэй, дэлхийн зах зээлийн үнээс 500-700 долларын илүү үнэтэй. 1000 байсан бол 1500, 1700 долларын үнэтэй шатахуунуудыг хэтэрхий монопол цөөхөн компаниуд маань бас үгсэн хуйвалдаж нийлүүлдэг байжээ. Үүнийг задлахын тулд өнөөдөр төрийн өмчит компани байгуулаад тэр компани нь дөнгөж 22 онд үйл ажиллагаа явуулж

эхэлсэн. “Эрчис ойл” компани тийм үү? Энэ жил үйл ажиллагаа эхэлсэн тийм ээ? Тэгээд энэ жилийн 8 сараас. Энэ богинохон хугацаанд хямд үнэтэй тэр 1 тонн нь 1700 байсан онгоцны түлшийг 1340 болгочхож, тэгэнгүүт зах зээлийн 60 хувийг эзэлчихжээ. Нөгөө авиа компаниуд чинь бүгдээрээ хямд үнэтэй шатахуун руу яваад 60 хувийг нь эзэлчихсэн байж байна.

Одоо энэ хууль ороод ирэх юм бол, энэ хуулийг баталчих юм бол түрүүн Ганбаатар сайд хэлсэн, бас хэн хэлсэн. Манай уул уурхайн яамныхан. “Роснефть” компанийнхан тийм үү, өшөө дахиад 1350-аас нь доош нь үнийг 200 гаруй доллароор буулгах асуудал урьд нь бол мэдэгдэж байсан. Энийг цаашид хэлэлцээрээр шийднэ гэж байгаа юм. Энийг бид нар одоо байж байгаа хувийн компаниудын үнээс түрүүн ярьсан тийм үү? 300-500 доллар хүртэл буулгах бололцоотой болно гэж. Ийм байдлаар үндсэндээ бол өрсөлдөөнийг дэмжээд байгаа юм. Өрсөлдөөнийг. Өрсөлдөөн бий болгох гээд байгаа юм. Өрсөлдөөн бий болж байж үнэ хямдарна, үнэ хямдарч байж ард талд нь нөгөө тийзийн чинь үнэ хямдарна.

Гэхдээ тийзийн үнэ чинь хямдрахдаа би түрүүн хэлсэн шүү дээ. Тоонуудыг манай Мөнхнасан дарга нэмээд хэлээд өгчих. Манай авиа компаниуд агаарын тээврийн либералчлал хийгдэж байгаа. Авиа компани урьд нь ерөөсөө зорчигчоосоо илүү онгоцны түлшээ хямдхан авчирдаг. Сөүлээс тийм үү, Бээжингээс, Москвагаас яагаад гэвэл түлш хямд учраас онгоцныхоо ачааны дийлэнхэд нь түлшээ ачиж ирдэг байсан. Энэ тоонуудыг хэлээд өгчих. Хэдэн жил тэгж явсан юм? Агаарын тээврийн лебаралчлалын хүрээнд 19 онгоцтой байсан бол сүүлийн жил гуравхан сарын хугацаанд үндсэндээ МИАТ 1 том онгоцтой боллоо. “Изинэс” компани бас том онгоц оруулж ирлээ. Өнөөдөр

“Mongolia airways” компани 2 бас Airbus 320 онгоц оруулж ирж байна.

Ийм байдлаар үндсэндээ бол агаарын тээврийг лебралчлах байдлын хүрээнд манайхан бол онгоцнууд оруулж ирж байна. Бас олон чиглэлд, олон улс руу нислэгүүд сэргээх бодлого барьж байгаа. Ингэхэд бас онгоцны түлш хямдхан байх нь Монголын иргэд гадагшаа аялахад, жуулчлахад, мөн гаднаас олон жуулчин ирэхэд бас энэ тийзийн үнийг хямдруулах бодлогыг бид барьж байгаа. Энэ хүрээндээ гаднын авиа компанийг дэмжинэ, дотоодын авиа компаниудаа ч гадагшаа нисэх бололцоо, боломжийг бий болгоно. Орон нутгийн нислэгээ сэргээх бас бодлого бас давхар явж байгаа юм. Үүнд бас энэ шатахууны үнийн хямдрал, онгоцны түлшний үнэ хямдруулах бас чухал нөлөөтэй юм.

Өнөөдөр Увс руу нисэхгүй байгаа шүү дээ онгоц. Орон нутгийг сэргээмээр байна. Яагаад гэвэл үнэтэй учраас хүн нисэхгүй байна. Яагаад билет үнэтэй байгаад байна? Онгоцны түлш тодорхой хэмжээнд нөлөөлж байна. Гэхдээ онгоцны түлш нэг шалтгаан нь. Үүнээс гадна би түрүүн хэлсэн. Тэр нэмэгдсэн өртгийн албан татвар, бусад салбаруудаас нь авдаггүй. Агаарын тээврийн салбаруудаас нь. Энэ дээр анхаарах хэрэгтэй байна. Бусад салбартаа тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлдэг мөртөө бид үзүүлэхгүй байна. Иймэрхүү юмнууд яриад Цогтгэрэл гишүүн жоохон анхаараад өгөөч. Тэгэх юм бол Увс руу ард иргэд чинь хямдхан үнээр нисдэг болчих гээд байна. Гадаад руу Монголчууд маань бас хямдхан үнээр нисдэг болчих гээд байгаа юм. Энэ талаас нь та хараад өгөөч.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууна.

О.Цогтгэрэл: Үгүй ээ, би үнсэндээ асуусан асуултад хариулт авсангүй л дээ. 1

улсаас 3 компани оруулж ирээд 1600-аар зардаг байсныг монопол болгоод гэхээр цаад улс чинь яг хямдруулаад яг ямар өгөөж хүртэх гээд байгаа юм бэ? Тэр нь ойлгомжгүй. Энэний цаана чинь нэг тийм эдийн засгийн биш харилцаа харагдаад л байна л гэж л асуусан л даа.

Нөгөө талдаа тэр түрүүний асуулт. Энэний цаана чинь өөрөө улс төрийн шахалт дарамт байна уу? Ингэхгүй бол нефть бүтээгдэхүүн нийлүүлэхгүй гээд байгаа юм уу? Илүү үнэтэй өгнө гээд байгаа юм уу? Энэ зүйл байна уу? Энэ дээр дахиад тодруулаад өгөөч. Өөр энэ ажлын хэсгийн болоод энэ хүмүүсээс нэг асуухад тэр Дорноговийн нефть боловсруулах үйлдвэр энэ худалдааг нь хариуцах гээд байгаа юм уу? Танилцуулга дээр тийм юм байна лээ. Тэнд нэг нефть боловсруулах үйлдвэрийн төсөл гээд явж байсан баг энд олон улсын худалдаа эрхлэх гээд байгаа ч юм шиг. Тийм танилцуулга харагдсан. Тэгэхээр энэ чинь өөрөө эдийн засгийн төрөлжилт, олон утга санаагаараа тэнд нэг өөр утга санаатай төслийн баг. Энэ бол эдийн засгийн бас.../минут дуусав./

Г.Занданшатар: Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Зүгээр яах вэ, бөөний нийлүүлэгч энэ салбарт орж ирэхийг хорьчихсон байсан. Тэрийг л нээж байгаа юм. Гэхдээ жижиглэн худалдааны салбарт бөөний нийлүүлэгч орж ирэх хориотой хэвээрээ байгаа. Жижиглэн худалдаа гэдэг нь колонкууд А92 дизель, А80, 95 дээр гэсэн үг. Цаашдаа тийм зүйл болохгүй гэдэг дээр баталгаатай хэлье. Тийм юм байлгахгүй.

Мэдээж агаарын тээвэр дээр бид ямар бодлого барьж байна гэвэл жуулчин их ирүүлмээр байна. Орон нутаг руу онгоц нисүүлмээр байна. Манай онгоцнууд дотоодоосоо сумламаар байна. Бусад улстай өрсөлдмөөр байгаа юм. Ийм

үүднээс манай тавьсан хүсэлтийн дагуу л явж байгаа ажил. Түүнээс биш “Роснефть” компани өөрсдөө хүсээд энэ юм яваад байгаагүй. Бид агаарын түлшээ хямдруулах хэрэгтэй. Би түрүүн японы үнийг, Солонгосын үнийг зүгээр ч нэг уншиж өгөөгүй. Дизель түлш нь болоод тэр машиных нь бензинүүд нь үнэтэй байдаг бүр. Та бол сайн мэдэж байгаа. Харин агаарын түлш нь хямдхан байдаг. Энэний цаана.../минут дуусав./

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн асуулт асууя.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гэнгүүт нь бас баярлаад энэ шатахуун түгээх станцуудад дизелийн түлш, бензин хямдрах юм байна гэж ингэж бодолтой орж ирсэн. Тэгээд ганцхан өгүүлбэр байна. Нисэх онгоц, онгоцны бензин яриад л явчихлаа. Би та нарт нэг юм сануулахгүй бол ерөөсөө болохгүй нь. Саяхан энэ 16 онд дизелийн түлш 1400-хан төгрөг байсан. Тэр үед Монголыг дууслаа, сүйтгэлээ, дизелийн түлш өсчихлөө, 1600 болчихлоо гээд орилоод байсан. Өнөөдөр 2 дахин илүү, 3 дахин өсчихсөн байна. Түгжрэлд зарцуулж байгаатайгаа нэмэх юм бол 4 дахин өсчихсөн байна. Тэгээд 16 оноос ч хойш өнөөдөр 6, 7 жил болчихсон байна. Яагаад арга хэмжээ авдаггүй юм? Яагаад өнөөдөр энэ хууль орж ирж байгаа юм? Даараад байна. Дан дээлтэй болохлоор болохгүй байна, давхар дээлтэй болохоор болно гээд. Янз бүрийн л улс төрийн шалтгаанууд хийгээд байдаг.

Тэгээд өнөөдөр энэ чинь танай бүлэг дэмжихгүй байна шүү дээ. Хүчээ нэгтгээд өгөөч, бид нар алаад өгье гэсэн. 16-20 онд 65-ын бүлэг, 20-24 онд 62-ын бүлэг байна. Тэгээд хууль орж ирэнгүүт танай бүлэг дэмжихгүй байна шүү дээ. Энэ 10 хүрэхгүй хүн. Сүүлийн орж ирж байгаа бүх хуулиудыг 10 хүрэхгүй хүн манаж

суудаг. Сайд нар нь гуйдаг юм уу, Байнгын хороо нь гуйдаг юм уу, яадаг юм? Ингээд өөрсдийнх нь бүлэг нь хүч нэгдчихээд байгаа бодлого нь дэмжихгүй байхад орж ирээд ингээд зүтгүүлээд байх хэрэг байгаа юм уу? Энийг орж ирсний дараа, энэ хуулийг батлагдсаны дараа тэр хөдөө байгаа портерын, бонгоны дизель түлш хямдрах юм уу, хямдрахгүй юм уу гэсэн асуудлыг л ярих нь зүйтэй байх.

Өнөөдөр Монгол Улс газар нутгаараа 1 хүнд оногдохоор дэлхийд 1 гэдэг шиг 1 хүнд оногдох шатахуун түгээх станцаараа бараг дэлхийд 1 байх. Бараг хаашаа л явбал шатахуун түгээх станц. Хаашаа л явбал төөрмөөр олон шатахуун түгээх станц байна шүү дээ. Тэнд хамгийн өндөр үнэтэй түлшээр портер, бонгогоо, хадлан гэжээлээ, нүүдэл суудлаа хийж чадахгүй байхад өнөөдөр онгоцны түлш яриад л, онгоцоор явдаг хүмүүсийн чинь амьдрал шал өөр амьдралтай, идэш, хоолоо залгуулж чадахгүй байгаа, түлээ нүүрсээ ойртуулж чадахгүй байгаа хүмүүсийн түлшийг ярих энэ асуудал байж байна.

Дээр нь нэг зүйл байгаа юм. Ерөнхий сайд чинь бодлогоо хэлээд байгаа шүү дээ. Төрийн өмчийг задална. Энэ либералчилна гээд. Тэгтэл өнөөдөр энэ хууль чинь төрийн өмчийн 1 компанид давуу эрх олгоно, монополчлоно. Та нар ер нь юу юм, бусад нь ер нь юу юм? Тэгээд төрийн өмчид өгөөд яасан юм? Тэр Хөгжлийн банк юу болсон юм? Тэр нөгөө Нийгмийн даатгалын сан юу болсон юм? Тэр долларын ханш юу болсон юм? Монгол банк чинь. 16 оноос хойш бид нарыг хүч нэгтгээд өгвөл, бид нарыг сонгоод өгвөл бид нар ёстой гайхамшгийг үзүүлнэ гэсэн. Бүр алиагаа алдаад Их Хурал нь ч хуралдаж чадахгүй, Засгийн газар нь Ерөнхий сайдынхаа эсрэг бодлого сайд нар нь оруулж ирж байна шүү дээ.

Тэгээд өнөөдөр ингэснээрээ өнөөдөр энэ дизелийн түлш буурах юм уу,

энэ асуудалд ярь л даа та нар. Монгол Улсын 360 гаруй сум, 1000 гаруй баг, хороо, хөдөөгийн хоёр, гурван мянган өрхөд дизелийн түлш буурах уу, үгүй юу гэдэг юмыг ярих болохоор зэрэг төрийн өмчийн 1 монопол компанид хууль гаргуулан асуудлыг шийдье, ингээд жоохон та нарын тийз чинь буурч магадгүй гэж. 16 онд гадагшаа явж байсан тийз 2-3 дахин өсчхөөд байгаа. Одоо буурах уу гэнгүүт нэг мэргэжилтэн нь болонгуут 230 доллароор буурч магадгүй, сайд нь болонгуут 300-500 доллароор буурч магадгүй гээд ингээд ямар ч бодлогын биш хуулийн төсөл байна. Тийм учраас энэ хуулийн төслөө татаж аваач. Үгүй бол иж бүрнээр нь оруулж ирж ярилц.../минут дуусав./

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар гишүүн хариулья.

Ж.Ганбаатар: Батсуурь гишүүнд жоохон чангахан хариулчих гээд байдаг. Жоохон татаж хариулья даа. Би нэгдүгээрт энэ хууль өнөөдөр орж ирээгүй Батсуурь гишүүнээ. Энэ хууль чинь анхны хэлэлцүүлэг нь. Үгүй ээ, энэ чинь анхны хэлэлцүүлэг шүү дээ. Хэлэлцэх эсэх нь аль 3 сард шийдэгдсэн. Дэмжиж байна. Тийм, та хариултаа сонсох уу? Би таныг ярьж байхад бол яриагүй гэдгийг бас соёлтойгоор хэлье. Ам гараагүй. 3900 төгрөг байгаа дизель түлш. Доллароор бодоод үзээрэй. За ойлгож байгаа. Хөдөөгөөр 4200, 300 байгааг мэдэж байгаа. Тийм. А92 2400 төгрөг байгаа. Хамгийн хямдхан байгаа шүү.

Ер нь бол дэлхийд хамгийн хямд түлш хэрэглэж байгаа. Та бүхэн өөрсдөө тэгээд намайг буруу хэлсэн бол намайг няцаагаарай. Би уурлаж хүлээж авахгүй. Үгүй ээ, үгүй 6000-ыг яриагүй байна.

Тэгэхлээр энэ хуулийг бол тэр 4 сард хэлэлцсэн шүү. Өнөөдөр хэлэлцээгүй гэдгийг хэлье. Тэрнээс гадна энэ дизель түлш дээр үүсэж байгаа асуудлыг Оросын

Холбооны Улсын дотоод нөхцөл байдалтай уяхаас өөр арга байхгүй шүү дээ. Та өөрөө маш сайн мэдэж байгаа. Оросын Холбооны Улсын дотоод нөхцөл байдлаас шалтгаалаад манайд нийлүүлдэг “Ангарскийн” үйлдвэрийн дийлэнх ачаалал баруун тал руугаа байна. Төмөр замын асуудал байна. Зүгээр яах вэ, шүүмжлэх гэсэн байдлаар асуудалд хандвал хэн ч ярьж чадна л даа.

Тэгэхлээр дэлхийн зах зээл дээр энэ дизель түлш болоод А92 бусад А95, бусад түлшнүүдээс бол манай улс хамаагүй хямд байгаа. Тийм биш байна гээд надад тоо, баримт гаргаад өгвөл бид бас хүлээн зөвшөөрнө Ганбат гишүүнээ. Би юмыг хүлээн зөвшөөрдөг шүү дээ. Тийм, таныг ярих гэж байгааг ойлгож байгаа. Та бүхнийг тухайн үед ярьж байхад бол долларын ханш хамаагүй өөр байсан байх. Өнөөдөр бол ер нь тэр үетэй адилхан байгаа. Тэгээд Батсуурь гишүүнд хариулж байгаа юм. Ер нь бол зүгээр 1 компанид зориулчихсан асуудал байхгүй шүү дээ. Зүгээр энэ бол чөлөөт өрсөлдөөнийг бий болгож байгаа юм. Ганцхан үгтэй шүү дээ. Ганцхан үгтэй тэр хуулийнхаа өгүүлбэрийг л унш л даа. Тэнд чинь тийм 1 компанид монопол болгуулна гэсэн тийм үг, өгүүлбэр бол байхгүй.

Манайх тэгээд Оросын Холбооны Улсын ганцхан компаниас импортолдоггүй шүү дээ. Би түрүүн хэлсэн. Тэр “Газпром”, “Янстик”, “Ди Ви ойл”, “Гүнвор”, тэгээд өчнөөн олон компаниудаас импортлох боломжтой. Тэрнээс гадна хувийн компаниуд өөрсдөө дотоод зардлаа хэмнээд, эс үгүй бол эх үүсвэрийнхээ зардлыг багасгаад нийлүүлэх бүрэн боломжтой. Хэнийг ч хаагаагүй, хэнийг ч боогоогүй. Наад хууль дотор чинь хаасан, боосон 1 ч өгүүлбэр байхгүй. Зөвхөн нээж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Зааланд бол 10 биш, 20 гаруй гишүүн байгаа. Гэхдээ

цайны цаг болсон учраас, ирц сул байгаа учраас хойшлууллаа. 14 цагаас асуулт, хариулт явуулъя. Энэ гишүүд чинь хүн цөөхөн байна гээд байна. Яг 14 цагаас асуулт хариултаа эхлээд, тэгээд ирцээ бүрдүүлээд санал хураалт явуулан шүү. Завсарлалаа.

13.24 цаг

*Пүрэв гараг 01 Аравдугаар сар 2022
Төрийн ордон “Их хуралдай” танхим*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Одонтуяа: Хуралдаанаа эхлүүлье. Ажлын хэсгийнхэн орж ирнэ үү. Ажлын хэсгийн гишүүдийн нэрс. Ажлын хэсгийнхэн орж ирсэн байна. Одоо Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Энэ газрын тосны үйлдвэр байгуулахад юу саад болоод байна? Ер нь гадагшийгаа нэлээн газрын тос, хулгайгаар гарч байна гэсэн үг гараад байна. 2 сая тонн гээд. Энэ нь үнэн үү? Энэ талаар шалгаж үзсэн үү? Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт, энэ шатахууны үнэ өндөр байгаатай холбоотой баруун аймгуудад онгоцны тийз бас өндөр үнэтэй байна. Нэг тал нь гэхэд 850000. Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан энэ аймаг үнэхээр хэцүү байна. Энэ талаар Зам, тээврийн сайд, энэ холбогдох яамдын сайдууд ямар бодолтой байна ер нь? Үнэхээр хүндрэлтэй байна. Сая 50-аас дээш насны хүний зардал 50 хувь буурлаа гээд ярьж байгаа. Гэтэл энэ асуудал дээр бас нэлээн юм яахгүй бол болохгүй нь.

Яагаад гэвэл хүнд өвчтөн тээвэрлэх асуудал дээр. Зүрхний шигдээстэй, тархины цус харвалттай хүн тээвэрлэхэд 4 хүний суудал аваад явдаг. Тэгээд 4-5 сая нэг талын зардал нь гарч байна. Ард иргэд

энийг ерөөсөө даахгүй байна. Зээл авч байна. Зээл ч банкнуудаар олгогдохгүй байна. Ийм учраас энэ онгоцны тийзийг бууруулах шаардлагатай байна. Энэ талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байна уу Зам, тээврийн сайдаа?

Хоёрдугаарт энэ Баян-Өлгий, сая би энэ хил, гааль, боомт, нүүрс тээвэрлэлтийг шалгах ажлын хэсэгт орсон. Цагааннуур боомтоор ороод яг хилээс орж ирж байгаа шатахууны үнийг авсан юм. Тэгэхэд орж ирж байгаа бензин 2200 хэдээс 2370 хооронд орж ирж байгаа. Гэтэл яг аймгийн агуулахад бууж байгаа үнэ шүү дээ энэ чинь. Галиас авсан баталгаат мэдээ байгаа.

Гэтэл аймагт цаанаас 2 газраас орж ирж байгаа юм байна лээ. 2700 байна аймгийн төвд, хөдөө сумдад 3000. Зарим газар 4500 дизелийн түлш. 5000 хүрчихсэн ийм байдалтай байна. Энийг буулгах ямар арга байна? Одоо энэ хотоос алслагдсан гэдэг Өлгийг тэгж ярьж байгаа мөртөө цаанаас 2 газраас орж ирж байгаа шүү дээ. Энийг буудах арга байна уу? Алслагдсан сумдад энэ шатахууны үнэтэй холбоотой 1 тонн нүүрс 260000 Булган суманд. Аймаар үнэтэй байгаа биз? 1 тонн нүүрс чинь 260000 хүрчхээд байна шүү дээ. Ард, иргэд энийг ёстой даахгүй байна. Нүүрс авч чадахгүй байна. Булган суманд зуд нүүрлэхсэн, цас орчихсон, нүүрсээ авч чадахгүй ийм хүнд байдалтай байна. 5 тонн нүүрс авлаа гэхэд 1300000-1400000 төгрөг хүрч байна. Энэ талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байна уу? Энэ дизелийн түлшний үнийг бууруулах ямар арга хэмжээ авч байна? Энэ талаар асууя.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Зам, тээврийн сайдаас эхлээд асуусан. Дараа нь нэмээд ажлын хэсгийнхэн хариулаарай.

С.Бямбацогт: Бейсен гишүүн бас чухал асуудал хөндөж байна. Ер нь бол алслагдсан аймгууд руу онгоц нисдэг. Онгоцоор бол олон иргэд маань бас

зорчдог. Гадаад, дотоодын жуулчдаас байгалийн сайхантай, ард иргэдийн зан заншилтай, түүх, өв соёлтой танилцах гээд олон чиглэлээр бас онгоц нисдэг байсан. Харамсалтай нь тийм биш болчхоод байна. Яагаад ийм биш болчхоод байна гэхээр үндсэндээ бол агаарын тээвэрлэгч хэдхэн компани байж байгаа. Ялангуяа “Ageo Mongolia” компани, “Hunnu Air” компани бол орон нутагт бол маш сайн нисэж байгаа. Энэ 2 компани л жоохон ачаа үүрч байна. Яагаад бусад компани нисэхгүй болохоор онгоцны шатахуун үнэтэй, төрөөс ямар нэгэн дэмжлэг байхгүй. Ийм болохоор, ашиггүй учраас нисдэггүй. Ашиггүй учраас нисэхгүй болохоор нөгөө орон нутагт иргэдэд үйлчилгээ хүрэхээ больчихож байгаа юм.

Урьд нь бол цагийн сайхан гэж ярьдаа. Цагийн сайханд 21 аймгаас 11 аймагт онгоц байнга нисдэг байсан. Билетээ хүн болгон булаацалдаад, онгоцонд суух гээд ёстой нэг алалцаад тийм үү? Билетийнх нь үнэ хүртэл өсдөг байсан. Билет нь олдохгүй. Одоо үндсэндээ онгоц Ховд, Баян-Өлгий аймагт цагийн хуваарьтай нислэг хийж байна. Үндсэндээ хуваарьт нислэг. Бусад аймагт бол алдаг оног. Увс ганц нэг аймагт бол алдаг оног уурхайн нислэг хийгдэж байгаа.

Тэгээд энийг яагаад ийм болчхов гээд судлаад үзэхээр ерөөсөө л тийзийн үнэ. Та сая өөрөө хэллээ. Нэг талдаа 850000, хоёр талдаа 1500000, 1700000. Тэгэхэд чинь Сөүл нисээд ирэхэд 6 цагийн нислэг нисдэг. Тэгсэн мөртөө 1000000 орчим төгрөгөөр нисдэг. Баян-Өлгий нисэхэд 3 цаг нисдэг. Тэгсэн мөртөө 1500000. Энэ юутай холбоотой вэ гэхээр үндсэндээ зарцуулж байгаа шатахуун, онгоцных нь хүчин чадалтай холбоотой. Ийм л болчхоод байгаа. Энийг л бид нар буулгахын тулд онгоцны тийзийн үнийг яаж хямдруулах вэ. Хямдруулах нэг нөхцөл нь бол энэ шатахууны онгоцны нислэгийн зардалд эзэлж байгаа 28-46 хувь

нь эзэлж байгаа шатахууны зардлыг, үнийг хямдруулчих юм бол онгоцны тийз тодорхой хэмжээгээр буурах нь.

Дээрээс нь бусад тээврийн үйлчилгээтэй адилхан дотоодын орон нутгийн төмөр замын тээвэр дээр нэмэгдсэн өртгийн албан татвар авахгүй байна. Дээрээс нь хот хоорондын зорчигч тээвэр дээр, Улаанбаатарт нийтийн тээвэр дээр нэмэгдсэн өртгийн албан татвар авдаггүй. Энэнтэй адилхан болгоод нийтийн тээвэр дээр 10 хувийн НӨАТ-ыг буулгачих юм бол бас нэг 10 хувь буух нь.

Мөн одоо бас энэ орон нутгийн дотоодын нийтийн тээврийн үйлчилгээнд үзүүлж байгаа татаастай адилхан тодорхой хэмжээний татаас өгөх юм бол онгоцны тийз хямдрах нь.

Мөн авиа компаниуд өөр бусад дэмжих бүхий л бололцоотой талаар нь дэмжиж байгаа. Ийм байдлаар тийзийн үнийг хямдруулъя. Тийзийн үнэ хямдарчих юм бол орон нутагт ард, иргэд нисэж эхэлнэ.

Нөгөө талдаа ард, иргэд нисэхээс гадна гаднын жуулчид маань ирчхээд очих газаргүй болчихоод байна шүү дээ ерөөсөө. Хаана очих вэ? Очих газар байхгүй. Онгоц нисдэггүй учраас. Ийм аль аль юу гэдэг юм, 1 сумаар 2 туулай буудсан Монголд зочлох жил болж байгаа 23, 24, 25 онд жуулчдаа Улаанбаатарт түгжихгүй, гацаахгүй хүссэн газар руу нь онгоцоор нисгэхич юмсан.

Нөгөө талд нь орон нутгийн иргэдээ бас, ялангуяа аслагдсан аймгуудын иргэдийг бас онгоцоор нисдэг болгочих юмсан гэдэг бодлогыг л Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн яамнаас анхаарч ажиллаж байгаа. Энэ хүрээндээ энэ хуулийг бас дэмжээд, хэлэлцээд явах юм бол бас тодорхой хэмжээгээр Баян-Өлгий аймагт нисэж байгаа иргэдийн тийзийн үнэ

бас буурах юм. Ийм ач холбогдолтой. Энийг та бүхэн бас ойлгож, бусад дэмжлэг чиглэлүүд дээр та бүхнийг бас дэмжиж өгөөч гэж хүсэж байгаа юм. Тэр татаасны асуудал. Дээрээс нь тэр татваргүй нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудал. Энэ бүгд дээр та бүгдийг бас дэмжлэг үзүүлээсэй гэж бас хүсэж байна.

С.Одонтуяа: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар гишүүн нэмж хариулья.

Ж.Ганбаатар: Бямбацогт сайд бас дэлгэрэнгүй хариулчихлаа. Би тэр үлдсэн 2 асуултад нь хариулья. Газрын тосны үйлдвэрийн хувьд бол Энэтхэгийн зээлээр хэрэгжиж байгаа. Яг процесс нь бол ер нь бага зэргийн хоцорсон, хоцрогдолтой. Тэгэхдээ хэвийн явагдаж байгаа. Шадар сайд энэ асуудлыг ер нь гардаж хариуцаж, ажиллаж байгаа. Ер нь бол нэг том төсөл. Та бас мэдэж байгаа. Тэх, бараг нэг аравны долоо, найман тэрбум долларын том төсөл байгаа. Энэ ажил бас хэвийн явагдаж байна. Сая Засгийн газрын хуралдаанаар тэр тендерийг 4 хуваасан. Тэр 3, 4 дүгээр процесс нь Пи Си 2, 3 гэсэн процессууд нь ороод Засгийн газар бас баталгаажсан. Тэгээд Энэтхэгт тендерийн шалгарсан компаниуд ажилдаа ороод явж байгаа. Тэгэхдээ яах вэ, мэдээж бас хүндрэлүүд байна. Таны мэддэг хүндрэлүүдийг бас эргээд яриад яах вэ. Зүгээр гол асуудал бол ТЭГ-КОВИД асуудал байна. Тэгээд олон асуудлууд бас энд нөлөөлж байна. Тэгээд асуудал бас санасныг бодвол хэвийн явж байгаа гэдгийг бас танд мэдээлье. Баригдах хугацаа бол ер нь ойролцоогоор 25, 26 онд гэхэд баригдаж дуусна гэсэн ийм хуваарьтай явж байгаа гэдгийг хэлье.

Баруун аймгуудад дизелийн түлш өсчихсөн байгааг ойлгож байгаа, мэдэж байгаа, мэдээлэлтэй байгаа. Тэгээд ямар арга хэмжээ авч байгаа талаар та асуулаа. Бид Оросын Холбооны Улсаас “Роснефть”

компаниас бидний дизелийн түлшний 60 хувийг хангадаг байсан. Бусад 40 хувийг нь тэр жижиг трейд компаниуд хангадаг байсан бол энэ үйл ажиллагаа тасалдчихаад энэ 40 хувьд нь асуудал үүсээд байгаа юм. Таны ярьж байгаа тэр нийлүүлэлтийн хомсдол гэдэг зүйл бол бодитой.

Тийм учраас бид энийг даван туулахын тулд Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас дизель түлш импортолж байна. Тэгээд энэ Оросоос ирж байгаа дизель түншүүдээрээ бид нар Улаанбаатар хотын хэрэглээ болоод аймгууд руу явдаг автобус, нийтийн тээврийнхээ хэрэглээг хангаад, Хятадаас орж ирж байгаа дизель түлшээрээ уурхайнуудаа хангана гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Ер нь бол ойрын 7-10 хоногтоо багтаад нийлүүлэлт жигдэрсэн тохиолдолд баруун аймгуудад үүсээд байгаа хүндрэлүүд хэвийн болно гэдэгт итгэлтэй байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Буланы Бейсен гишүүн тодруулъя. 1 минут.

Б.Бейсен: Энэ газрын тос хулгайгаар гарч байна гээд улсууд яриад байх юм. 2 сая тонн энэ тэр гарчихсан байна гээд. Энийг шалгаж үзсэн үү? Та чинь сайд болоод удаагүй л дээ. Энэ талаар араас нь ороод шалгасан юм байна уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ Зам, тээврийн сайдаас би сая Өлгий яваад ирлээ л дээ. Томилолтоор. Тэгээд 50 хүнтэй онгоц 20 хэдэн хүнтэй нисэж байна. Үнийг нь буулгаад нисэж болохгүй юм уу? Тэгээд л цөөхөн хүнтэй өндөр үнээр нисээд байна шүү дээ. Ард түмэнд хүндээр тусаж байна. Энэ талаар та энэ компаниудтай ярьсан уу гээд асуух гээд байна.

С.Одонтуяа: 89 дүгээр микрофон нэмж хариулъя. Хариулах гэж байгаа хүмүүс нэрээ хэлээд, байгууллагаа хэлээрэй.

Ч.Хишигдалай: Хишигдалай Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга. Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр газрын тостой холбоотой 2 сая орчим тонн бүтээгдэхүүний хулгай гэсэн асуудал зүгээр яригдсан. Газрын тосны бүтээгдэхүүн газрын тос бол өөрөө онцлогтой. Ууршимтгай, хэвийн, хорогдолтой, алдагдалд тооцдог, норм нормативтай. Монгол Улсаас экспортолж буй газрын тосон дээр бол 0.6 хувийн хэвийн хорогдлын норм тогтоочихсон байдаг. Тэр хэмжээгээр экспортлоход хил дээр шалгасан тоо хэмжээнээс Хятадад хүлээж авч байгаа тоо хэмжээг хорогдлыг тооцдог байгаа. Үүнтэй холбоотой гарсан хэмжилтийн зөрүүг хулгай гэж одоо мэдээ.../минут дуусав./

С.Одонтуяа: Зам, тээврийн сайд Бямбацогт нэмж хариулъя.

С.Бямбацогт: Орон нутгийн нислэг үндсэндээ бол бараг л амь тасрах гээд байгаа. Одоо энэ амь тасрах гэж байгаа үед нь төрөөс жоохон дэмжлэг үзүүлж байж, төр бас бодлогын зохицуулалт хийж байж сэргээнэ. Өнөөдөр яагаад тэр 50 хүний суудалтай онгоцонд 20 хэдэн хүн нисээд байгаа юм гэхээр үнэтэй учраас хүмүүс онгоцоор нисэхгүй байна. Онгоцны тийзийг хямдруулчих юм бол хүмүүс ниснэ, 50 хүнтэй суудал дүүрнэ. Суудал дүүргэх юм бол тэр компаниуд бас тодорхой хэмжээнд ашигтай ажиллаж эхэлнэ. Ашигтай ажиллаж эхлэх юм бол олон чиглэлд олон нислэг нээнэ. Ийм л зах зээлийнх нь зарчмаар явуулъя.

Гэхдээ нэгэнтээ ингээд дор орчихсон, уначихсан байгаа үед нь төр

жоохон дэмжлэг үзүүлье, орон нутгийн нислэгтээ татаас олгоод ч байдаг юм уу. Дээрээс нь бусад зохицуулалтаар дэмжлэг үзүүлээдэлье. Ингээд нэг жоохон босоод ирээсэй. Босоод хөл дээрээ зогсчих юм бол аяндаа онгоц олон хүн нисээд эхлэх юм бол ашигтай ажиллаад, цаашаа олон чиглэлд нислэг маань эргээд сэргэчих юм. Ийм л зохицуулалтыг хийх ёстой. Өөр бидэнд зохицуулах механизм, өөр боломж гарах бол жоохон бага л байна л даа. Энийг та бас зөв ойлго.../минут дуусав./

С.Одонтуяа: Телеханы Аубакер гишүүн асуулт асууна.

Т.Аубакир: Баярлалаа. Оруулж ирж байгаа асуудлыг дэмжиж байгаа. Энэ асуудлыг оруулж ирсэн Уул уурхайн сайд, Зам, тээврийн сайд нарт маш их баярлалаа. Яагаад гэвэл энэ онгоцны тийзийн асуудал бол яах арга байхгүй алслагдсан аймгуудад бас тулгамдсан асуудал болоод байсан. Бямбацогт гишүүний хувьд бас Ховд аймгаас сонгогдсон билет, энэ онгоцны тийзийн хүндрэлийг бол маш сайн ойлгож байгаа. Ганбаатар сайд энэ тийзийн, онгоцны тийзийг хямдруулах тал дээр бас шатахууны үнийг бууруулах нь сайнаар нөлөөлөх юм гэдгийг бас олж хараад энэ асуудлыг оруулж ирж байгааг бол дэмжиж байна. Бусад гишүүдийг ч гэсэн бас энэ асуудлыг дэмжиж өгөөч гэж.

Алслагдсан аймгуудад ажиллаж, амьдарч байсан хүмүүс энэний бас нэг хүндрэл бэрхшээлийг ойлгодог юм л даа. Яах вэ, ингээд ярихаар бас төрөөс бүх юмыг татаасаар байдаг ч юм уу, хөнгөлөөд бас шийдээд байх нь зөв арга биш гэж үздэг гишүүд ч бий. Гэхдээ яах арга байхгүй баруун аймгууд, алслагдсан аймгуудад амьдарч, ажиллаж байгаа хүмүүст яг тулгамдсан, яаралтай, өвчтэй зовлонтой хүмүүс байж байна. Энд Улаанбаатар хотод ирээд ажил төрөл хөөцөлдөх, мөн оюутнуудын асуудал гээд

л хүний амьдрал баян л болсон хойно янз бүрийн асуудал тулгамдаж байдаг.

Тийм учраас энэхүү онгоцны түлшний асуудал дээр бас зөв гарц, гаргалгааг олж байгаа, олж оруулж ирсэн сайдуудаа бас баярласан, талархсанаа илэрхийлье. Энэ асуудлыг дэмжиж байна. Энэ асуудал шийдэгдэх юм бол яг хэдэн сарын хэднээс онгоцны тийз маань яг бодитойгоор буурах боломжтой гэж харж байна? Энэ ондоо багтах юм уу? Үгүй бол ирэх жилийн 1 сараас байдаг ч юм уу, 2 сараас байдаг ч юм уу, яг хэзээнээс буурах бололцоотой вэ? Энэ дээр яг тэдийгээс буурчих болов уу гэсэн яг тоо, дата юм байна уу? Энийг бас нэг хэлээд өгөөч.

Яагаад гэвэл энэхүү асуудлыг хүлээж байгаа маш олон ард иргэд байж байгаа. Бид нарыг тойргоор явж байхад Бямбацогт гишүүн сайн мэдэж байгаа байх, сая Бейсен гишүүн ч гэсэн ярьж байна. Яг энэ алслагдсан аймгуудаас сонгогдсон гишүүдийн бас л нэг шийдэх ёстой, гарцыг хайх ёстой, үргэлж гарц эрэлхийлж байдаг нэг ийм асуудал учраас энэ дээр яг хэдэн сарын хэднээс бодитойгоор буурна гэж бид бас сонгогчдодоо байдаг юм уу, алслагдсан аймгуудын иргэддээ бид нар бас нэг баяртай мэдээ болгож дуулах бололцоотой гэж харж байгаа. Яг хэдэн сарын хэднээс бурах вэ гэж нэг л асуулт байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт сайд асуултад хариулна.

С.Бямбацогт: Энэ хууль батлагдсаны дараа “Роснефть” Монголын “Эрчис ойл” 2 компанийн хамтарсан компани байгуулагдана. Монголын талд 60 хувь нь эзэмшдэг, Оросын тал 40 хувийг нь эзэмшдэг. Энэ хууль батлагдаад, үүний дараа. Тэгээд энэ компаниа үндсэндээ Сингапурын биржийн үнэ орчимд, Монголд онгоцны түлшийг зарж борлуулна гэсэн ийм л нөхцөлтэй, ийм л бодлого, зорилго бид нар хэрэгжүүлэх гэж

байгаа. Ийм бодлого, зорилго. Ингэх юм бол Сингапурын биржийн үнэ өнөөдөр хэд байна вэ гэхээр яг 2022 оны 11 сарын байдлаар 1100 орчим долларын үнэтэй байна. 1 тоон шатахууны үнэ. Онгоцны шатахууны үнэ өнөөдөр. Манай хувийн компаниуд онгоцны шатахууныг 1 тонныг нь 1700 орчим доллароор борлуулж байна. Төрийн 100 хувийн өмчтэй “Эрчис ойл” компани бол онгоцны шатахууныг 1 тонныг 1350 орчим доллар. Түрүүн бас хэлсэн.

Өөрөөр хэлэх юм бол 1700 доллароос энэ хууль хэрэгжээд энэ Орос Монголын хамтарсан компани байгуулагдаад онгоцны түлшийг өгөөд эхлэх юм бол дээд тал нь 600 орчим доллароор. Хамгийн багадаа 300, 400 орчим доллароор онгоцны түлшний үнэ 1 тонн тутамдаа буух болов уу. Ингээд л буучих юм бол бас манай авиа компаниуд 8-12 хувь орчмоор онгоцны тийзийн үнийг буулгах боломжтой гэсэн тооцоо судалгаа, урьдчилсан байдлаар хийж байгаа. Онгоцны нийт нислэгийн зардлынх нь 28-46 хувь нь онгоцны түлш байна. Тийм болохоор энэ тооцоог бид ингэж урьдчилсан байдлаар гарч байгаа тооцоо. Энэ тооцоогоо аль болох л хурдан хугацаанд хэрэгжүүлж, асуудлыг шийдүүлэх ийм л бодолтой ажиллаж байгаа.

Гэхдээ 10 хувь буурна гэдэг маань үндсэндээ бол онгоцоор хүн пиг зорчоод эхлэх үнэ биш. Сая Бейсен гишүүн хэллээ шүү дээ. Баян-Өлгий рүү 1500000 ирж очих юм. Тэр 1500000 арга ядарсан нялх нойтон хүүхэдтэй хүмүүс, дээрээс нь настай, өвчин зовлонтой хүмүүс, үнэхээр өндөр настай автомашинаар 1700 километр аялж чадахгүй болчихсон хүмүүс.

Ийм хүмүүс л явж байгаа Аубакир гишүүнээ. Та бол мэдэж байгаа. Эс үгүй бол мөнгөтэй хэдэн цөөхөн хүмүүс л явж байгаа юм. Тэгтэл 10 хувь буулгалаа, 1500-

г онгоцны бензин буусантай холбоотой бодох юм бол 1350 орчим төгрөг болж, 1500000-аас 1350000 орчим болж 60 хувиар буурна. Үүний цаана талд бид нар нэмэгдсэн өртгийн татварыг дахиад 10 хувь болгох юм бол 150000-аар гээд 1200000 орчим. Цаана нь дахиад дэмжлэг үзүүлэх юм бол гээд иймэрхүү байдлаар л бид нар Баян-Өлгий нисэж байгаа нислэгийн тийзийг болж өгвөл 500-700000-д хүргэчих юм сан. Хоёр талд нь тийм ээ? Ийм л бодлогыг барьж, үүний төлөө л хичээж ажиллаж байгаа.

Яг үүнтэй адилхан хамгийн холын аймгаар би жишээ авч ярьж байгаа юм. Гэтэл урд нь нисдэг байсан Дорнод аймаг, Сүхбаатар аймаг, Өмнөговь аймаг, Говь-Алтай аймаг, Завхан аймаг, Хөвсгөл аймаг, Увс аймаг гээд энэ олон аймгууд онгоц нисэхгүй байгаа. Энэ хэмжээгээр уул нь онгоцны түлш буураад, онгоцны билет, тийзийн үнэ буурчих юм бол энэ олон аймгуудад нислэг сэргэнэ. Тэр нислэг сэргэсэн хэмжээгээрээ цаад талд нь яах вэ гэвэл тэр ядарсан, зүдэрсэн, өвчтэй, зовлонтой, нялх нойтон хүүхэдтэй, өндөр настай энэ хүмүүст л бас буян болох л ажил болох юм. Энэ үүднээс нь бид нар бас төр энэ хүмүүсээс харж үзээсэй гэж бодож байгаа юм.

Дээрээс нь Монголд зорчих жил болгож зарлаж байгаа. 2023, 24, 25 оныг. Ингэхэд гаднын жуулчид ирчхээд 21 аймагт саяын хэлдэг аймгууд руу нисэх гээд тэгэхээр онгоц байхгүй. Улаанбаатарт түгжрэлийг нэмж байгаад л тэгээд л Улаанбаатар хотод гацаж байгаад л Хөвсгөл явъя онгоц байхгүй, Дорнод явъя онгоц байхгүй, Говь-Алтайн явъя онгоц байхгүй, Баянхонгор явъя онгоц байхгүй. Ийм л болчих гээд байгаа юм л даа.

Тийм болохоор үе шаттайгаар яаж билетээ бууруулах вэ л гэсэн бодлого явуулж байгаа. Энийг бас манай Их Хурлын гишүүд бас ойлгож, ялангуяа энэ

онгоц нисдэг байсан аймгийн гишүүд одоо өндөр үнэтэй нисэж байгаа юмыг гишүүд маань бас дэмжиж, бас тодорхой санаачилгатай ажиллаасай гэж та бүгдээс бас хүсье.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: 76 тэнэгүүд хоорондоо уралдаж байгаа юм шиг л юм ярих юм даа. Бензиний үнэ хэзээ буух вэ, хэдээр буух вэ л гээд л гоё яриад байх юм. Хэдий хүртэл буух бол? Хэзээ буцаад өсөх бол? Энэ дахиад ерөөсөө хэзээ ч өсөхөөргүйгээр та нар буулгаж байгаа юм уу? Өнөөдөр тонн нь 5500000 төгрөгөөс 4400000 төгрөг болгоно гээд л гайхалтай гоё юм яриад байна. Өнөөдөр нефть, шатах тослох материал бол улс төр, дипломат харилцааны хэрэгсэл болоод 100 жил болж байна. Та нарыг гаднын төр хуурч байна. Би буулгахын эсрэг биш шүү дээ. Буулгахын төлөө. Хэр тогтвортой юм?

Дараа нь миний нэгдүгээр асуулт Бямбацогт сайд Ганбаатар сайд 2 хариулна биз. Монгол Ардын намын сайд нарын буянаар 7.2-т ийм өөрчлөлт орж байгаа юм. Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүнийг гадаадын хуулийн этгээд дотоодын зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулахыг хориглоно гэсэн заалтыг бид өөрчилж, тодорхой бүтээгдэхүүнээ гадаадын этгээд дотоодын зах зээлд борлуулах эрхийг нь өгч байгаа заалт. Энэ заалт бол. Энэ заалтыг тэдэнд өгнө гэдэг бол цаад утгаараа Монгол Ардын намын Засгийн газар гадаадын төртэй нийлж Монголын нийт бизнес эрхлэгч, энэ нийт бензин хэрэглэгчдийн эрх ашгийг шийдэх юм байна. 5500000 төгрөгөөр бензин авдаг юм байна. Буулаа. Саяар буулаа. Аль зэрэг хугацаанд үргэлжлэх бэ? Буцаад энэ хэмжээнд хүртэл өсөөд, энэнээс дээш өсөхөд энэ хууль өөрчлөх үү? Эсвэл надад хамаагүй гээд яваад байх уу? Энэ талаар

судалгаа хийсэн тооцоолол байгаа юу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Үндэсний бизнес эрхлэгчид, миний сонссон мэдээлэл бол 5 компани бензин оруулж ирдэг юм байна. Яг энэ чиглэлийн. Онгоцны бензин оруулж ирдэг юм байна. Эдэнтэйгээ зөвлөлдөж ярьсан уу? Ясыг нь гартал тэднээс үнийг нь буулгах боломж та нарт байхгүй байсан юм уу? Тэдний барьцаанд орчихсон юм уу? Тэгэхлээр тэр хүмүүстэй ярьж чадахгүйгээр гаднын төртэй ярих нь та нарт амар байгаа юм уу? Тэд нартай хэрвээ ярьсан юм бол тэдэнд ямар ч ашиггүйгээр байхад Оросын төр та нарт давуу эрх өгч байна гэдэг бол энэ яг Цогтгэрэл гишүүний асуугаад байгаа өөр асуудал болж хувирч байгаа юм биш үү? Энэ хоёрдугаар асуултад тоо баримттайгаар хариулж өгөөч. Үндсэндээ Казахстан, Киргизстан, Узбекистан яг энэ асуудлаар боомилуулж үхэх гэж байгаа. Тажик, Болгар 2 бол энэ асуудал дээр арай гэж мултарч гарсан. Гаднын төрд энэ бензиний эрхээ өгчхөөд махаа зулгааж байж гарсан тохиолдол байгаа юм. Энийг судалсан уу?

Дөрөвдүгээрт, үндэсний бизнес эрхлэгчдийн эрх ашгийг зөрчиж байгаа. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр энэ асуудал хэлэлцсэн үү? Яагаад гэвэл энэ 7.2-ын заалт орж ирэхдээ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр орж ирсэн юм байна лээ. Одоо тэдний дүгнэлтийг авсан уу? Тэр дайныг санхүүжүүлэгч, би урьд нь зөндөө ярьчихсан учраас тэрийгээ давтаад яах вэ.

Эцэст нь арслан, хонь 2 хэлэлцээрт орвол хонь удахгүй мах болдог гээд нэг үг байдаг юм даа. Та нар загасны мах завсартай гэдэг шиг дунд нь хэдэн үндэсний бизнес, нефть импортлогч нар байвал Монголын Засгийн газарт, Монголын төрд ярихад үгүй мөн амар л байх болов уу гэж би бодоод байгаа юм.

Миний саяын 4 асуултад тоо баримттайгаар, үндэслэлтэйгээр хугацаатайгаа хариулна уу.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар сайд. Байж байгаарай. Энэ зочид очиж танилцуулаадахъя.

Америкийн Нэгдсэн Улсын Жорж Тауны Их Сургуульд суралцдаг оюутнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе.

Нэг, энэ хариултын дараа асуулт хариултын цаг дуусаж, санал хураалт явуулах учир гадаа байгаа гишүүд болон үзэж байгаа гишүүд орж ирнэ үү. Энэ асуултын дараа санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал томъёоллоор санал хураалт явуулна. Яасан чанга л инээдгийн та нар чинь. Жамбалын Ганбаатар гишүүн асуултад хариулъя.

Ж.Ганбаатар: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Гаднын төр энэ тэр бол орж ирж байгаа юм бол байхгүй. Ганбаатар гишүүнээ та уншаад бол 2 үг л өөрчлөгдөж байгааг ойлгож байгаа байх. Тэнд бол өрсөлдөөн л бий болж байгаа юм. Хувийн компани өрсөлдөөд явах бүрэн боломжтой. Энэ дээр айхтар тоо баримт гэхлээр яг юу ярихыг нь бол ойлгохгүй байна. Хэзээ буцаад өсөх вэ гэдгийг та өөрөө сайн мэднэ шүү дээ. Энэ чинь зах зээлийн үнэ л мэднэ шүү дээ. Дэлхийн зах зээлийн үнэ.

Гэхдээ Оюун-Эрдэнэ сайд сая Владивостокт айлчлахдаа дизель түлшин дээр 23 оны 1 сарын 1-нээс эхлээд зах зээлийн үнээс, Ленинградын бирж юм уу, эс үгүй бол Сингапурын биржийн үнээс 10 хувийн хямдрал авна гээд тохирсон. А 92-ыг 815 доллароор нийлүүлнэ гэж тохирсон. Тэгэхлээр бид нар нэг их, нэг их аймаар мангасын аманд, тийм аманд орно гэж би

бол ойлгохгүй байна. Хөрш улстайгаа бас бид нар. Тэртээ тэргүй энэ харилцаанд бид нар бараг 100 хувь энэ харилцаагаа хангаад ирсэн улс. Тэгээд айхтар бид нарыг аймаар боож, хаагаад л байсан тохиолдлуудыг нэг их бүгдийг нь нэг их ой санахгүй байна.

Тэгэхлээр таны болгоомжлол бас зүгээр 1 юунаас, угаасаа л бид нэг газраас хамааралтай. Өөр бид нарт сонголт байхгүй байгаа. Газар зүйн байршлын хувьд ч тэр, далайд гарцгүй улсын хувьд ч тэр. Түүнээс биш нэг өөр сонголттой байхлаар нь ганцхан, 1 компаниудыг сонгоод байгаа юм бол байхгүй байна.

Тэр хэзээ өсөх асуудлаар нь танд бол хэллээ. Ер нь бол дэлхийн зах зээлийн үнэ ямар байна, тэрнээс шалтгаална. Гэхдээ манай улсын хувьд бол ер нь А92 дизель түлш, онгоцны түлшийг бол ер нь дэлхийн зах зээлийн үнээс харьцангуй хямд үнээр Оросын Холбооны Улс тогтвортой нийлүүлж ирсэн. Бас хамаагүй, юу гэдэг юм дээ нэг талыг бариад муулаад байх нь бол зохимжгүй болов уу гэж бодож байна. Нэг их томоохон асуудлууд үүсээд, мэдээж асуудал үүсдэг. Жилийн хэрэглээ бараг 2000000 тоннд хүрнэ. Манай шатахуун. 1.8 сая тонн. Бараг 2 тэрбум долларын эргэлт байгаа. Зарим саруудад асуудлууд үүссэн. Сая бол бас зуны түлшнээс өвлийн түлшт шилжих процесст бас тодорхой хэмжээгээр нөлөөллөө.

Ер нь тэгэхдээ яах вэ, бүх асуудлуудыг юунд чихээд байгаа юм алга байна. Ер нь бид асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд ажиллаж байна. Танд хариулахад бол Хятад улсаас бас тодорхой хэмжээгээр дизель түлш орж ирж байна. Бид бас энэ тодорхой хэмжээгээр үнэтэй. Тэгээд үнэтэй дизель түлшээрээ бид нар бас урд бүсийн уурайнуудынхаа дизелийн хязгаарлагдсан асуудлуудыг шийдвэрлэх гээд ажиллаж байна. Байнга л ажиллаад л явж байна. Болно гэсэн үү? За.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Тэгэхээр ерөнхийдөө бол бид нар баримжаа болгож Ганбаатар гишүүнээ одоо бол манай хувийн компаниуд маань онгоцны түлш нийлүүлж байгаа. Энэ үнэ маань Сингапурын биржийн үнэ гэж нэг баримжаа үнэ байгаа юм бидэнд. Энэ биржийн үнээр дунджаар 600 орчим долларын үнэтэй байгаад байгаа юм. 600 орчим долларын. “Эрчис ойл” гээд төрийн өмчит компани байгуулаад энэ компани маань энэ оны 8 сараас ажиллаж эхэлсэн. Эд нар маань Сингапурын биржийн үнээс 250, 300 орчим долларын үнэтэй шатахуун нийлүүлж байгаа юм. Энэ 7.2-г нэмэлт өөрчлөлт оруулаад Орос Монголын хамтарсан компани байгуулагдаад үйл ажиллагаа явах юм бол Сингапурын биржийн үнэ орчимд онгоцны түлшийг бас тогтвортой нийлүүлнэ л гэсэн иймэрхүү урьдчилсан тохироотой гэсэн байдлаар Уул уурхайн яамныхан бол анх энэ хуулийг өргөн барих үедээ.

Энэ хууль чинь бол өнгөрсөн хаврын чуулганд өргөн баригдсан шүү дээ. Энэ үед ийм тохироотой юм гэж тухайн үед бас Ёндон сайд хариулж байсан. Би бас яг тийм л ойлголттой байгаа. Ийм ойлголттой. Тийм үүднээсээ очоод ажиллахаар үнэхээр онгоцны түлш бол зайлшгүй хямдрах шаардлагатай юм байна, хямдрах боломж нь бас нэг шийдэл нь энэ юм байна гэж ойлгож байгаа. Тийм учраас энэ асуудлыг дэмжээд явах ёстой гэж ойлгож байгаа.

Хэрвээ ярьж болдог байсан бол урьд өмнө олон сайд нар олон Засгийн газар ажиллаж байсан. Ярьж болоод тэр үнэтэй Сингапурын биржийн үнээс тонн тутамдаа 600 долларын үнэтэй онгоцыг түлш өгөөд байсныг бас шийдэх бололцоо байсан байх л даа. Болохгүй байсан учраас л ийм арга руу орсон байх. Ингэж бодож байна.

Дээрээс нь бид нар бас хоёр хөршөө, бид хоёрхон хөрштэй дэлхий дээр. Хоёр хөрштэй саахалт хүний санаа нэг, айл хүний амь нэг гэж тийм ээ? Ийм байдлаар л бас ажиллаж, ойлголцож амьдрах ёстой болохоос биш хонь, арслан 2 гээд хар яр гээд байх юм бол бид нар чинь бүгд мөнхөд аль нь ч тэгээд идүүлнэ л дээ.

Тийм болохоор харилцан ашигтай, хамтарч ажиллах иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээтэй. Энэ хүрээндээ л ажиллаж ирсэн. Цаашдаа ч ажиллах байх. Энд бид нар юу гэдэг юм, хоёр хөршөө хэтэрхий хаа хамаагүй хэлэх нь бас зохимжтой биш байх. Энийг бас бид нар бас цааш цаашдаа бодолцох ёстой болов уу?

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулъя. 1 минут.

С.Ганбаатар: За за. Би яах вэ, хоёр хөрштэй. Хятад, Оростой Монгол Улс дотно байх ёстой гэдэг дээр хатуу итгэлтэй байдаг. Мөн бусад гуравдагч орны бодлого тэрэн дээрээ бол бид бас хүндэтгэлтэй хандана гэдэг тийм байр суурьтай байдаг. Хамгийн гол нь хоёр хөрштэйгөө харин дотно байхын тулд бас нэг загасны мах завсартай. Бас тодорхой хэмжээгээр хүндэтгэлтэй байх энэ орон зайгаа биднүүс энэ буфер зоноо биднүүс авч хаяж байгаа л гэсэн үг шүү. Тэдэнтэй бол муудалцах эрх байхгүй. Бензиний үнээ бол тэдэнтэй ярьдаг болсон. Та нар социализмын үед ч гэсэн дээ намрын ажлын үеэр л бензин тасалддаг, өсдөг байсан шүү дээ. Дохио бол гэж авдаг байсан. Энд би муу хэлээгүй шүү дээ. Энэ бол нефтийн бодлого бол тэртээ тэргүй улс орны дипломат болон улс төрийн харилцааны багаж хэрэгсэл болоод олон жил болж байгаа. Тэрэн дээрээ бид бас харин муудахгүй, сайнтай байхын тулд л би энийг ярьж байгаа юм. Тэгээд яах вэ, Монгол Ардын нам өнөөдөр .../минут дуусав./

Г.Занданшатар: Үг хэлчихлээ тийм ээ? Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. 1 л санал байгаа. Ямар санал? Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл.

О.Цогтгэрэл: Энэ газрын тосны, oil-тай холбоотой энэ асуудал дээр Ардчилсан намын бүлгээс завсарлага авах хүсэлтэй байна. Ямар үндэслэл байна вэ гэж. Энэ дээр олон эргэлзээтэй асуудал байна. Багцлаад хэлэх юм бол эдийн засгийн талаасаа, улс төрийн талаасаа. Эдийн засгийн талаасаа яг энэ засгийн барьж байгаа бодлого олон зүйл дээр чинь хэдий зах зээлийг либералчилна, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг аль болох нэмж байгуулахгүй, хувьчилна, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ гээд байдаг. Энд эргэж төрждөг тухай нэг яриа энэний цаана яваад байна. Тэр тэр тусмаа гадаад улсын 1 аж ахуйн нэгжид давуу эрх хэрхэн олгох тухай. Эдийн засгийн талаасаа.

Улс төрийн талаасаа түрүүн Ганбаатар сайд ч хэлж байна, яг энэ Оросын талд манай талд нефть бүтээгдэхүүн дээр сонголт байхгүй гэж байна л даа. Тэгээд Оросын тал өгч болж байгаа үнээс манайд нэг ийм улс төрийн шийдвэр, нэг монопол давуу эрхтэй компани байгуулчхаад яагаад юм хямдруулах гээд байгаа юм. Нэгэнт тэд нарт бүх эрх нь байна шүү дээ. Энэний цаана чинь яг ямар улс төрийн, ямар ашиг сонирхол байгаад байгаа юм бэ? Энэ ерөөсөө шууд нэг ийм эдийн засгийн гоё сайхан яриад байгаа шиг утгатай зүйл энэний цаана харагдахгүй байгаад байна шүү дээ. Ийм учраас энэ бүхэн дээр бид бүгд Ардчилсан намын бүлгээс бас завсарлага авъя. Завсарлага авахдаа өмнө нь 1 удаа авч байсан юм байна. Тэгэхээр завсарлагыг дараагийн удаа 3 хүртэл хоногоор сунгаж өгч болдог байх. Тэгэхээр

Ардчилсан намын бүлгээс энэ хуулийн төсөл дээр 3 хоногийн завсарлага авъя.

Г.Занданшатар: Ер нь энэ өнөөдөр бол геополитикийн асуудал яриагүй. Уул, уурхайн хүнд үйлдвэрийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын тайлбарлаж байгаагаар бид нар монопол, эликопол үүсгэхгүй, нэгт.

Хоёрт бол үнэ бууруулна. Шатахууны үнэ хямдарна, агаарын тээврийн зардал хямдарна л гэсэн зорилготой ерөнхий хууль хэрэглэж байгаа. Аль нэг улс орон, асуудал бол ярьж байгаа гэж бид ойлгоогүй. Сайд нарын тайлбарлаж байгаагаар. Сайд нарын яриа, мэргэжлийн улсуудын яриа тэгж тайлбарласан. Тэгээд тэр үнэ, ханш хямдарч байвал энэ өнөөдрийн энэ бензин шатахууны үнэ, тээврийн үнэ ханш өндөр байгаа үед энэ бас хугацаа алдалгүй шийдвэрлэх нь зүйтэй байх. Дэгийн тухай хуулиар бол 15.1-т зааснаар бол өмнө нь завсарлага авсан бол 1 удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно гэсэн заалт бий.

Гэхдээ 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно гэсэн заалт бий. Тэгэхдээ энэ цаг хугацааны хувьд ч энэ чинь өнөө, маргаашгүй яаралтай шийдэх асуудал биз дээ тийм ээ? Тэгээд яаралтай шийдэх асуудал учраас өмнөхөд яах вэ 3 өдөр ахиж сунгаж болно гэж байгаа юм. Тэр дагуу байгаа. Тэгэхээр энийг бол Тогтохоо дарга та хэд яриад маргааш өглөө хүртэл сунгаж болж байна. Нэг гэвэл хугацаатай асуудал гээд 1, 2 цагийн завсарлага өгч болж байна. Үгүй ээ, харин дэгтээ 1 удаа, 3 удаа сунгаж болно гэдгээ сая хэлчихлээ л дээ. 15.1-т. Тийм энэ бол, бүлэг бол завсарлага авах эрхтэй. Завсарлага авах хугацаа ажлын 5 хоногоос илүүгүй өдөр байх бөгөөд шаардлагатай бол нам, эвслийн бүлэг хүсэлт гаргавал завсарлагын хугацааг 1 удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно гэж байгаа юм. 3-аас илүүгүй

өдрөөр. Тэгэхээр 3-аас дотогш л гэсэн үг. Маргааш өглөө хүртэл. Маргааш өглөө ирцээ сайн бүрдүүлээд, өглөө 10 цагаас санал хураалт явуулна. Маргааш өглөө 10 цаг хүртэл завсарлага өглөө.

Дараагийн асуудалд орёе. Энэ бас гишүүд олон санаатай байгаа учраас энийг бас дэгээрээ явсан нь зөв байх. Дараагийн асуудал орно.

14.47 цаг

Долоо. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жамъянгийн Мөнхбат танилцуулна.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн албанаас албаны зөвлөлөөс Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт төрийн өндөр албан тушаалтны зэрэг, зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын зэрэг, зиндааг өөрчлөх асуудлыг дэмжсэн саналаа 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 012276 тоот албан бичгээр Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлсэн.

Тус Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Тогтоолын төсөлд Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн төрийн өндөр албан тушаалтны зэрэг, зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай 19 дүгээр тогтоолын хавсралтад Монгол Ерөнхий прокурорын албан тушаалын зэрэг зиндаа ТӨ 4 байсныг ТӨ 3 болгон өөрчлөхөөр тусгалаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Тогтоол танилцуулсан. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Энхбаяр гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт үг хамтдаа.

С.Чинзориг: Нэг асуулт, нэг санал байна. Энэ төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах албан тушаалтны ангилал, зэрэглэлийн асуудлыг би бас жаахан гадарладаг юм. Олон жил хариуцаж ажиллаж байсан юм. Тэгээд Ерөнхий прокурор, ТӨ 3-аар хуучин байсан юм. Яагаад ингээд ТӨ 4 болгоод ангилал, зэрэглэлийг нь 1 шат буулгачихсан байсан юм? Ямар учиртай ингэсэн юм? Ерөнхий прокурор чинь Үндсэн хуулийн байгууллага гэдэг утгаараа ТӨ 3-аар явдаг байсан. Энийг яагаад буулгачихсан юм бол доо гэж нэг асуумаар байх юм Байнгын хорооноос.

Хоёр дахь асуудал нь бид төрийн албан төрийн байгууллагуудад, төрийн албан тушаалтнуудад ижил тэгш хандах ёстой гэдэг зарчмыг би байнга л яриад байгаа юм. Хаврын чуулганаар бил үү, өнгөрсөн намрын чуулганаар билүү шүүхийн Тамгын дарга, Цэцийн Тамгын дарга нарыг төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах албан тушаалтны ангилал, зэрэглэлд оруулчихсан юм. Би энийг бол тухайн үед нь бас эсэргүүцэж байсан хүний нэг. Энэ Тамгын газрын дарга нар гэдэг чинь ажлын албаны л дарга нар, төрийн захиргааны албан хаагчид байх ёстой.

Гэтэл энийг тухайн үедээ ярьсаар байж байгаад төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах албан тушаалтны ангилал, зэрэглэлд оруулчихсан юм. Одоо нэгэнт энэ шүүх, Цэцийн Тамгын газрын дарга нарыг энэ өндөр албан тушаалтны ангилал, зэрэглэлд оруулчихсан бол прокурорын Тамгын газрын даргыг нь би бол адилтган оруулах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа юм. Үндсэн хуулийн байгууллага, прокурорын байгууллага, тэгээд шүүхийн Тамгын дарга, Цэцийн Тамгын дарга нарыг нь зарчим нь буруу шүү дээ гэсээр байтал төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах албан тушаалтны ангилал, зэрэглэлд оруулчихаад

прокурорын Тамгын газрын даргыг нь энэ ангилал, зэрэглэлд оруулаагүй, үлдээчихсэн юм.

Тийм учраас энэ Их Хурал төрийн алба, төрийн албан хаагчидтай ижил тэгш хандах ёстой гэсэн энэ зарчим байх ёстой. Энэ үүднээсээ Үндсэн хуулийн байгууллага болох энэ прокурорын Тамгын даргыг төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах албан тушаалтны ангилал, зэрэглэлд оруулах асуудлыг Байнгын хороо авч үзээгүй юм уу, яриагүй юм уу? Прокурорын ангилал, зэрэглэлийн асуудлыг шинэчилж байгаа бол тэр шүүхийн Тамгын дарга, Цэцийн Тамгын дарга нартайгаа адилтгаад, прокурорын Тамгын даргын ч гэсэн энэ ангилал, зэрэглэлд нь оруулах асуудлыг Байнгын хороо яриад оруулаад ирж болоогүй юм уу? Бид ингээд Үндсэн хуулийн байгууллагууддаа 2 өөр нүдээр хараад байж болохгүй шүү дээ. Зарчим нь бол буруу гэж би зөндөө ярьсан. Тухайн үед нь. Гэхдээ олонхын санал аваад шүүхийн Тамгын дарга, Цэцийн Тамгын дарга нар өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах албан тушаалтны ангилал, зэрэглэлд орчихсон юм.

Тийм учраас энэ Үндсэн хуулийн байгууллага учраас энэ прокурорын Тамгын даргын ч гэсэн адил тэгш хандах зарчмаа баримтлаад энэ төрийн өндөр албан тушаалтны ангилал, зэрэглэлд нь оруулчих асуудлыг Байнгын хороо үзээд оруулчихмаар байгаа юм. Бид ингээд төрийн байгууллагууддаа ижил тэгш бус хандаад байж болохгүй шүү дээ. Нэг л зарчим байх ёстой, барих ёстой гэж ийм бодолтой байгаа. Энийг Байнгын хороон дээр яриагүй юм уу? Цаашдаа энэ тогтоол хэлэлцүүлгийнхээ явцад тэр Тамгын даргыг нь төрийн өндөр албан тушаалтны ангилал зэрэглэлд оруулчих тийм бололцоо байна уу, үгүй юу гэдгийг би бас асуумаар байх юм.

Г.Занданшатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жамьянгийн Мөнхбат хариулъя.

Ж.Мөнхбат: Чинзориг гишүүний энэ ярьж байгаа энэ төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалын зэрэглэлийн асуудлыг Монгол Улсын Ерөнхий прокурорын өөрөө Үндсэн хуульт байгууллагыг тэргүүлдэг гэдэг утгаараа Монгол Улсын Цэцийн дарга, Дээд шүүхийн дарга, Улсын Ерөнхий прокурор бол хуучин ТӨ 3-т байсан. Энэ ТӨ 3-т байсан зүйлийг бол 2019 оны 2 сарын 1-ний өдрийн Улсын Их Хурлаас баталсан тогтоолын хавсралтад ТӨ 4 болгож ингэж бууруулж баталсан юм байна лээ. Тэгээд үүнтэй холбоотой ямар асуудал үүссэн бэ гэхээр төрийн ёслолын үйл ажиллагаа, арга хэмжээн дээр ч юм уу, энэ зэрэг зиндааны асуудал Үндсэн хуульт байгууллагын адилхан гурван байгууллагын хоёрынх нь дарга нь ТӨ 3-т байдаг. Нэг нь ТӨ 4-т байдаг ийм л асуудал хөндөгдсөн. Энэ асуудлыг бас Төрийн албаны тухай хуулийн 17.1-т заасан үндэслэлээр бол төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэж Улсын Их Хурал тогтооно гэсэн Төрийн албаны тухай хуулийн 17.1-т байгаа. Энэний дагуу Төрийн албаны зөвлөл энийг ТӨ 3 болгох саналыг дэмжсэн саналаа ирүүлсэн учраас бол Ерөнхий прокурорын асуудлыг Үндсэн хуульт байгууллагын тэргүүлж байгаа Ерөнхий прокурорын асуудлыг ингэж оруулж ирж байгаа юм.

Яг энэ Төрийн албаны хуулийн 17.1-т заасны дагуу бол прокурорын Тамгын газрын даргын асуудлыг бол санал ирээгүй. Төрийн байгуулалтын байнгын хороонд. Төрийн албаны зөвлөлөөс ч ийм санал ирээгүй. Тийм учраас бол мэдээж хуулийн дагуу бол Байнгын хороо шууд энийг санаачлаад юм уу, Их Хурал шууд

санаачлаад шийддэг юм биш, Төрийн албаны тухай хуулийн 17.1-ээр төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэж ийм шийдвэр гаргах эрх нь Улсын Их Хуралд байдаг.

Тийм учраас хэрвээ прокурорын Тамгын газрын даргын асуудал, зэрэг зиндааны асуудал хөндөгдөнө, Үндсэн хуульт байгууллагын бүх дарга, тамгын дарга нар ижил тэгш байна гэх юм бол энэ асуудлаа Улсын Их Хурал, тэгээд төрийн албаны төв байгууллагад хандаж тавих нь бол зүйтэй байх. Тэрний дараа энэ асуудлыг авч хэлэлцэх асуудал нь бол Төрийн байгуулалтын байнгын хороонд эрх нээгдэнэ. Хуулиараа ийм байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна.

Б.Энхбаяр: Монгол Улсын Ерөнхий прокурорын ангилал, зэрэглэлийг төрийн өндөр 3 гэдэг ангилал руу болгох саналыг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Энэтэй холбоотой 2 асуулт байна.

Нэгдүгээрт, Ерөнхий прокурор нь дээшээ 1 шат ахичихаар орлогч нар нь яаж байгаа вэ? Дагаж ахиж байгаа юу, байрандаа үлдэж байгаа юу гэсэн эхний асуулт байна.

Хоёр дахь асуулт нь Монгол Улсын Ерөнхий прокурор Монгол Улсад үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх үйл явдалд, мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн тайланг Улсын Их Хуралд жил тутам танилцуулж байх үүрэгтэй. Хуульчилсан үүрэгтэй. Энэ өнгөрсөн парламентад бол жил тутам танилцуулдаг байсан юм. Энэ удаагийн Улсын Их Хурал нэг ч танилцуулсангүй. Энэ хууль нь больчихсон юм уу? Эсвэл хүн нь өөр болохоор ингээд байгаа юм уу? Энэ чинь уг нь хуультай шүү дээ. Монгол Улсын Их Хурал бол ард түмний төлөөллийн дээд

байгууллага. Тодорхой гэмт хэрэг хянан шийдвэрлэсэн асуудлаар үнэлэлт, дүгнэлт өгч хэлэлцэх гэж байгаа асуудал бол биш. Монгол Улсад үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн байдал, түүний шалтгаан, нөхцөл, түүнээс учирч байгаа хохирол, барагдуулалт гээд энэ тайлан, мэдээллийг чинь бид сонсож байж ямар ч төрлийн гэмт хэргүүд нэмэгдээд байна вэ, юу нөлөөлөөд байна вэ?

Цаашдаа төрийн бодлогыг энэ гэмт хэрэг зөрчлийг бууруулах чиглэл дээр юунд анхаарах ёстой юм байна гэдэг бодлого, чиглэлээ энэ тайланг сонсож байж гаргадаг. Энэ шинэ Улсын Их Хурал 2 жил хагас бид үйл ажиллагаагаа явуулж байна. Нэг ч ийм тайлан сонссонгүй. Энэ асуудлыг бол Хууль зүйн сайдаас бас асуугаад байдаг асуудал биш. Яагаад гэхээр Хууль зүйн сайд гэмт хэрэг, зөрчлийн үйл ажиллагаа нь тодорхой, хөндлөнгөөс оролцдоггүй, мөрдөн шалгадаггүй, хяналт тавьдаггүй. Энэ чиг үүрэг Монгол Улсын Ерөнхий прокурорт байгаа. Тэгээд сүүлийн үед чинь бүгд хулгай л ярьдаг болсон шүү дээ одоо. Тэрбум биш, их наяд ярьдаг болсон. Тэгээд асуумаар юмнууд их байх юм. Тэгээд энэ хэзээ тайлангаа тавих юм бэ? Энэ ер нь тайлан ирүүлж байгаа юу, үгүй юу бичгээр? Ирүүлснийг нь эсвэл сонсохгүй байгаад байна уу? Эсвэл бүр огт ирүүлэхгүй байна уу? Улсын Их Хурал бол энэ чинь Ерөнхийлөгчийн тайланг хүртэл сонсдог, хэлэлцдэг шүү дээ. Жил тутам Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд жилийн ажлынхаа тайлангаа ирүүлж, Улсын Их Хурал сонсдог шүү дээ.

Тэгтэл Ерөнхий прокурор энэ гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг ирүүлдэггүй. Тайланг хэлэлцүүлдэггүй одоо 2 жил хагас болчихлоо.

Г.Занданшатар: Байнгын хорооны дарга Жамъянгийн Мөнхбат хариулья.

Ж.Мөнхбат: Энхбаяр гишүүний асууж байгаа энэ Ерөнхий прокурорын орлогч бол өнөөдрийн байдлаар бол ТӨ 5 А зэрэглэлд байгаа. Энэ зэрэглэлд бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн. Шүүхийн сахилгын хорооны гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны дарга, Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Авлигатай тэмцэх газрын дэд дарга гэсэн ийм албан тушаалтнууд багтаж байгаа. Энэ удаагийн Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах асуудал бол орлогч болон тамгын дарга ч юм уу ямар нэгэн бусад албан тушаалтнуудыг хөндөөгүй. Зөвхөн Ерөнхий прокурорын буюу Үндсэн хуульт байгууллагын тэргүүнүүд, тэргүүлж байгаа хүмүүс адил нэг зэрэглэл, зиндаанд байх ёстой гэдэг ийм асуудал, ийм үндэслэлийн хүрээнд л асуудал Ерөнхий прокурорын хүрээнд, түвшинд, албан тушаалтанд яригдаж байгаа гэдгийг бол хэлье.

Хоёр дугаар асуудал, энэ гэмт хэргийг хэрхэн шийдвэрлэж байгаа талаарх энэ мэдээлэл, тайлангаа Улсын Их Хуралд ирүүл, тайлагнаж байна уу гэж байна. Ер нь зүгээр авсан мэдээллээр бол Ерөнхий прокурор, прокурорын байгууллагын зүгээс бол цаг хугацаанд нь тайлан мэдээлэл ирүүлж байгаа юм билээ. Ирүүлсэн мэдээллийг Байнгын хороогоор хэлэлцүүлэх үү, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх үү гэдэг нь бол тухайн Байнгын хорооны бүрэн эрхийн асуудал. Хэлэлцэх эсэх нь. Тэгэхээр энэ асуудал бол Төрийн байгуулалтын байнгын хороонд хамаардаггүй. Өөрөөр хэлэх юм бол Хууль зүйн байнгын хороонд хамаардаг учраас энэ асуулт дээр Хууль зүйн байнгын хорооны дарга хариулах нь зөв байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Энхбаяр Хууль зүйн байнгын хорооны гишүүн. Хууль зүйн байнгын хороон дээрээ ярих ёстой. Энэ байгууллагуудын танилцуулгыг сүүлд нэмэгдсэн Хяналт шалгалтын тухай хуулиар Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын чуулганд оруулна гэсэн заалттай байна. Байнгын хороогоороо тайлангуудыг хэлэлцээд дүгнэлт гаргаж байгаа юм. Одоо гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Энэ 2 гишүүний асуусан асуулттай холбогдоод энэ тогтоол батлагдах юм бол харин дарга нь ангилал өөрчлөгдөхөөр дагаад тэр тамгын дарга, орлогч дарга нарын асуудал яригдах юм уу гэдгийг тусдаа тодорхойлох асуудал байгаа. Одоо гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт бэлэн байна уу? Санал хураалт.

31 гишүүн дэмжиж, 64.6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолын эцсийн найруулга. Тогтоолыг уншиж танилцуулъя. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Дараагийн асуудал орно.

15.03 цаг

Найм.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын

хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт илүү бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцээд чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас зарим зүйл, заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу ажлын хэсгээс төслийн 18.2.7 дэх хэсгийн заалтыг төслийн үйл ажиллагаанд шаардлагатай Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдох тусгай болон энгийн зөвшөөрлийг тодорхойлсон байх гэж өөрчлөх, төсвийн 27.1 дэх хэсэгт сонгон шалгаруулалтад оролцогчид нь Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасны дагуу харилцан хамааралгүй байна гэсэн шинэ заалт нэмэх, төслийн бусад зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй саналууд бэлтгэснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь хэсэг, хамт өрөг мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах саналыг чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь эдгээр саналаар дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан төслийн 29.1 дэх заалтын “зээлэгдэгчийн” гэснийг “санхүүжүүлэгчийн” гэж, 29.2 дахь хэсгийн Монгол Улсын хууль болон түншлэлийн гэрээнд заасан эрх, үүргийн дагуу оролцоно гэснийг холбогдох хууль, түншлэлийн үндсэн болон дагалдах гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ гэж өөрчлөх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах саналыг дэмжихгүй гэсэн саналуудаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь дэмжлээ.

Монгол Улсын 2023 оны тэр төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлэгдэж батлагдсан Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нийцүүлж Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эшлэлийн дугаарыг өөрчилж, төсөлд тусгалаа.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарын төсөл болон Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчны хамгаалах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Концессын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил, тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Улсын

тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүд болон тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Зочид танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Мөнгөнморьт сумын сургууль, цэцэрлэгийн багш, ажилчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилт, сайн сайхныг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Асуулт алга байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 10 санал байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулья.

1.Төслийн 18.2.1 дэх заалтын “энэ хуулийн 19.4, 19.6-д нийцүүлэн гүйцэтгэсэн” гэснийг “боловсруулсан” гэж өөрчилж, 18.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.2.7.Төслийн үйл ажиллагаанд шаардлагатай Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдох тусгай болон энгийн зөвшөөрлийг тодорхойлсон байх;”. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт явуулья. Асуулт хариулт дууссан. Санал хураалтын цаг эхэлж байгаа учраас гишүүд чуулганы танхимд цуглаарай. Санал хураалт явуулах уу? Ирцээ сайн бүрдүүлээрэй энэ чинь бас. Түрүүн энэ тэр бол энэ сөрөг хүн олонтой үед бол саналууд уначихаар байна шүү бас. Санал хураалт. Үдээс хойших санал хураалт энэ бүртгэлийн санал хураалт энэ. Энэ бүртгэлд орохгүй байгаа 22 гишүүнийг дууд. Бүртгэлд оруулья. Бүртгэлийн санал хураалтаар санал хураалт явуулаа. Энэ Идэрбат, Жаргалмаа, Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Өнөрболор, Ж.Сүхбаатар. Одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Төслийн 18.2.1 дэх заалтын “энэ хуулийн 19.4, 19.6-д нийцүүлэн гүйцэтгэсэн” гэснийг “боловсруулсан” гэж өөрчилж, 18.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.2.7.Төслийн үйл ажиллагаанд шаардлагатай Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдох тусгай болон энгийн зөвшөөрлийг тодорхойлсон байх;”. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 25.2.6 дахь заалтын “үнэлэх” гэснийг “үнэлэх, шаардлага хангаагүй бол энэ хуулийн 25.2.7-д заасан хугацааны дотор оролцогчид мэдэгдэх;” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Г.Мөнхцэцэг, Жаргалмаа, Тэмүүлэн, Б.Энх-Амгалан нар хаачсан бэ? Санал.

3.Төслийн 27.1.6 дахь заалтын “хамтарч оролцохгүй байх” гэснийг хасаж, 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.1.7 дахь заалт нэмэх:

“27.1.7.сонгон шалгаруулалтад оролцогчид нь Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасны дагуу харилцан хамааралгүй байна.”. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 53.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 29.1 дэх хэсгийн “зээлдэгчийн” гэснийг “санхүүжүүлэгчийн” гэж, 29.2 дахь хэсгийн “Монгол Улсын хууль болон түншлэлийн гэрээнд заасан эрх, үүргийн дагуу оролцоно” гэснийг “холбогдох хууль, түншлэлийн үндсэн болон дагалдах гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 39.3 дахь хэсгийн “байгууллагаас” гэсний дараа “зөвшөөрөл” гэж нэмэх. Санал гарсан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 50.1.3 дахь заалтын “төслийн баримт бичгийн үнэ” гэснийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

52.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурал хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд зааснаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл санаачлах,” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн саналыг хэлэлцэх,” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

25 гишүүн дэмжиж 56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээнд заасныг үндэслэн” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлээр” гэж өөрчилж, мөн зүйлийн “холбогдсон харилцааг” гэсний дараа “Газрын тухай,” гэж нэмэх. Санал

гаргасан Эдийн засгийн байнгын хороо.
Санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй,
Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Би өөрөө энэ ажлын хэсэгт байгаа. Тэгээд дэмжиж дарсан гэсэн, сая сөрөг гарчихлаа. Тэгээд санал хураалтыг дахин явуулж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Дэмжиж дарахаар сөрөг гарна гэж байхгүй.

М.Оюунчимэг: Харин тэгчихлээ.

Г.Занданшатар: Энэ нь их ач холбогдолтой заалт мөн юм уу? Холбогдсон харилцааг гээд тэгчихсэн юм байна шүү дээ. Түншлэлийн гэрээгээр болон холбогдох бусад хуулиар холбогдсон харилцааг зохицуулна гэж байсан юм. За яах вэ, Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Саяны санал хураалтыг хүчингүйд тооцох тухай.

56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Оюунчимэг гишүүний гаргасан горимын санал дэмжигдэж, өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Өмнөх санал хураалт хүчингүйд тооцсон учраас Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан саналаар дахин санал хураалт явуулъя одоо.

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах саналыг дэмжихгүй. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Энэ буцаах саналыг чинь дэмжээд би буцаах тогтоол уншчихсан шүү дээ. Хөөе та хэдэн үздээ наадах чинь. Үгүй ээ, гүйцээн боловсруулах чиглэлийг түрүүчийн заалт дээр өгсөн юм. Төсөл санаачлагчид нь буцаагаад тогтоол уншчихсан юмыг ингэж ахиж хэлэлцэж болдог юм уу? Босчихсон юм уу тээ? Уншаагүй байна уу тээ? Та нар уншаагүй гэсэн шүү. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Буруу дараагүй тэр тэгэхдээ бас тийм юутай байсан юм. Одоо өнгөрсөн. Түрүүн тайлбараа хийцгээхгүй яасан юм? Би дахиж санал хураахгүй шүү гэж хэлсэн. Одоо ингээд энэ хууль буцлаа. Түрүүнд тайлбараа хэлэхгүй яасан юм тэгээд? Түрүүнд нь яг унахад ингэсэн. Тайлбар хийхгүй байж байгаад л унасан. Тэгээд л дараа нь тайлбар хийсэн. Энэ хуулиа, одоо Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль одоо орж ирнэ шүү дээ. Тэрэн дээрээ л дахиад ярихаас өөр замгүй. Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн горимын санал гаргая.

Т.Энхтүвшин: Байна уу? Би сая энэ хажуу тийшээ цай уучхаад ирлээ. Тэгээд дахин санал хураалт өгч явуулаач гэж.

Г.Занданшатар: Цай ууна гэж байхгүй. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн. Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Би сая энэ саналыг дэмжиж өгсөн. Тэгээд миний төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр энийг хүчингүй болгож өгөөч.

Г.Занданшатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүний гаргасан горимын саналаар саяны санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. Энэ Энхтүвшин гишүүн энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн талаар хамгийн их санаа зовж, ярьсан хүн байгаа юм уул нь. Тэгсэн чинь сая цай ууж аваад саналаа угаачих юм. Тилеуханы Аубакир гишүүн.

Т.Аубакир: Би сая дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй. Саяын саналыг хүчингүй болгоод дахин санал хураалт хийж өгнө үү гэж хүсье.

Г.Занданшатар: Энэ чинь ингээд 2 дахь санал хураалт уу? 3 дахь уу? Тэгээд заавал 3 хураах гэсэн шаардлага байхгүй. Аубакир гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

58.1 хувийн саналаар Аубакир гишүүний гаргасан саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт дэмжигдлээ. Саяын санал хураалт дэмжигдсэн учраас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт.

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 3,4 дэх заалт тус тус нэмэх:

“3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн

байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Зарчмын зөрүүтэй саналын томиллоор санал хураалт явуулж дууслаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Энэ Түвдэндорж дэд сайд ер нь энэ ажлын хэсэг, энэ холбогдох яамныхан, энэ бөөс хуурсыг. Энэ яагаад унаад байна гэхээр байна шүү дээ аягүй, дандаа negative зохицуулалтаар тэр болохгүй, энэ болохгүй байна. Төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль үйлчлэхгүй энэ тэр гээд ийм буруу үг хэллэгтэй биччихээр чинь энэ дэмжигдэхгүй байгаа шүү дээ. Маш олон засвар орж, эцсийн хэлэлцүүлэг дээр хүртэл 10 санал хураалт явуулж байна гэдэг бол энэ хуулийн найруулга, бичилт маш муу байгааг өглөө би анхааруулсан шүү. Энэ дээр цаашдаа анхаарах хэрэгтэй. Энэ чинь negative биш positive зохицуулалтаар нь зохицуулчих юмнуудыг тэгээд. Тэр үйлчлэхгүй гэхээр энэнээс гадуур хачин юм явах гэж байгаа юм шиг хүмүүс ойлголт өгөөд байна шүү дээ. Дараагийн асуудалд орно.

15.30 цаг

Ес.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан таар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг танилцуулна. Индэрт урьж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг баримтлан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар уг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-г заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын сал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд

оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хороо Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Шатарбалын Раднаасэд гишүүн суудалдаа сууна уу. Санал хураалт явуулъя. Тэнчээ сая байсан Төмөртоогоогийн Энхтүвшин, Энхтайваны Бат-Амгалан 2 гишүүн сая тэнд байж байсан яасан бэ? Тилеуханы Аубакир гишүүн суудлаас суу. Санал хураалт явуулна. Санал хураалт.

24 гишүүн дэмжиж 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Ийм учраас Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд оръё.

15.34 цаг

Арав.Хот, суурины ус хангамж, ариутгах, татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Баделхан, Баттөмөр, Булгантуяа нараас 2021 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот, суурины усан хангамж, ариутгах, татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2022 оны 5 дугаар сарын 12, 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 7 дугаар тогтоолоор Хот, суурины ус хангамж, ариутгах, татуурга ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгээр ахлуулж, Батлут, Доржханд, Чинзориг, Цэрэнпунцаг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа.

Байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэндээ танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн зарим нэр томъёог олон улсын стандарт болон бусад хуулийн зохицуулалттай нийцүүлэх, Зохицуулах зөвлөлийг зохицуулах хороо болгон өөрчилж байгаатай холбогдуулан төсөлд тусгагдаагүй, орхигдсон зарим зүйл, заалтын нэр томъёог жигдэлж, өөрчлөх чиглэлээр ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Хот, суурины усан хангамж, ариутгах, татуурга ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудыг Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хот, суурины ус хангамж, ариутгах, татуурга ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа,

Г.Занданшатар: Байнгын хороо энэ санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа. Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна.

Б.Энхбаяр: Баярлалаа.1 асуулт байгаа юм. Өргөн барьсан хуулийн төслийн 8.1.4-т ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг орон нутгийн өмчит аж ахуйн

нэгж, байгууллагын удирдлагад тухайн чиглэлээр мэргэшсэн хүнийг, хот суурины усан хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн томилж, чөлөөлөх гэдэг ийм заалт нэмэх гэж байгаа юм.

Тэгэхээр энэ заалт нь өөрөө бас их зөрчилтэй байгаад байгаа юм. Яагаад зөрчилтэй байна вэ гэхээр орон нутгийн өмчит компанийн удирдлагыг төрийн захиргааны төв байгууллагын даргын саналаар томилох буюу орон нутгийн өмч, төрийн өмч гэдгийн зааг, ялгаа алга болж байгаа нэг ийм асуудал байгаад байгаа юм.

Бид нар Өмчийн тухайн хууль Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн баригдсан. Энэ дээр бол төрийн өмч, орон нутгийн өмчийн асуудлыг нэлээн зааглаж байгаа. Тэр дундаа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг бид шинэчилж, батлаад мөрдөж байгаа. Үүгээр юу гол зааг, ялгаа ярьж байна вэ гэхээр энэ өмчийг төрийн болон орон нутгийн өмч гэж ялгаж байгаагийн гол агуулга юун дээр гарах вэ гэхээр орон нутгийн өмчийн асуудал дээр төв, Засгийн газар оролцохгүй. Төв, Засгийн газрын асуудал буюу төрийн өмч дээр орон нутгийн удирдлага оролцохгүй гэсэн үг. Үүгээрээ гол цаад энэ өмчийг ялгаж байгаагийн эрх зүйн үр дагавар гарч ирдэг. Тэгэхээр энэ хууль дээр бид нар орон нутгийн өмчийн компанийн удирдлагуудыг нь төв Засгийн газар буюу Барилга, хот байгуулалтын сайд мэдээд эхэлчихвэл тэр орон нутгийн өмч гэж байхын эсвэл орон нутгийн өмчийн компани гэж байхын утга агуулга юу билээ болоод явчих ийм асуудал байгаад байгаа юм. Тийм учраас энэ асуудал Байнгын хороон дээр хөндөгдөж яригдсан уу гэдэг ийм асуулт байна.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг хариулья.

М.Оюунчимэг: Байнгын хорооноос томилогдсон ажлын хэсэг дээр нэг нэггүй заалтууд яригдсан. Гэхдээ ажлын хэсгийн хүрээнд таны саяын дурдсан 8.1.4 хөндөгдөөгүй, яг оруулж ирсэн төслөөрөө үлдсэн байгаа. Яагаад гэвэл мэргэжлийн байгууллага судалгаа, туршлага дээр үндэслээд энэ заалтуудыг оруулж ирсэн учраас ажлын хэсэг энийг хөндөөгүй. Энэ өөрөө заалт нь бол саяын таны хэлснээр Барилга, хот байгуулалтын яам тухайн орон нутгийн бүрэн эрхэд халдсан зүйл бол байхгүй байгаа юм байна лээ. Тэгэхээр Батсуурь дарга юм уу, ажлын хэсгийнхний яг энэ дээр тайлбар байвал хэлчхээрэй. Ажлын хэсгийн хүрээнд энэ асуудал хөндөгдөөгүй.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдээ танилцуулчихъя. Энэ Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуйн инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгслийг зохицуулах газрын дарга Ганчулууны Цогтсайхан, тус яамны Хуулийн хэлтсийн дарга Батдэлгэрийн Нямдорж, тус яамны Нийтийн аж ахуйн инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах бодлогын газрын ахлах шинжээч Рэнцэнсүрэнгийн Батчимэг, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Жамъянсүрэнгийн Батсуурь, Хот, суурины ус хангамж, ариутгах татуурга ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Тусгай зөвшөөрөл хэрэглэгчийн газрын дарга Гантөмөрийн Нарантуяа.

Зочид танилцуулья. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их

Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхныг үс ерөөе.

83 хариулья.

Ж.Батсуурь: Та бүгдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Тэгэхээр энэ орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн аж ахуйн байгууллагууд нь бол ундны ус, ахуйн хэрэглээний усаар хангадаг, бохир усыг нь татан зайлуулдаг, мэргэжлийн ажил үйлчилгээ эрхэлдэг ийм байгууллага байгаа юм. Мэргэжлийн байгууллага. Тэгэхээр Зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрөл авч, Зохицуулах зөвлөл өдөр тутмынх нь үйл ажиллагааг бас зохицуулах чиг үүрэгтэй ажилладаг.

Тэгэхээр энэ мэргэжлийн байгууллагын удирдлага нь өөрөө усан хангамж гэдэг маань хүний эрхийн анхдагч хүчин зүйл. Ундны усаар хангагдах эрх нэгдүгээрт. Хоёрдугаарт олон улсын түвшин.../үг тасрав./

Г.Занданшатар: Гишүүд чуулганы танхим цуглаарай. Асуулт хариултын цаг дуусан. Санал хураалт.

Ж.Батсуурь: ...Усны аюулгүй байдлын асуудлын хүний эрүүл мэндийн, нийгмийн эрүүл мэндийн асуудал дагнаж яригддаг асуудал учраас үүнийг мэргэжлийн удирдлагыг эрхэлсэн сайдтай нь зөвшилцөх зарчмаар орон нутгийн удирдлага томилно л гэсэн ийм санаа агуулга байж байгаа юм. Зүгээр зөвшилцөх гэдэг утгаар нь. Болж өгвөл бас мэргэжлийн, тухайн асуудлаа бас ойр дөт ийм хүнээр томилогдвол бас бидний ажилд цаашдаа хэрэгтэй байгаа юм.

Тэгээд зарим аймгуудын удирдлага 3, 4 жилийн хугацаанд 4, 5 удаа солигддог. Дандаа мэргэжлийн биш, өөр салбарын хүмүүс томилогддог учраас энэ асуудал бас яригдаж, ингэж бас тодорхой

хэмжээний өөрчлөлт оруулах нь зүйтэй юм гэж энэ асуудал орж ирсэн юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тэгэхдээ энэ асуултын гол нь энэ хуульч хүн тайлбарлахгүй бол. Ер нь энэ өмчийн ялгааг их тодорхой болгохгүй бол өмчийн захиран зарцуулах эрх гэдэг бол тухайн эзэндээ 100 хувь үйлчлэх ёстой. Захиран зарцуулах, эзэмших, ашиглах эрхийг Засгийн газар шийддэг болчхоод байгаа. Орон нутгийн өмчийг.

Одоо санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 12 санал байна. Санал хураалт явуулна. Санал хураалт явуулна. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна. Эдийн засгийн хороо дэмжсэн санал бол

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1-ийн 3.1.20 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.20.“бохир ус” гэж хүн амын ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанаас бий болсон, эсвэл тухайн нутаг дэвсгэрээс хурын ус зайлуулахад үүссэн шингэн хаягдлыг”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг, Дамбын Батлут, Тогмидын Доржханд, Содномын Чинзориг, Цэдэндамбын Цэрэнпунцаг цаашид ажлын хэсэг гэнэ.

Санал хураалт явуулахад бэлдээрэй. Энэ “эсвэл” гэж яагаад бичээд “эсхүл” гэж бичдэггүй юм уу? “Эсхүл” гэж бичнэ шүү дээ. “Эсвэл” гэх юм бол наадах чинь давхар их буруу ойлголт. “Эсхүл” гэдэг нь бол хоёр нөхцөл заавал зэрэг хангагдахгүй гэвэл. Энэ аль нэг нь гэж. Энэ “эсвэл” гээд

ийм хууль зүйн жигдлээгүй нэр томъёо ашиглах бол энэ хоёулаа хамт мөрдөгдөх шаардлага орж ирж болзошгүй. Эдийн засгийн байнгын хороо энийг. Энэ найруулгыг эцсийн хэлэлцүүлэгтээ анхаараарай. Анхаарах чиглэл өгч байна. Санал хураалт явуулья.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг нь их сайн залуу, өглөө ирээд их ус уух л юм гэсэн гэж байгаа юм. Дараагийн санал хураалт.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4-ийн 10.1.10 дахь заалтын “журам,” гэснийг мөн 10.1.12 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4-ийн 10.1.13 дахь заалтыг 10.1.12 дахь заалт болгон өөрчилж, тус заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.12.энэ хуулийн 3.1.14-т заасан хангагчийн үйлчлэх хүрээг тогтоох журам батлах.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Батсуурь даргаа та ер нь Монгол хэл, цэвэр усны хангамжийн гэж болдоггүй юм уу? Заавал хангагчийн энэ тэр гэж. Харин тэгээд л цэвэр усны хангамжийн эх үүсвэрийг. Санал дэмжигдсэн.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт болон 16.2.7 дахь заалтыг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ Монгол хэлний нэр томъёо энэ тэрийг сайн асууж байх хэрэгтэй шүү. Санал хураалт.

59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ чинь ер нь цэвэр усны үйлчилгээ хангамжийн байгууллага л биз дээ? Хуучин чинь ус хангамжийн газар л гэдэг байсан шүү дээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 7-ийн 20.4 дэх хэсгийн “хорооноос” гэснийг “хорооны тогтоосноос” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийг 2 дугаар зүйл болгон өөрчилж, тус зүйлийн 2-ын 8.1.2 дахь заалтын “системийг” гэснийг “барилга, байгууламжийг” гэж, мөн зүйлийн 4-ийн 10.1.1 дэх заалтын “үнэ тариф” гэснийг “тарифыг” гэж тус тус өөрчилж, 10.1.1 дэх заалтын “тухайн орон нутагт мөрдүүлэх” гэснийг, мөн заалтын “тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифыг” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 1-ийн 3.1.19 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.19.”саарал ус” гэж ямар нэгэн ялгадасгүй зөвхөн ахуйн бохир усыг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ нэр томъёонууд, үг, үсгийг энэ Монгол хэлнийхээ энэ тэр дээр нягталж үзээрэй. Энэ Эдийн засгийн байнгын хороо энэ хууль зүйн юмнууд нь дандаа “эсхүл” нь тэр бас их зовлонтой юм байна шүү.

Батсуурь дарга чинь хаана төгслөө? Дунд, доод шатны нөгөө. Чех.

Найруулгын саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтад “3.1.22” гэсний дараа “, 3.1.23” гэж, 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон өөрчилж, тус зүйлд “9.9” гэсний дараа “9.12” гэж, “10.2 дахь” гэсний дараа “хэсэг, 22 дугаар зүйлийн 22.2 дахь” гэж, “судалгаа” гэж” гэсний дараа “9.13 дахь хэсгийн “зөвлөлийн” гэснийг “хорооны” гэж,” гэж, “8.1.7” гэж” гэсний дараа “10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалтын дугаарыг “10.1.13.” гэж” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

25 гишүүн дэмжиж 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Хуучин МОНЦАМЭ-гийн модон л гэж ярьдаг байсан. Одоо Эдийн засгийн байнгын хорооны эрлийз хэл гэж ярмаар л болсон.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн “12.1 дэх хэсгийн” гэснийг “12.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.18 дахь заалтын” гэж, мөн зүйлийн “8.1.7” гэснийг “8.1.8” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 2-ын 5.1.9 дэх заалтын “орчин болон хот, суурины ус хангамж, ариутгах татуургын” гэснийг “орчны” гэж, “гишүүд” гэснийг “гишүүнтэй” гэж, “батална” гэснийг “батлах” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн “7.1.3 дахь заалтын дугаарыг “7.1.4” гэж,”

гэснийг болон “9.8 дахь хэсэг” гэсний дараах “9.10,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.1 хувийн саналаар санал дэмжлээ.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг заалтын болон эшлэлийн дугаарыг өөрчилж, төслийн агуулга зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын засвар хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Баделхан гишүүн Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн Оюунчимэг гишүүд нь үг, үсгийг нь бас бусад хууль энэ тэртэйгээ нийцүүлээд сайн үзээрэй.

Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяагийн урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын удирдлага, гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс сайн сайхныг хүсье. Дараагийн асуудалд орно.

15.55 цаг

Арван нэг.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мөрдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хууль зүйн байнгын

хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар танилцуулна. Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга, Монгол Улсын сайд Жамъянхорлоогийн Сүхбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 2 дугаар тогтоолоор дээрх хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар миний бие, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар, Мөнх-Оргил, Пүрэвдорж, Раднаасэд, Б.Энх-Амгалан нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Хууль зүйн байнгын хороо 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан болно.

Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар Монгол Улсын Засгийн газраас, Иргэдээс төрийн

байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаатай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8-д заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хууль зүйн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгай журмаар шийдвэрлэх маргаанд Засгийн газар, Монголбанкнаас гаргасан шийдвэрийг оруулж байгаа үндсэн шаардлагын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг төслөөс хасах, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан

өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг төслөөс хасах санал дэмжигдсэнтэй холбогдуулан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах;

-хуулийн төслийн нэр томъёог зүйл, хэсэг, заалт хооронд болон холбогдох бусад хуулийн нэр томъёотой нийцүүлэх зэрэг болно.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын

томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулья. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Өлзийбатын Мөнх-Ундарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Лувсанцэрэнгийн Пүрэвсүрэн.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ. Алга байна, тасаллаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 15 санал байгаа.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1, 7, 8, 9, 10, 11 дэх заалтыг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жамьянхорлоогийн Сүхбаатар, Лхагвын Мөнхбаатар, Цэндийн Мөнх-Оргил, Бөхчулууны Пүрэвдорж, Шатарбалын Раднаасэд, Бямбасүрэнгийн Энх-Амгалан цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт. 23 гишүүн дэмжиж, 53.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “эсхүл шаардлагатай” гэснийг “шаардлагатай” гэж өөрчилж, мөн зүйлийн “эрх олгосноос бусад тохиолдолд” гэсний өмнө “хуулиар” гэж нэмж, мөн зүйлийн “93 дугаар зүйлийн

гарчгийн “захиргааны байгууллага” гэсний дараа “, түүний нийтлэг үүрэг” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “зүйл,” гэснийг, мөн зүйлийн 4, 5 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Баделхан гишүүн өөрийнхөө санал хураалтыг дэмжчихээд, одоо эсрэг санал өгөхөө болимоор байна. Зочид танилцуулья.

“Парламентын боловсрол” хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ажилтнуудын хүүхдүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хэрэг эрхлэх газрын ажилтнуудын хүүхдүүд та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье.

51.2 хувь. 4 дэх заалт. Төслийн 4 дүгээр зүйлийн “94 дүгээр зүйлийн 94.4 дэх хэсгийн “30” гэснийг “21” гэж,” гэснийг хасах. Санал авсан ажлын хэсэг. Санал хураалт. 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын саналаар санал хураалт явуулья.

1.Саналын томьёоллын 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 1 дүгээр зүйлийн “зүйл, хэсэг, заалт,” гэснийг “хэсэг,” гэж, мөн зүйлийн 2 дахь заалтын тайлбарын “зохицуулалтын” гэснийг “зохион байгуулалт, зохицуулалтын” гэж, 3 дахь заалтын 60.5 дахь хэсгийн “уг” гэснийг “тухайн” гэж, 4 дэх заалтын 64.6 дахь хэсгийн “хуульд заасан Засаг дарга” гэснийг “Засаг даргын хуульд заасан” гэж, 5 дахь заалтын тайлбарын “, цахим холбоос /эрх зүйн

мэдээллийн нэгдсэн санд байршуулсан/-ын,” гэснийг “эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулсан цахим холбоосын” гэж тус тус өөрчилж, мөн тайлбарын “зөвхөн” гэснийг хасах. Санал авсан ажлын хэсэг. Санал хураалт. 51.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Раднаасэд гишүүн хаачив? Бат-Амгалан гишүүн, Цэрэнпунцаг гишүүн хоёр сөрөг гараад байна шүү. Эдийн засгийн байнгын хорооныхон өглөөнөөс хойш тэгээд л хуулиа хэлэлцүүлчхээд гарч яваад байна шүү.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүдийн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

1.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Ажлын хэсэг. Сайд нар яасан бэ? Сандагийн Бямбацогт, Жамбалын Ганбаатар. Энэ 2 сайд байсан хаачсан? Санал хураалт.

Цэдэндамбын Цэрэнпунцаг, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, Ганзоригийн Тэмүүлэн, Жамъянгийн Мөнхбат. Архангай гурван гишүүнийг танхимд урьж байна.

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Аялал жуулчлалын хуулийг 11 цагт хэлэлцэж эхэлбэл сайн байна гэсэн байна. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Нийтийн сонголын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Содномын Чинзориг гишүүн. Санал хураалттай шүү одоо. Хөөгөөд ир.

16.10 цаг

Арван хоёр.Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт үрэн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Түр хорооны дарга Энхтайваны Бат-Амгалан танилцуулна. Энхтайваны Бат-Амгалан гишүүнийг индэрт урьж байна. Сайнзориг дарга.

Э.Бат-Амгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт

бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 6 дугаар тогтоолоор хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан миний бие, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт, Дэлгэрсайхан, Жаргалмаа, Мөнх-Оргил, Сэргэлэн нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Хууль зүйн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

Шүүх шинжилгээний байгууллагын шинжээчийн хараат бус байдлыг хангах зорилгоор шинжээчийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах программ хангамж ашиглах;

-Шинжилгээ хийлгэх, иргэдийн эрх ашгийг хамгаалах, шинжилгээний найдвартай байдлыг хангах, шаардлагатай урвалж бодисын нөөцийг бүрдүүлэх зорилгоор шинжилгээнд ашигладаг урвалж бодис, лабораторийн тоног төхөөрөмжийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

худалдан авах тухай хуульд заасны дагуу шууд гэрээ байгуулах замаар шийдвэрлэх;

Алба хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор цогц үзлэг хийх, зөөвөрлөх, задлан шинжлэх ажиллагааг гүйцэтгэсний нэмэгдлийг шүүх шинжилгээний алба хаагчид олгох;

Шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн санд экологийн шинжилгээний санг шинээр нэмж, шинжээч болон бусад албан хаагч шинжилгээний байгууллагын шинжилгээний адилтгал, мэдээллийн санг бусад этгээдэд шилжүүлэх, хуулиар хүлээсэн чиг үүрэгтээ хамааралгүй зорилгоор ашиглахыг хориглох;

-Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хуулиар хориглосноос бусад тохиолдолд шүүх, прокурорын зөвшөөрснөөр шинжилгээний дүгнэлтийг хийх журам, шинжлэх ухааны үндэслэлийн талаар хэргийн оролцогчоос бусад этгээдэд мэдээлэл өгөх;

-Алба хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор амь нас, эрүүл мэндийг даатгах зэрэг болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргасан бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонх дэмжээгүй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.19-д заасны дагуу цөөнх болж, нэгдсэн хуралдаанд үг хэлж, саналаа тайлбарлан санал хураалгахаа илэрхийлсэн болно.

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцууллаа. Байнгын хорооноос гаргасан 45 зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Энэ зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудтай холбогдож, Байнгын хорооны санал, дүгнэлтийн талаар асуусан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Нармандахын Жамъянхүү, Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн захирал, цагдаагийн хурандаа Жаргалын Буянбат, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Бадамдоржийн Жаргал, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Лхамдоржийн Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга,

цагдаагийн хурандаа Идэрийн Батчулуун, Шүүхийн шинжилгээний дүн бүртгэл мэдээллийн газрын захирал, цагдаагийн хурандаа Даваацэрэнгийн Мөнхбат, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн газрын дарга, цагдаагийн хурандаа Гүржавын Дагиймаа. Дагиймаа алга байна. Хасаж тэмдэглэ. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Стратеги, төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил эрхэлсэн дэд захирал шинжээч эмч Гойдовнямын Баатаржав, Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Агваанцэрэнгийн Амгаланболд, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний газрын дарга, цагдаагийн ахмад Өлзийдэлгэрийн Сэр-Од, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газрын дарга, цагдаагийн хошууч Хашхүүгийн Бат-Эрдэнэ, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Баатарын Ламчин, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистик шинжилгээний газрын чиглэлийн ахлагч мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Батсүхийн Эрдэнэ-Очир, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач Дамбын Ганхүрэл, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ахлах зөвлөх Буяннэмэхийн Жамбал.

Асуулт байхгүй. Одоо санал хураалт явуулна. 45 санал байгаа. Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “ажиллагааны” гэсний өмнө “, зөрчил шалган шийдвэрлэх” гэж нэмж,

“эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад” гэснийг “гэмт хэргийн улмаас” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан, Сандагийн Бямбацогт, Борхүүгийн Дэлгэрсайхан, Бадарчийн Жаргалмаа, Цэндийн Мөнх-Оргил, Цэдэвийн Сэргэлэн. Цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт. 53.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалтын “Монгол Улсын хууль, Монгол Улсын” гэснийг “хууль тогтоомж болон” гэж өөрчилж, “хуульд заасан” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Баттөмөр Энхбаяр гишүүн, Содномын Чинзориг гишүүнийг аваад ороод ирээч. Мөнхбаатар гишүүн Хууль зүйн байнгын хорооны дарга энэ Архангайн гурван гишүүнийг олж ирье. Жамъянгийн Мөнхбат, Ганзоригийн Тэмүүлэн, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг.

Санал хураалт. 54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 9.3, 9.5 дахь хэсэг тус тус нэмэх:

“9.2.Шинжилгээний байгууллага нь шинжилгээг шинжилгээний төрөл тус бүрээр урьдчилан мэдэх боломжгүй санамсаргүй тохиолдлоор хуваарилах программ хангамж ашиглан шинжээч, эсхүл шинжээчийн багт хуваарилна.”

“9.3.Энэ хуулийн 9.2-т заасан программ нь хуваарилагдах шинжээчийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг

бүрдүүлж, дараах шаардлага хангасан байна:

9.3.1.шинжилгээний байгууллага шинжилгээ хийлгэх шийдвэр шинжилгээний объектыг хүлээн авсан даруй хуваарилалтыг хийх, хуваарилалтыг өөрчлөх боломжгүй хамгаалалттай байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд шууд өгөх боломжтой байх;

9.3.2.шинжилгээг хуваарилахдаа шинжээчийн мэргэжил, ажлын дадлага, туршлага, мэргэшсэн байдал, эрдмийн зэрэг, цол, ажлын ачаалал зэргийг харгалздаг байх;

9.3.3.цахимаар хийгдсэн хуваарилалтыг гагцхүү энэ хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, эсхүл шинжээч, шинжээчийн бүрэлдэхүүн солигдох нөхцөлд өөрчлөх бөгөөд уг өөрчлөлт нь хүний нөлөөллөөс ангид, ил тод, баримтжуулсан байх.”

“9.5.Энэ хуулийн 9.2-т заасан шинжээчид цахим программ хангамж ашиглан шинжилгээг хуваарилах журам болон энэ хуулийн 9.3-т заасан нөхцөл, шаардлагыг шүүх шинжилгээний төв байгууллагын дарга батална.”. Санал гаргасан ажлын хэсэг.

Тэр 9-ийн 2 шинжилгээний байгууллага нь шинжилгээг шинжилгээний төрөл тус бүрээр гэдгийг найруулах хэрэгтэй юм байна шүү.

Санал хураалт явуулъя. 54.8 хувиар салах санал дэмжигдлээ.

Үг, үсгийн найруулгыг нь эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараад, дээр нь программ хангамжаар хуваарилна гэж байгаа мөртөө зэрэг, цол, туршлага энэ тэр

харгалзана гэдэг чинь программ хангамжийн өгөгдөл нь байх юм уу? Аль эсвэл тусдаа байгаа юм уу? Энийг программ хангамжийнхаа өгөгдөлд анхаарна гэхгүй бол салаа утгатай уншигдаж байна.

4.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн, мөн зүйлийн Тайлбарын “шинжилгээ хийлгэхээр даалгах” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах” гэж өөрчилж, 9.4 дэх хэсгийн “Шинжилгээ хийлгэхээр даалгах эрх бүхий албан тушаалтан” гэснийг, “байгууллагын тэмдгээр” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 11 дүгээр зүйлийн гарчиг, 11.1 дэх хэсгийн “түдгэлзүүлэх,” гэсний дараа “сэргээх,” гэж, мөн хэсгийн “саналыг” гэсний өмнө “ажиллана. Зөвлөлийн” гэж, 11.3 дахь хэсгийн “тэмдэг” гэсний өмнө “хувийн дугаар бүхий” гэж тус тус нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 11.4.6, 11.5.3 дахь заалт нэмэх.

“11.4.6.тусгай мэдлэг эзэмшсэнийг гэрчлэх мэргэжлийн үнэмлэх, дипломтой байх.”

“11.5.3.хуульд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.9 дэх хэсгийн “11.5.1, 11.7.3, 11.7.4-т” гэснийг “11.7.3, 11.7.4, 11.7.5-д” гэж, “11.5.2, 11.7.1, 11.7.2, 11.7.5, 11.7.6, 11.7.7, 11.7.8-д” гэснийг “11.5.1, 11.5.2, 11.7.1, 11.7.2, 11.7.6, 11.7.7, 11.7.8-д” гэж тус тус өөрчилж, 11.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, Тайлбарыг 8 дугаар зүйлд шилжүүлэх.

“11.12.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах журам, маягтын загварыг батална:

11.12.1.мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн санг нийтэд танилцуулах, шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдэг, маягт ашиглах журам;

11.12.2.зөвлөлийн үйл ажиллагааны журам;

11.12.3.шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдэг, дүгнэлтийн маягтын загвар.”. Санал гаргасан ажлын хэсэг. Тилеуханы Аубакир гишүүн суу. Санал хураалт явж байна. Аубакир гишүүн суу. Санал хураалт. 52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “амархан” гэсний өмнө “түргэн,” гэж нэмж 13.7 дахь хэсэг болгон шилжүүлж, 12.4.1 дэх заалтын “нийтийн” гэсний өмнө “олон” гэж нэмж, 12.4.3 дахь заалтын “дурсгалт зүйл болон түүх, соёлын” гэснийг “болон” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал дэмжигдсэнгүй.

Ер нь тэгэхдээ угаасаа гүйцээн боловсруулах, анхаарах асуудлууд байна. Дурсгалт зүйл болон түүх соёлын энэ тэр гэснийг эцсийн хэлэлцүүлэгт анхаарах. Гүйцээн боловсруулах.

8.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “архив үүсгэн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.1 хувийн саналаар энэ санал дэмжигдээ.

9.Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16.4 дэх хэсгийн “шинжилгээ даалгасан” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах” гэж тус тус өөрчлөх.

“16.3.Шинжээч энэ хуулийн 16.1-д заасны дагуу тогтоосон хугацаанд шинжээчийн дүгнэлт гаргах боломжгүй бол хугацаа дуусахаас өмнө шинжилгээний байгууллагын хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтанд хугацааг сунгуулах тухай хүсэлтээ өөрийн биеэр мэдэгдэж, хүсэлтээ тайлбарлана.”. Санал гаргасан ажлын хэсэг.

Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэлх гишүүн үг хэлж болно. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Би энэ саналыг дэмжиж дэмжиж үг хэлж байгаа. Тэгэхдээ энэ хуулийг баталсны дараа зөв ойлгож, хэрэгжүүлэх талаас нь Их Хурлын чуулганы протокол зориуд тэмдэглэж үлдээх гэж байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр шүүх шинжилгээний байгууллагын шинжээч нь шүүхийн шинжилгээний энэ дүгнэлтийг хэнээс ч хараат бусаар гаргадаг байх ёстой. Энэ асуудал бол үүрэгжүүлж энэ хуульд тусгагдаж байгаа. Энэ шинжээчийн гаргасан дүгнэлтэд тухайн байгууллагын дарга нь ч бай, өөр этгээд бай энэ дүгнэлтийг өөрчлүүлэх талаар нөлөөлөх ийм оролцох ийм эрх байхгүй. Энэ нь бол мөн хориотой байгаа хуулиар. Энэ 16.3, 4 дээр шинжилгээний байгууллагын хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан гэдэг ойлголт байгаа. Энэ бол тухайн шинжээчийн удирдах нэгжийн дарга л даа. Тэгэхээр энэ хуваарилалтыг баталгаажуулах гэдэг энэ заалтыг тэр байгууллагын дарга нар шинжээчийн дүгнэлтийг өөрчлөх эрхтэй мэтээр ойлгож хэрэгжүүлж болохгүй гэдгийг би зориуд хэлэх гэж байгаа юм. Баталгаажуулна гэдэг бол энийгээ ингээд янзлаад ир, тэгсний чинь дараа би баталгаажуулья гэж дарга тэр шинжээчийн дүгнэлтийг өөрчлөх эрх байхгүй шүү. Ингэж мушгиж, хэрвээ

ойлгож хэрэгжүүлбэл энэ хууль шууд бүхэлдээ гажуудна. Шууд гажуудна.

Тийм учраас би зориуд энэ шинжилгээний байгууллагын хуваарилалтыг баталгаажуулах гэдэг энэ үгийг шинжилгээний дүгнэлтийг өөрчлөх гэж ойлгож хэрэгжүүлэхгүй шүү. Ингэж ойлгохгүй шүү. Хууль тогтоогч бол ингэж ойлгож энэ үгийг оруулаагүй шүү гэдгийг би зориуд протоколд тэмдэглэж байгаа юм.

Г.Занданшатар: Үг хэлээ. Санал хураалт явуулья. Тэгээд хүсэлтээ гаргана гэснийг л биеэр мэдэгдэж хүсэлтээ тайлбарлана гэсэн тийм. Санал хураалт явуулья. 54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

1 санал хураалтаар 2 заалтуудыг ингэж зэрэг л өөрчилдөг болчхоод байгаа юм даа.

10.Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.4 дэх хэсэг нэмэх:

“18.4.Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хуулиар хориглосноос бусад тохиолдолд шүүх, прокурорын зөвшөөрснөөр шинжилгээний дүгнэлтийг хийх журам, шинжлэх ухааны үндэслэлийн талаар хэргийн оролцогчоос бусад этгээдэд мэдээлэл өгч болно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ их сонин заалт байна шүү бас. 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтын “мөрдөгч” гэсний өмнө “зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд,” гэж нэмж, 19.3 дахь хэсгийн “шинжилгээ хийлгэхээр даалгасан эрх бүхий албан тушаалтанд” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан

тушаалтанд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 22.3.5 дахь заалт нэмэх:

“22.3.5.экологийн шинжилгээний сан.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 24.5 дахь хэсэг нэмж, 24.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 24.3 дахь хэсгийн “ажлын шаардлагаар” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“24.2.Шинжилгээний байгууллагын шинжээч болон бусад алба хаагч шинжилгээний байгууллагын шинжилгээний адилтгал, мэдээллийн санг бусад этгээдэд шилжүүлэх, хуулиар хүлээсэн чиг үүрэгтээ хамааралгүй зорилгоор ашиглахыг хориглоно.”

“24.5.Шинжилгээний адилтгал, мэдээллийн сангийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах хүрээнд шинжилгээний байгууллага шаардлагатай программ хангамж, техник хэрэгслээр хангагдсан байна.”

14.Төслийн 29 дүгээр зүйлийн гарчгийн “багаар” гэсний өмнө “**шинжээчдийн**” гэж нэмж, 29.2 дахь хэсгийн “шинжилгээ хийлгэхээр даалгах эрх бүхий албан тушаалтан **шинжилгээ хийлгэхээр даалгах**” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах нэгжийн дарга тодорхойлно. Бусадтай хамтран ажиллах журмыг шүүх шинжилгээний төв байгууллагын дарга батална” гэж, 29.4 дэх хэсгийн “шинжилгээ хийлгэхээр даалгах”

гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах” гэж тус тус өөрчилж, 29.1 дэх хэсгийн “хоёр, түүнээс дээш” гэснийг хасах. Санал хураалт.

Айн? Энэ хоёр, эднүүс дандаа 13, 14 хамтдаа хураагаад байгаа юм. Тэгж бичсэн юм байна. 54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “саналаа дүгнэлтэд хавсаргана” гэснийг “дүгнэлтээ тусдаа гаргана” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Хууль зүйн байнгын хорооны референт Үнэнбат ажилласан уу энэ дээр? Сая 14 дүгээр саналыг тэр 24-ийн 1, 2-ыг яагаад шууд ингээд явчхаж байгаа юм? 24-ийн 2, 24-ийн 5 хоёртой?

Энэ санал дэмжигдсэнгүй. Адьшаа гишүүн. Энэ чинь 15. Энэ санал дэмжигдсэнгүй. Дараагийн асуудал.

16.Төслийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсгийн “нотлогдсон” гэснийг “тогтоогдсон” гэж, 33.6 дахь хэсгийн “тухайн нөхцөл байдалд” гэснийг “боломжит нөхцөлд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Нотлох баримтаар тогтоогдох, нотлогдох. 54.8 хувийн саналаар санал дэмжигдсэн.

17.Төслийн 38 дугаар зүйлийн 38.6.3 дахь заалтын “эргэлзээтэй бол” гэсний дараа “байгаль орчинд нөлөөлөх байдлын” гэж нэмж, 38.1 дэх хэсгийн “хуулийн 38.5-д” гэснийг “хуульд зааснаас” гэж өөрчилж, 38.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.1 хувиар дэмжлээ.

17.38 дугаар зүйлийн 38.

18.Төслийн 39 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“39.1.8.энэ хуулийн 40.1-д заасан сэтгэцэд учирсан хор уршиг;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

39.1.8 чинь бусад хохирол гэж байгаа шүү дээ. Тэр 39.1.8-аа яагаад өөрчилж байгаа юм? 39 дээр заалт хасагдаагүй байхад. 39.1.9 гэж нэмэгдэнэ шүү дээ. Найруулгаараа дараа бусад нь 39.1.9 рүүгээ орно биз.

19.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “Арван хоёрдугаар бүлэг/” гэсний дараа “Хүний” гэж, 40.2.1 дэх заалтын “энэ хуулийн” гэсний өмнө “хохирогч нь” гэж тус тус нэмж, 40.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 40.1 дэх хэсгийн **“26.3 дугаар зүйл /Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/,”** гэснийг, 40.2.4, 40.2.5 дахь заалтыг тус тус хасах.

“40.2.2.энэ хуулийн 40.1-д заасан гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэцэд түр зуурын, эсхүл байнгын шинжтэй өөрчлөлт орсон байх;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.1 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн.

20.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн “ажиллагааны” гэсний өмнө “, шүүхийн шийдвэр гүйцэтгэх” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсгийн “Шинжилгээний байгууллагын шинжилгээ даалгах эрх бүхий албан тушаалтан шинжилгээний хугацаа сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш” гэснийг “Яллагдагч,

шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах хугацааг сунгахдаа” гэж өөрчилж, 44.4 дэх хэсгийн “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Төслийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсгийн “тусламж” гэсний дараа “, үйлчилгээ” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 45.1.5 дахь заалт нэмэх:

“45.1.5.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэрэглэгдээгүй болон хэрэглэхийг хориглосон эм тариа, арга хэрэгсэл хэрэглэх.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.1.Хүний биед шинжилгээ хийхдээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэрэглэгдээгүй болон хэрэглэхийг хориглосон эм тариа, арга хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ чинь угаасаа л хуулиар хориотой л доо энэ чинь. 65.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Төслийн 48 дугаар зүйлийн гарчгийн, 48.1, 48.2, 48.3 дахь хэсгийн, 48.1.3 дахь заалтын “шинжилгээ хийлгэхээр даалгах” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах” гэж тус тус өөрчилж, 48.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 48.1.5 дахь заалтыг хасах.

“48.2.1.шинжилгээний хуваарилалтыг энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэх;”. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4.6 дахь заалтын “этгээдэд” гэсний дараа “шүүх, прокурорын зөвшөөрөлгүйгээр” гэж нэмж, “шинжилгээ хийлгэхээр даалгах” гэснийг “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах” гэж өөрчилж, 49.2.1, 49.2.2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“49.2.1.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тавьсан асуултын дагуу шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой хийж, тогтоосон хугацаанд дүгнэлт гаргах;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төслийн 55 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 55.1.3 дахь заалт нэмж, 55.1.7 дахь заалтын “шинжилгээний байгууллагын хэмжээнд онцгой дэглэм тогтоох,” гэснийг, 55.1.8 дахь заалтын “гамшиг, гамшгийн” гэснийг тус тус хасах.

“55.1.3.шинжилгээний байгууллага, шүүх шинжилгээний үйл ажиллагааг шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах хүрээнд шинжилгээний байгууллагыг шинжилгээний лабораторийн техник, тоног төхөөрөмж, программ хангамж, урвалж бодисоор шуурхай хангах, урвалж бодисын нөөцийг бүрдүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу шууд худалдан авах ажлыг зохион байгуулах;”. Санал гаргасан. Ажлын хэсэг санал хураалт.

Энэ заавал яагаад шууд худалдан авалт хийж байгаа юм? Энэ чинь нөөц бүрдүүлэхэд гэж байна шүү дээ. Нөөц бүрдүүлэхэд заавал шууд худалдан авах

ёстой юу? Угаасаа 5 сая төгрөгөөс дотогш бол тендер залахгүй байж болно л доо.

27.Төслийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийн “тусгайлсан шалгуур үзүүлэлтийг” гэснийг “энэ хуулийн 56.4-т заасныг” гэж, 56.7 дахь хэсгийн “шалгалтыг таван жил тутамд авна” гэснийг “шалгалтад таван жил тутам хамрагдана” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Түрүүчийн саналыг 60.5 хувиар дэмжсэн байгаа. Энэ 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Төслийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 62.1-д заасан” гэснийг “Шинжилгээний байгууллагын алба хаагчийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Төслийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсгийн “хэрэг, зөрчилд холбогдсон” гэснийг “хэрэгт яллагдагчаар татагдсан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ чинь бүрэн эрхийг түдгэлзүүлэх дээр. 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Төслийн 66 дугаар зүйлийн 66.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“66.1.2 гэм буруутай болох нь нотлогдож, шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төслийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт “хуульд” гэсний өмнө “, Цагдаагийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” гэж, төсөлд доор дурдсан агуулгатай 68.6 дахь

хэсэг тус тус нэмж, 68.2 дахь хэсгийг хасах.

“68.6.Цогцост үзлэг хийх, зөөвөрлөх, задлан шинжлэх ажиллагааг гүйцэтгэсний нэмэгдлийг шүүх шинжилгээний алба хаагчид олгоно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Төслийн 71 дүгээр зүйлийн 71.5 дахь хэсгийн “дээшлүүлэх” гэсний өмнө “, мэргэшил” гэж нэмж, “Сум, тосгоны” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 71.13 дахь хэсэг нэмэх:

“71.13.Шинжилгээний байгууллагын алба хаагчийн амь насыг заавал даатгах бөгөөд даатгалын төлбөрийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Төслийн 80 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 80.5, 80.6 дахь хэсэг нэмэх.

“80.5.Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь хэсгийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл шүүх шинжилгээг төрөл тус бүрээр шүүх шинжилгээний төв байгууллагын даргын баталсан түр журмаар хуваарилна.

80.6.Сэтгэцэд учирсан хор уршгийг үнэлэх, хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгуулахтай холбоотой Шүүх шинжилгээний тухай хууль болон дагалдах бусад хуулийн зохицуулалтыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Саналаа өгөөч гишүүн. 62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Төслийн 72 дугаар зүйлийн 72.9 дэх хэсгийн “хэмжээг” гэснийг “хэмжээ болон энэ хуулийн 72.6, 72.7-д заасан үнэлгээ, зардлын хэмжээг” гэж өөрчилж, 72.3 дахь хэсгийн “онцгой тохиолдолд” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналаар санал хураалт явуулна.

1.Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “дүгнэлт гаргах” гэсний дараа “болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шинжилгээ хийж, дүгнэлт гаргах” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.8 хувийн саналаар Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

2.Төслийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “шинжилгээний байгууллагад 18-аас” гэснийг “хууль сахиулах, шинжилгээний байгууллагад 15-аас” гэж, 54.4 дэх хэсгийн “шинжилгээний байгууллагад 15-аас” гэснийг “шинжилгээний байгууллагад 12-оос” гэж тус тус өөрчилж, 54.2 дахь хэсгийн “улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Энхтайваны Бат-Амгалан гишүүн үг хэлнэ.

Э.Бат-Амгалан: Байнгын хороон дээр дэмжээгүй саналаа ажлын хэсэг татаж байна дарга. Тэгээд гүйцээн боловсруулах чиглэл өгөөд, Байнгын хороон дээрээ энэ асуудлаа бас яриад эргэж, орж ирье.

Г.Занданшатар: Энэ татчихсан юм чинь Байнгын хороо яах вэ. Энэ саналыг ажлын хэсэг татаж авсан гэж ойлголоо. Татлаа, санал хураалт байхгүй. Гүйцээн боловсруулахгүй. Энэ хүнд тохируулж хууль өөрчлөхгүй. Дараагийн санал.

3.Төслийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “шинжилгээний байгууллагад 18-аас” гэснийг “шинжилгээний байгууллагад 10-аас” гэж, 54.4 дэх хэсгийн “шинжилгээний байгууллагад 15-аас” гэснийг “шинжилгээний байгууллагад 8-аас” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Санал гаргасан гишүүн үгээ тайлбарла. Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Энэ Шүүхийн шинжилгээний байгууллагын дарга болон дэд даргад Монголд байхгүй ийм өндөр босго шаардлага тавьж, хуулийн төсөл өргөн баригдсан юм. Тэрний энэ Шүүхийн шинжилгээний байгууллагын дарга нь болохоор шинжилгээний байгууллагад 18 жилээс дээш ажилласан байх, дэд дарга нь 15 жилээс дээш ажилласан байх гэдэг ийм хаана ч байхгүй ийм босго ороод ирсэн юм.

Тэгээд энийг хангасан бараг 1, 2 л хүн байгаа байх бараг. Тэгээд энэ хүнд зориулж хууль гаргаж болохгүй. Өөрийгөө хуулиар бас дархалж болохгүй. Тэгээд манай Монголын хамгийн өндөр босготой яамдын Төрийн нарийн бичгийн дарга чинь бид нар хуулиар бол нөгөө 50 хувийн шаардлага хангуул гэхээр 8 жил төрийн жинхэнэ албанд ажилласан байх гэдэг шаардлагатай байхгүй юу.

Тэгэхээр бүр түүнээс бүр 2 дахин их ийм шаардлагатай агентлаг гэж байж бол таарахгүй байгаад байгаа юм.

Тийм учраас энэ шаардлагыг багасгаж, дарга нь бол 10 жил, дэд дарга нь бол 8 жил гэдэг ийм босго тавья гэдэг саналыг бол миний бие гаргаад, манай бас ирц жоохон муутай байсан учраас энэ санал унасан юм. Тэрнээс биш яг энэ саналыг нь бол хууль санаачлагч Засгийн газар, Хууль зүйн сайд, ажлын хэсэг бүгд дэмжээд байсан юм уг нь. Тэгээд ирцээс болоод уначихсан юм. Тийм учраас та

бүхэн маань энэ саналыг дэмжиж, кнопдоо гар хүрэхгүйгээр босгож өгөөч гэж хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Хүнд тохируулсан хууль ингэж оруулж ирж болохгүй. Энийг итгэ, тэхдээ шалга гэсэн зарчмаар. Энэ Шүүхийн шинжилгээний газрын дарга хаана байна? 80. Яагаад ийм өөртөө зориулсан хууль оруулж ирсэн юм?

Ж.Буянбат: Их Хурлын даргын асуултад хариулъя. Би энэ ажил, албан тушаалд томилогдоод 2 сар болж байгаа. Хууль өргөн баригдсаны дараа томилогдсон юм байгаа юм.

Г.Занданшатар: Энэ хэдэн хүн шаардлага хангаж байгаа юм? Тэр 2 гэдэг нь үнэн үү? Шалгаж байна. Хэдэн хувийн шаардлага хангаж байгаа юм?

Ж.Буянбат: Төрийн нарийн хариулчих.

Г.Занданшатар: 81, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Яагаад та нар хүнд зориулж хууль хийгээд байгаа юм?

П.Сайнзориг: Энэ дээр бас яах вэ тухайн үедээ бас энэ шинжилгээний байгууллагад бас янз янзын хүмүүс бас орж ирээд байна гэдэг, толгойлоод байна гэдэг бас яг хуулийг хэлэлцүүлж байх явцад бас гарсан. Тэгээд энэ хэлэлцүүлгийн явцад зайлшгүй ингэж бас өндөр босго тавина гэсэн боловч бас яг Энхбаяр гишүүн нарын хэлж байгаа зүйл байгаад байгаа юм. Хэт бас цөөн тооны хүмүүст зориулагдаж байна. Энийг бас сонгон шалгаруулалтыг илүү их оролцогч олонтой болгох, тодорхой хэмжээнд бас нээлттэй, өрсөлдөөнтэй болгох үүднээс бас шалгуурыг жоохон буулгах нь зөв гэдэг дээр бол ажлын хэсэг дээр бас ярьсан, Байнгын хороон дээр яригдсан байгаа.

Ажлын хэсгээс бол энийг 3, 3 жилээр буулгая гэдэг санал оруулсан. Энхбаяр гишүүн бол 50 хувь лаад буулгачихъя гэдэг ийм санал байгаа.

Тэгэхээр ийм л зарчмын зөрүүтэй байгаа. Мэдээж өндөр босго бол өрсөлдөөн бас цөөн тооны хүнд явахыг бид хэд бас хүлээн зөвшөөрч байгаа учраас энэ саналыг бас эргэж гүйцээн боловсруулах л саналтай байгаад байгаа юм.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна. Санал хураалт явуулаад, тэгээд энэ саналыг зарчмын хувьд босгоод, тэгээд гүйцээж Байнгын хороон дээрээ ярилц. Санал хураалт. Дэмжихгүй байж болно гэсэн үг. Дэмжихгүй байна гэсэн үг.

Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдсэнгүй. Энэ санал босож байна. Ер нь энэ төрийн тусгай албадын юу нэг стандарт баймаар байгаа юм. Тэгш журамтай баймаар. Тэгэхгүй өөр өөр, ийм янз янзын хүнд тохируулсан юм шиг өөр өөр стандарт мөрдүүлж болохгүй. Төрийн албаны хуулийнхаа, төрийн тусгай албаныхаа нийтлэг стандартыг баримтлаад л гүйцээн боловсруулчих. Тийм шүү. Цагдаагаас томилогдож болно. Тагнуулын дарга дээр ч ийм шаардлага байхгүй шүү дээ. Прокурор дээр л. Ингэж энэ зарчим нийтлэг зарчмаар боловсруулна.

Хоёр. Найруулгын санал. Ер нь бас ийм хүнд тохируулж хаа юм оруулж ирдэг ийм юм Хууль зүйн яаманд ажиглагдаад байгаа шүү. Та нар. Дахиж давтагдвал арга хэмжээ авах саналд оруулна. Одоо найруулгын санал.

1.Төслийн 56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсгийн “Албанд” гэсний өмнө “Шинжилгээний” гэж нэмж 55 дугаар зүйлд шилжүүлэх, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсгийн “хуулийн” гэсний дараа “14.7”

гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Манай Адьшаа гишүүн овоо саналаа өгөөд идэвхтэй оролцож байсан. Энэ Батсуурь гишүүн бас хаачив? Овоо саналаа өгөөд, дэмжээд яваад байсан чинь. Заавал 1 гишүүн ядаж сууж байх ёстой шүү танай бүлгээс.

58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 11 дүгээр зүйлийн “11.10” гэсэн дугаарыг “11.7” гэж, 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “хийж” гэснийг “хийлгэх” гэж, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “хувьд” гэснийг “хийхэд” гэж, 38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсгийн “материалын хувьд” гэснийг “материал нь” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “**4.3 дугаар**” гэснийг “**24.3 дугаар**” гэж, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийн “дарга нартай” гэснийг “даргатай” гэж, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийн “зүйн” гэснийг “зүй” гэж, “дарга нарт” гэснийг “даргад” гэж, 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсгийн “хэрэглүүлэх” гэснийг “хэрэглэх” гэж, 71 дүгээр зүйлийн 71.11 дэх хэсгийн “71.9-д” гэснийг “71.10-т” гэж, 71.12 дахь хэсгийн “хоёр” гэснийг “гурван” гэж, 73 дугаар зүйлийн 73.2 дахь хэсгийн “багийг нууцалж” гэснийг “багийн” гэж, 74 дүгээр зүйлийн 74.4 дэх хэсгийн “асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “болон” гэж, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсгийн “2022 оны 10 дугаар сарын 01-ний” гэснийг “2024 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж, 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсгийн “2022” гэснийг “2023” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 58.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 4.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан” гэснийг, 4.1.2 дахь заалтын “зэрэг” гэснийг, 10

дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “энэ тухай” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.4.4 дэх заалтын “бусад” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “энэ” гэснийг, Тавдугаар бүлгийн гарчгийн “төрлийн” гэснийг, 34 дүгээр зүйлийн Тайлбарын “мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг, 55 дугаар зүйлийн 55.1.8 дахь заалтын “бүх” гэснийг, 74 дүгээр зүйлийн 74.4 дэх хэсгийн “хөдөлмөрийн” гэсний дараах “болон” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Үнэнбат дарга, Энхбат хоёр энэ хуулийн эцсийн найруулга дээр саяын энэ нэр томьёо, хэл найруулга, дэс дарааллыг сайн хянаж үзээрэй за юу. Уншилтыг сайн хийгээрэй.

2.Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт одоо явуулья.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хүүхдийн сэтгэцэд учирсан”, “хүний сэтгэцэд учирсан”, “гэр бүлийн гишүүний сэтгэцэд учирсан” гэсний дараах “хор уршгийг” гэснийг “гэм хорыг” гэж, “тогтоож болно” гэснийг “тогтооно” гэж, “508.5, 508.6-д” гэснийг “508.5-д” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “, 508.6” гэснийг, “508.6.Энэ хуулийн 508.5-д заасан гэм хорыг арилгахдаа энэ хуулийн 508.4-г заасан журмыг баримтална.”

гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Байнгын хороо дэмжсэн саналууд 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ дээр тараасан материалд Байнгын хороо дэмжсэн санал гэдгийг яагаад бичээгүй юм айн?

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулья.

1.Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийн “Эрүүгийн хэрэг” гэсний дараах “шүүхэд” гэснийг хасаж, 2 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн “даалгана” гэснийг “хуваарилна” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 1 дэх заалтын “12.Шүүх шинжилгээний ерөнхий газар” гэснийг “13.Шүүх шинжилгээний ерөнхий газар” гэж, 2 дахь заалтын “12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24” гэснийг “13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26” гэж, мөн заалтын “13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25” гэснийг “14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27” гэж, 3 дахь заалтын “газрыг” гэснийг “ерөнхий газрын” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ерөнхий газар болгоод л өргөн барьсан юм. Одоо ингээд.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “5.1.50, 5.1.51 дэх” гэснийг “5.1.55, 5.1.56 дахь” гэж өөрчилж, мөн хэсгийн “төрлийн” гэснийг, 3 дахь хэсгийн “төрлийн” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар санал хурааж дууслаа.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд орно.

17.09 цаг

Арган гурав. “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс

нэвтрүүлэх, чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох зорилгоор Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын 31 дүгээр тогтоолыг баталсан.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Хилийн боомтын асуудлаарх Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаг өөрийнх нь хүсэлтийн дагуу чөлөөлж, тус хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяаг оруулахаар ирүүлсэн санал Авлигатай тэмцэх газраас Улсын Их Хуралд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн албан бичгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцлээ.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасныг баримтлан Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Байнгын хорооны гишүүд санал гаргаагүй бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын

хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Батгөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа. Батгөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Энэ хил, гаалийг тойрсон Түр хороо Ганболд гишүүнээр ахлуулж байгуулсан. Энэ хүрээнд сүүлийн үед бол дандаа нүүрсний хулгай, мафи их ярьж байгаа. Тэгээд манай Адьшаа яагаад гараад явчхав гэсэн асуулт байна.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа. Энэ чинь юу билээ? Дэгээрээ Байнга хороо хариулна л даа. Эдийн засгийн байнгын хороо. Эдийн засгийн байнгын хорооны дарга.

Ц.Цэрэнпунцаг: Эндээс Авлигатай тэмцэх газраас бичиг ирсэн юм. Энэ ашиг сонирхлын зөрчил үүсэх ийм нөхцөл байдал үүсэж магадгүй гэсэн учраас Адьшаа гишүүн эндээс гарч оронд нь Одонтуяа гишүүн орж байгаа юм байгаа юм. Тэх. Энэ Ардчилсан намын бүлгээс ирүүлсэн саналын дагуу бид нар энэ гишүүнийг сольж байгаа юм.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн үг хэлнэ. Ширнэнбаньдын Адьшаа гишүүнээр тасаллаа. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн. Та битгий дараа бай. Цаанаас асахаар та урдаас нь дарж унтраах юм.

Ш.Адьяшаа: Энэ Хянан шалгах түр хороог би анх санаачилж, Улсын Их Хурлын 26 гишүүнээр.../үг тасрав./

Г.Занданшатар: Битгий хүр л дээ.

Ш.Адьяшаа:...Энэ Хянан шалгах түр хороог би санаачилж, 26 гишүүнээр гарын үсэг зуруулж энэ түр хороог байгуулсан. Тэгээд энэ Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлд урьд ажиллаж байсан байгууллагатай холбоотой асуудлыг шалгах бол энэ хуулиар энд оролцож болохгүй гэсэн ийм хуулийн зохицуулалт байгаа. Энэний дагуу би өөрөө өргөдөл өгч гарсан юм. Тэрнээс биш энэ Энхбаяр гишүүний яриад байгаа шиг тийм юм байхгүй шүү. Энэ дээр олон, их булхай, луйвар, олон асуудал байгаа шүү. Би бүгдийг нь мэдэж байгаа. Энийг би хэдийгээр Түр хорооноос энэ Хяналт шалгалтын тухай хуулийн дагуу гарсан ч гэсэн энэ цуглуулсан бүх нотлох баримтыг олон түмэнд би та нарын нэгэн адил дэлгэж тавина. Энэ хулгай, луйвартай, энэ нүүрсний мафи гэдэг бол байгаа нь үнэн. Тэрэнтэй бол бид бүгдээрээ нийлж энийг засаж залруулахын төлөө хууль дээдлэх зарчим, энэ төрийн өмчийн хулгай луйвар хийдэг энэ асуудалтай тэмцэх ёстой гэдэг дээр санал нэг байгаа.

Тэрнээс биш би тэнд ашиг сонирхлын зөрчилтэй ч юм уу, ямар нэгэн байдлаар энэнээс гарч байгаа юм байхгүй. Энийг би санаачилж байгуулсан хүн би өөрөө. Энийг бол бүр хариуцлагатай хэлье.

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Тэгэхээр энэ Түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах саналыг дэмжиж байна. Адьяшаа гишүүнээ чимээгүй бай, дэмжиж байна. Би нэг зүйлийг хэлье гэж бодоод байгаа юм. Манай Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хуралд санал гаргаад энэ Хяналт шалгалтын тухай хуулийн дагуу санал гаргаад энэний дагуу Улсын Их Хурал энэ хил боомтын асуудлыг хянаж шалгах, ялангуяа тэр одоо яригдаад байгаа энэ нүүрсний хулгайтай эд нар тэмцэхтэй холбоотой асуудлыг судалж,

хянаж тогтоох энэ зорилгоор бол Хянан шалгах түр хороо байгуулсан.

Ер нь Улсын Их Хурлаас барьж байгаа бодлого, чиглэл бол хэрэв нүүрсний хулгай байдаг бол энэтэй хатуу тэмцэх ёстой гэдэг ийм байр суурьтай л байгаа. Бид ч тэгж харж байгаа.

Гэхдээ Хянан шалгах хорооны бүрэлдэхүүнд орж байгаа гишүүдэд нэг зүйлийг бид нар хариуцлагатай хэлэх ёстой гэж бодож байгаа юм. Энэ хороог бол бид нар хил боомтын асуудлаар ажиллаад, хянаад, шалгаад, баталгаатай нотолгоотой болгоод ингээд Их Хуралд танилцуулах ёстой.

Гэтэл баталгаатай, нотолгоотой болоогүй байхад зарим нэгэн гишүүд нь дундаас нь улс төр хийх зорилгоор иргэдийг төөрөлдүүлж янз бүрийн мэдээлэл гаргаад байгаа юм.

Тийм учраас би энэ Хянан шалгах түр хорооны гишүүдийг хариуцлагатай бариач гэж хэлэх гэж байгаа юм. Хороогоороо хэлэлцээд, шаардлагатай гэвэл Их Хурлаар хэлэлцээд яг тогтоочихсон юмаа ярихгүй, ерөнхий зүгээр ийм таамаг хэлбэрээр юм ярьж иргэдийг төөрөлдүүлээд байгаа юм. Одоо юу гэнэ 300, 400 сая тонн нүүрс алга болчихсон юм шиг. Гэтэл бид чинь жилд 30 саяыг ч гаргаж чадахгүй байгаа шүү дээ. Тэгээд буруу мэдээллээр иргэдийг хангаад байгаа юм.

Тийм учраас би юу гэж хэлж байна вэ гэхээр цаашдаа энэ Түр хороод мэдээллээ эцэслэн тогтоогдоогүй байхад дундаас нь улс төр хийх зорилгоор янз бүрийн мэдээллийг зарим нэгэн хүмүүсийн нэр хүндэд ч хүртэл халдаж, ингэж хийдгээ бол болих хэрэгтэй байгаа юм.

Харин энэ мэдээллүүдийг нэгтгээд, судлаад, хянаад шалгаад, тогтоогоод яг

баталгаатай мэдээллээ Түр хорооныхоо нэрийн өмнөөс, эсвэл Улсын Их Хурал дээр, эсвэл хэвлэлд хандаж мэдээлэл өгчихмөөр байгаа юм.

Тийм учраас би Түр хорооны хүмүүст бол энэ чиглэлээр хариуцлагатай ажиллахгүй бол бид нар иргэдээ төөрөгдүүлээд байна гэдгийг л хэлье гэж бодож байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар “Хяналт шалгалтын түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Батлут гишүүнээ санал хураалт.

62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолыг уншиж танилцуулъя.

Ер нь зөвхөн нүүрсний төдийгүй бүх төрлийн энэ төсвийн хулгай, ашигт малтмалын хулгайтай тэмцэх ёстой. Нотлох баримт, үнэн, бодит мэдээлэлд тулгуурлаж ярих ёстой. Худал, бодитой бус мэдээлж иргэдийг төөрөгдүүлж болохгүй. Энийгээ Түр хороо анхаарч ажиллана биз. Нээлттэй, ил тод, үнэн зөв, зөв, шударга ажиллах хэрэгтэй шүү.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1. 6 дахь заалт Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2. 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор байгуулсан Хилийн

боомтын асуудлаарх Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшааг өөрийнх нь хүсэлтийг нь үндэслэн чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор байгуулсан Хилийн боомтын асуудлаарх Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяаг нэмсүгэй.

Энэ тогтоолыг 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Тийм, энэ ерөөсөө тогтоолд өөрчлөлт оруулах гээд л 2 заалттай. 2-лаа ороод явчхаж байгаа юм. Хассугай, нэмсүгэй. Дараагийн асуудалд орно.

17.21 цаг

Арван дөрөв.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг танилцуулах болон ажлын хэсгийн гишүүдийг танхимд орж байна. Стандартчилал, хэмжил зүй. Зөвшөөрөл дотор нь байгаа, дагаж байгаа. Зөвшөөрлийн хууль чинь батлагдчихсан шүү дээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн

Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт нарын 20 гишүүн 2019 онд Зөвшөөрлийн тухай хуулийг Их Хуралд өргөн барьсан. Монгол Улсын Их Хурал 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хууль 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

Зөвшөөрлийн тухай хуулийг баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 35 дугаар тогтоолоор зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүргийг Засгийн газарт даалгасан.

Иймд зөвшөөрөл олгох харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн зөрчил, давхардал, хийдлийг арилгах хүрээнд Зөвшөөрлийн тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нийт 89 хуулийн төсөл, 1 Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг боловсруулахад холбогдох яам болон төрийн захиргааны байгууллага, түүнчлэн зөвшөөрөл олгох бусад эрх бүхий этгээд буюу Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо гэх мэт Засгийн газрын бус байгууллагын оролцоог хангаж, Засаг дарга, орон

нутгийн болон холбогдох нийтийн эрх зүйн хуулийн этгээд, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллалаа.

Хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хүрээнд хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтуудыг тусгасан.

1.Зөвшөөрлийн тухай хуульд зөвшөөрөл олгох, сунгах болон цуцлах шийдвэрээс гадна ажиллагааны үе шат, явцын талаарх мэдээллийг ил тод, нээлттэй түгээх, иргэдэд мэдээллийг цахим хэлбэрээр нэг цэгээс авах боломжийг бүрдүүлэх талаар эрх бүхий этгээдийн өрийг тодруулсан нэмэлт зохицуулалтыг тусгасан.

Түүнчлэн хуульд заасан зөвшөөрлийн жагсаалтаас 2 тусгай зөвшөөрөл, 3 энгийн зөвшөөрлийг хасаж, 2 тусгай зөвшөөрлийг энгийн зөвшөөрлийн ангилалд шилжүүлэн өөрчиллөө.

Цахим шилжилтийн эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх болон радио давтамжийг нийтийн үйлчилгээний бус зориулалтаар ашиглах үйл ажиллагаа, мөн байгаль орчны болон эрүүл мэндийн чиглэлд хамаарах эрсдэл бүхий тодорхой үйл ажиллагааг зөвшөөрөлтэй болгох шаардлагыг харгалзан 4 тусгай зөвшөөрөл, 3 энгийн зөвшөөрлийг хуульд нэмж тусгахаар саналыг боловсруулсан.

2.Зөвшөөрлийн зорилго, эрсдэлийн түвшин зэргийг харгалзан тавигдах нөхцөл, шаардлагыг стандартчилж, заавал мөрдүүлэх нөхцөлийг хангах зорилгоор Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Энэхүү өөрчлөлтийн дагуу Зөвшөөрлийн тухай хуульд заасан 108

тусгай зөвшөөрөл, 7 төрлийн энгийн зөвшөөрөлтэй холбоотой стандартыг тусгайлан баталж, зөвшөөрөл эзэмшигч түүнийг заавал дагаж мөрдөх үүрэгтэй байхаар хуульд нэмэлт, өөрчлөлтийг тусгасан.

3.Зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлсөн байхыг шаарддаг, зөвшөөрөл олгоогүй тохиолдолд хураамжийг буцаан олгодоггүй зэрэг хийдэлтэй байдлыг өөрчилж, холбогдох зохицуулалтыг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд тусгалаа.

4.Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль, тогтоомжийг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлж, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын итгэмжлэлийн тухай, Хэмжил зүйн тухай болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс гадна салбарын 85 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан.

Энэхүү өөрчлөлтийн хүрээнд салбарын хуульд заасан зөвшөөрлийн төрөл, ангиллыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэхээс гадна зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нөхцөл, шаардлагыг үйл ажиллагааны онцлог нэрийн дор хэт ерөнхий, эсвэл оновчгүй байдлаар тогтоосныг залруулахад анхаарсан.

Мөн зөвшөөрөл олгох харилцаанд мөрдөх журмыг зөвхөн хуулиар тогтоох зарчимд нийцүүлэн зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журмыг тухайлсан хууль бүрд тодруулан тусгасан болно.

Хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцсэн байгаа.

Хууль санаачлагч нь тухайлсан хуульд заасан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуулийн зарчим, нийтлэг зохицуулалтад нийцүүлэх, төрийн бүтээмж, цахим шилжилтийн бодлого болон тухайн салбарын шинэчлэл, онцлогийг харгалзан шинэчлэх чиглэлээр холбогдох хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу нэгдсэн журмаар хэрэгжүүлэх зорилгоор хууль, тогтоолын төслүүдийг боловсруулжээ.

Эдгээр хууль, тогтоолын төслүүд батлагдсанаар “Шинэ сэргэлтийн

бодлого”-ын хүрээнд дэвшүүлсэн төрийн хяналт шалгалтын давхардсан тогтолцоог цэгцлэх, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулах зорилтыг хэрэгжүүлэх нөхцөл хангагдах ач холбогдолтой гэж төсөл санаачлагч нь үзэж байна.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, энэ чинь бүгдээрээг нь унших юм уу дарга?

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Музейн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай, Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай өргөн, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хадгаламж зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад

худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах, татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, эдгээр хуулиуд нь дандаа тусгай зөвшөөрөл шаарддаг хуулиуд байгаа төслүүд. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Ёстой лонх тоолж байгаа юм шиг юм боллоо.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Адьшаа гишүүнээр тасаллаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сандагийн Бямбацогт Зам, тээврийн хөгжлийн сайд, Бямбажавын Ганбат. Ганбат дарга хаачихсан юм? Засгийн газрын хэрэг эрлэх газрын Тэргүүн дэд дарга, Болдбаатарын Билгүүн Стандарт хэмжил зүйн газрын дарга, Нэргүйн Мягмар Засгийн газрын Хэрэг эрлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Батмөнхийн Насантогтох Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга. Байхгүй юу? Дунхүүгийн Аюуш Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал. Энэ хууль санаачлагч сайд, энэ ажлын хэсгийн гишүүд байхгүй учраас Стандарт хэмжил зүйн хуулийг хойшлууллаа. Маргааш өглөө хэлэлцэнэ. Ажлын хэсэг бүрэлдэхүүнээ бүгдийг нь бүрэн авчирч байж хэлэлцэнэ.

Аубакир, Адьшаа гишүүн 2-оор асуулт, хариулт тасалсан. Маргаашийн үүгээр үргэлжилнэ. Дараагийн асуудалд орно. Дараагийн 3 хууль. Холбогдох хууль санаачлагчид, оролцогчид байвал үргэлжлүүлэхэд бэлэн байна. Явчихвал сайн байна. Тэгэхээр аялал жуулчлалын хуулийг бол 11 цагаас хойш хэлэлцье гэсэн. Тэгэхээр энэ стандартчилал хэмжил зүй 11 хүртэл явчихна. Энэ хоёрхон асуудалтай юм чинь. Газрын тосны санал хураалт явчихна. Ингээд л энэ хоёр таарч байна. Тэгвэл, хөөе хэн 2 явж байгаа юу гэнээ? Тилеуханы Аубакир гишүүн суудлаа суугаарай. Та сүүлийн үед ер нь хурал, чуулган таслаад, хүн амьтан уриалаад одоо явж байя гэх шиг ажлын цаг тараагүй байхад яагаад байна та? Суу. Ингээд дараагийн асуудалд орно.

17.35 цаг

Арван тав.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн асуудлыг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Аялал жуулчлалын тухай хууль хууль санаачлагчид байхгүй учраас маргааш хүртэл хойшлууллаа. Ингээд энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Лхагвын Мөнхбаатар Хууль зүйн байнгын хорооны даргыг дуудаж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын санхүүгийн зах зээлийг эрүүлжүүлэх, санхүүгийн зах зээлд өрсөлдөөнийг бий болгох, улмаар иргэд болон аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн санхүүгийн ачаалал, зардлыг бууруулах, санхүүгийн хүндрэл бэрхшээлийг хөнгөвчлөх зорилгоор санхүүгийн зах зээлд даатгалын баталгааг шинээр нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн дагуу аливаа санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдах барьцаа баталгаа, урьдчилгаа төлбөр, батлан даалтыг зөвхөн

банкны баталгаа, бонд, үнэт цаас хэлбэрээр хэрэгжүүлэхээр зохицуулсан байгаа нь санхүүгийн зах зээлд бусад төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэвтрүүлэх боломжгүй байдлыг үүсгэж байна.

Тухайлбал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар аливаа тендерт оролцогч нь тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг зөвхөн дан ганц банкны баталгаа байдлаар ирүүлэхээр тусгасан байгаа нь учир дутагдалтай юм.

Улмаар энэхүү хуулийн хязгаарлагдмал зохицуулалтын дагуу аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшлийнхэн ажил, үйлчилгээгээ 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг арилжааны банкнуудад дунджаар 2-3 жилийн хугацаанд хүүгүйгээр царцааж байршуулах, өөрийн гэх бүх өмч, хөрөнгөө банкны барьцаанд тавих зэрэг олон хүндрэлтэй асуудлыг үүсгэж байна.

Мөн өнөөдөр ипотекийн зээлд хамрагдах хүсэлтэй, урьдчилгаа төлбөр дутаж буй иргэдэд ч гэсэн зөвхөн банкны шаардлага болох 30 хувийн урьдчилгаа төлбөрийг бүрдүүлэхээс өөр санхүүгийн арга хэрэгсэл, хямд эх үүсвэр байхгүй байгаа нь байртай болох гэсэн айл өрх бүр санхүүгийн дарамт, ачаалал болж байгаа нь өнөөгийн санхүүгийн зах зээл дэх нийтлэг практик болж байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Ингэснээр банкнаас шаардах аливаа барьцаа, баталгаа, батлан даалт, урьдчилгаа төлбөрийн шаардлагыг орлох, санхүүгийн үйлчилгээ, шинэ бүтээгдэхүүнийг бий болгох, даатгалын баталгааг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх боломжтой болох юм.

Өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгж байгууллагууд хувийн хэвшлийнхэн хөрөнгө мөнгөө банканд 2-3 жилийн хугацаанд хүүгүй царцааж байршуулахгүй хямд эх үүсвэрээр барьцаа, баталгааны асуудлыг шийдвэрлэх, иргэд банкнаас шаардах байрны урьдчилгаа төлбөрийг даатгалын баталгаагаар буюу илүү хямд эх үүсвэрээр бүрдүүлэх боломж нөхцөл бүрдэх юм.

Мөн санхүүгийн бодлогын хүрээнд Монголын санхүүгийн зах зээл илүү эрүүлжиж, төрөлжих, банкнаас бусад санхүүгийн салбарыг дэмжих, санхүүгийн зах зээлд санхүүгийн шинэ үйлчилгээг бий болгох, хувийн хэвшлийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх, улмаар иргэдэд ирэх санхүүгийн ачаалал, зардал буурах боломжтой болно гэж хууль санаачлагчдын зүгээс үзэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал танилцуулна. Индэрт урьж байна таныг.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 3 гишүүн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд баталгаа, батлан даалтын аливаа этгээд үүрэг гүйцэтгэгчийн өмнө гаргах эрхтэй боловч төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээний үүргийн гүйцэтгэлд зөвхөн банкны баталгааг хүлээн зөвшөөрч байгаа нь даатгалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн зах зээлд даатгагчийн баталгаа гаргах боломжийг хязгаарласан сөрөг үр дагавар үүсэж байгааг өөрчлөх хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан даатгалын баталгааны санхүүжилтийн эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлэх талаар, мөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал даатгалын эрхлэгч байгууллагууд өөрийн хөрөнгийн хэдэн хувьд даатгалын баталгаа гаргах боломжтой эсэх, мөн даатгалын компанийг эрсдэлээс хамгаалахын тулд холбогдох байгууллагуудын мэдээллийн эх сурвалж, мэдээллийн харилцан солилцох боломжийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин төрийн болон орон нутгийн тендерт оролцогч компаниудад даатгалын сонголт бий болж байгаа нь сайшаалтай боловч томоохон хэмжээний тендерийн эрсдэлийг даатгалын компани дангаараа авч явах чадвар хараахан бүрдээгүй байгааг анхаарах, мөн даатгалын компаниуд шимтгэл хөөж томоохон тендерт оролцож байгаа даатгалын төлбөр төлөх тохиолдолд гэрээний дагуу нөхөн төлбөрийг төлж чадахгүй нөхцөлд хүрэх вий гэсэн болгоомжлол байгаа учраас тодорхой хэмжээний хязгаар тогтоох нь зүйтэй гэж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Даатгалын хуулийн төсөлд даатгалын байгууллагуудын баталгааны эх үүсвэрийг тодорхой болгож, цаашид томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд эрсдэл үүссэн тохиолдолд авах хариуцлагын тогтолцоог тодорхой болгох, мөн банк, даатгалын байгууллагуудын мэдээллийн системийг боловсронгуй болгох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал,

дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд бүртгүүлнэ үү. Цэндийн Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяа: Энэ хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Бас зөв, зүйтэй, өнөөдөр энэ бараа үйлчилгээ, төрийн болон орон нутгийн өмчийн бараа үйлчилгээг худалдан авахтай холбоотой олон бэрхшээлүүдийн нэг нь энэ банканд барьцаа байршуулах тухай асуудал байдаг. Энийг шийдвэрлэх ийм гарцыг эрэлхийлсэн зөв, зүйтэй хууль болсон гэдэг дээр би санал нэг байгаа. Энэ дээр энэ даатгал, банкны үйл ажиллагаа хоёрын ялгаа юу байх вэ? Энэ бизнес эрхлэгчдэд ямар үр дүнтэй, банкны үйлчилгээнээс давуу тал нь ямар байна гэдэг талаар нэг асуулт асууя.

Дээр нь энэ төрийн болон орон нутгийн өмчөөр бараа үйлчилгээ авах, энэ тендерийн үйл ажиллагаанд бас шийдэх ёстой асуудал байгаа. Өнөөдөр тендерт оролцож байна гээд 2, 3 компани бэлдчихээд тэрүүгээрээ тендерт ороод нөгөө ялсан компанийн ямар нэгэн тийм жижиг булхай, алдаа олж авчхаад тэрүүгээрээ шантайчилдаг, тэрүүгээрээ тэнд тэнтэй аливаа тэр тендерийг наймаалцахыг оролддог, тэр улсын төсвийн болон орон нутгийн бараа үйлчилгээний тендерийн үйл ажиллагааг чирэгдүүлдэг, цаг алдуулдаг, шүүх болон Сангийн яам заргалдаж олон бэрхшээл учруулж энэ төсвийн хөрөнгөөр хийгдэх ёстой ажлыг хойшлуулдаг ийм гацаа өнөөдөр түгээмэл байна. Энийг одоо энэ хуулийн төсөл дээр оруулж

шийдвэрлүүлэх тийм боломж байна уу?
Энэ талаар хариулт авъя,

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн, хууль санаачлагч хариулья.

Г.Тэмүүлэн: Адьшаа гишүүний асуултад хариулья. Тэгэхээр өнөөдөр үндсэндээ бид нар бас энэ Монголын санхүүгийн зах зээлд нэг талдаа бас нэг том энэ реформ, шинэчлэлийн асуудлыг энэ хуулийн хүрээнд хөндөж тавих зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа. Үндсэндээ Монголын санхүүгийн зах зээлийн 83 хувийг банкны салбар дангаар эзэлж байгаа. Эргээд 11 хувийг нь хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл бол дөнгөж 2-хон хувийг эзэлдэг. Эргээд олон улсын нийтлэг түвшиндээ аваад үзэх юм бол ер нь энэ санхүүгийн зах зээлийн 50, 50 хувийг авч явдаг 2 салбар бол даатгал болоод энэ банкны салбар байдаг.

Тэгэхээр бид нар үндсэндээ нэг талдаа энэ монополчилсон байдлаар нэг салбар нь илүү энэ санхүүгийн зах зээлийг авч явж байгаа учраас иргэдэд ирж байгаа энэ бараа, бүтээгдэхүүн болоод санхүүгийн үйлчилгээний үнэ, өртөг, зардал, ачаалал бол их өндөр байгаад байгаа юм.

Тэгэхээр үүний бодит нэг асуудал бол яг таны бас ярьж байгаа аж ахуйн нэгж болоод хувийн хэвшлийнхний аливаа тендерт оролцсон бол зээлийн баталгаа, барьцаа хөрөнгө нь хангалтгүй ч гэдэг юм уу, энэ нийтлэг бэрхшээл бол манай хувийн хэвшлийнхэнд байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс, энэ банкнаас бусад энэ санхүүгийн зах зээлийг дэмжих үүднээс энэ баялаг бүтээгчдийг болоод бизнес эрхлэгчдийг дэмжих үүднээс энэ хуулийн төслийг бас оруулж ирж байгаа.

Бүр том зургаар авч үзэх юм бол ер нь цаашдаа бид нар энэ гаднаас томоохон хөрөнгө оруулалтыг татах, экспортыг дэмжих, давхар даатгалын тогтолцоог бий болгох, энэ санхүүгийн зах зээлд эрүүл, зөв тогтолцоог бий болгох энэ боломж бололцоо бол бүрдэнэ гэж бас харж байгаа.

Саяын зөвхөн тендертэй холбогдуулаад аваад үзэхэд бол ер нь бол зүгээр энэ ажил гүйцэтгэгч компаниуд ажил үйлчилгээнийхээ 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг болоод мөнгөн хөрөнгийг доод тал нь 2-3 жилийн хугацаанд банканд байршуулж, царцааж байгаа. Үүн дээрээсээ хамгийн гол асуудал бол ерөөсөө хүүгүйгээр бас царцааж байгаа тэнд.

Тэгэхээр энэ бол өөр өөрсдийнхөө өмч хөрөнгийг, өөрөө өөрсдийнхөө баялгийг магадгүй үйл ажиллагаандаа зарцуулж байх байсан тэр мөнгөн хөрөнгийг энэ хүүгүйгээр байршуулж байгаа асуудал бол нэг талдаа энэ эрүүл бус тогтолцоо манайд тогтсон байгаагийн бодит илэрхийлэл байна гэж харж байгаа.

Энийг одоо бол даатгалын маань бол давуу тал маань юу болох вэ гэхээр ер нь аж ахуйн нэгжүүдэд илүү хямд, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээ, шинэ сонголт бол даатгалын баталгааны хүрээнд бий болно гэж харж байгаа.

Олон улсынхаа нийтлэг жишгээр бол одоогийн энэ магадгүй жишээ болгож хэлэхэд тухайн тэр ажил үйлчилгээнийхээ 5 хувьтай тэнцэх гээд 250 сая төгрөг, банканд 2-3 жилийн хугацаанд байршуулах байсан бол түүнээс 20-40 дахин хямд эх үүсвэрийг энэ даатгалын байгууллагууд санал болгох боломжтой гэсэн тооцооллыг өгч байгаа.

Тэгэхээр магадгүй 250 сая төгрөгөө та хүүгүйгээр 2-3 жил банканд байршуулах

уу? Эсвэл магадгүй 5-10 сая төгрөгийн хураамжийг та даатгалын баталгааны хураамжийг төлөөд эргээгээд нөгөө хэмнэсэн гэдэг юм уу, банканд царцаахгүй байсан хөрөнгөө бол үйл ажиллагаандаа зарцуулах боломж, бололцоо бүрдэнэ гэж байгаа юм.

Энэ бол зөвхөн энэ бид нар энэ барьцаа, баталгаанаас гадна нэг талдаа бол энэ бас их зөв, эрүүл орчин нөхцөл бүрдэнэ гэж л харж байгаа юм. Энэ өөрөө юу вэ гэхээр тухайн энэ даатгалын тогтолцоог, даатгалын баталгааг бид нар нэвтрүүлснээрээ барилга, ажил үйлчилгээний хяналт бол сайжирна гэж харж байгаа юм.

Өнөөдөр төрөөс явуулж байгаа, барьж байгаа ч гэдэг юм уу тухайн тэр зарлагдсан тендер, барилгын чанарт, ажил үйлчилгээнд нь, цаг хугацаанд нь, чанартай гүйцэтгэж байгаа эсэхэд хангалттай бид нар хяналтыг бас тавьж чадахгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар хувийн хэвшлийн оролцоотойгоор даатгалын байгууллагууд тухайн явцад нь үйл ажиллагаа дээр нь хяналт тавиад байх, өөрсдөө бас энэ юу гэдэг юм хяналт, мэдээллийн системийг бүрдүүлэх энэ боломж бололцоо бол бүрдэнэ.

Тэгэхээр ерөөсөө цаашдаа энэ чанаргүй ажил гүйцэтгэгч гэдэг юм уу, цүнх баригч энэ компаниуд байхгүй болох боломж бололцоо бол бүрдлээ гэж харж байгаа юм.

Үүнээс гадна мэдээж энэ бас зөвхөн зүгээр энэ банкны барьцаа, баталгаанаас гадна ер нь зүгээр энэ батлан даалттай холбоотой иргэдийн энэ орон сууц авахтай холбоотой, түүнд шаардагддаг урьдчилгаа төлбөрийн асуудлыг ч гэсэн бид нар даатгалын

баталгаагаар шийдвэрлэх боломжтой гэж харж байгаа юм.

Г.Занданшатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууна.

Б.Энх-Амгалан: Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бол зарчмын хувьд дэмжиж байна.

Гэхдээ 3 зүйл асууя. Энэ барьцаа хөрөнгө байршуулах асуудлыг л даатгалаар шийдэж байна, 5 хувийнхаа хөрөнгийг ингээд аж ахуйн нэгжүүд нэлээн удаан хугацаанд царцаагаад байна, хүүгүйгээр банканд байршуулаад байна гэдэг ийм л асуудал яригдаж байгаа юм л даа.

Нөгөө талаасаа ажлаа хийдэггүй, урьдчилгаагаа авчхаад хаяад алга болчихдог ийм хариуцлагагүй компаниудыг яах вэ? Нэг талдаа яах вэ, аж ахуй эрхлэгчдээ дэмжиж байгаа юм байна шүү дээ. Нөгөө талаараа хариуцлагагүй тэр ажил үйлчилгээнд оролцдог нөхдүүдийг яах вэ? Тийм зөндөө жишээ байгаа юм.

Хоёрдугаарт нь жил бүр нөгөө барьж байгаа объектынхоо төслийн өртгийг нэмэгдүүлээд яваад байдаг. Долларын ханш нэмэгдсэн, юмны үнэ нэмэгдсэн, бараа ажил үйлчилгээ нэмэгдсэн гээд л өртгөө өсгөөд л. Тэгээд баригдаж дуусдаггүй, тэгээд л 2, 3 жил болдог. Тэгээд л нөгөөх нь ийм араг яс босчихоод л байгаад байдаг. Байгаад байдаг. Анхны өртгөөсөө 3, 4 дахин өссөн ийм барилга, объектууд ч байгаа шүү дээ. Ингээд бүр бөөлчихсөн ийм системтэй ажиллаад байдаг. Тэгээд л нөгөө төсөл өртөгт өөрчлөлт орсон шүү гээд л үнээ нэмээд байдаг. Ийм хариуцлагагүй нөхдүүд дээр ямар хариуцлага тооцох вэ?

Тэгээд өмнө нь өч өчнөөн тендер аваад, тэгээд баахан чанаргүй барилга, чанаргүй зам, чанаргүй ажил, үйлчилгээ явуулчихсан. Тэр нь ардаа маш их хэрүүл дагуулдаг. Одоо усных нь хаялгыг дутуу хийчихсэн ийм объект Говь-Алтай аймгийн Баян-Уул суманд байна. Нөгөөх нь бороо орохоор бүх ус нь хана руугаа ороод ирдэг. Нөгөө барьсан тоосго нь уусдаг, урсдаг. Дулаалга, халаалт муутай, дээвэр муутай, цонх муутай, хаалга муутай юм барьчихсан. Нөгөө дулаан алдалтаас нь болоод өвөл нөгөө дөнгөж ашиглалтад ороод удаагүй байгаа барилга нь өвөл ингээд ашиглахад хэцүү байдаг. Ийм нөхдүүд байгаа юм. Ийм чанаргүй юм хийдэг. Ийм улсуудтай ер нь ямар хариуцлага тооцох вэ? Одоо ингээд л шүүхдээд л яваад байх уу? Яах вэ? Ийм юмыг хоёр талд нь бас давхар хармаар байгаа юм л даа. Энэ талаар нэг мэдээллүүд өгөөдхөөч.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн, хууль санаачлагч асуултад хариулна.

Г.Тэмүүлэн: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр яг үндсэндээ энэ даатгалын тогтолцоо, даатгалын баталгааг одоо санхүүгийн зах зээлд нэвтрүүлснээрээ ерөөсөө гол бас нэг үндсэн зорьж байгаа зорилго бол энэ барилга, үйлчилгээний хяналтыг сайжруулахад оршиж байгаа юм. Энх-Амгалан гишүүнээ, Тэгэхээр энэ ерөөсөө энэ барилга, ажил үйлчилгээ яг цаг хугацаандаа чанартай гүйцэтгэхэд хувийн хэвшлийн оролцоотойгоор бид нар үйл ажиллагаа дээр нь, гүйцэтгэл дээр нь хяналт тавих боломж бололцоо бүрдэнэ гэж харж байгаа.

Үндсэндээ өнөөдөр бид нар банкны барьцаа баталгаа гэхээр банк бол үндсэндээ тэрэн дээр ямар нэг тэр ажил нь цаг хугацаандаа хийгдэж байна уу, чанартай хийгдэж байна уу, тэр яг юу гэдэг

юм, төлөвлөсөн хугацаа, графикайнхаа дагуу явж байна уу, үгүй юу гэдэг дээр бол гүйцэтгэлийн хяналт тавьдаг зүйл байхгүй. Тэд нар зөвхөн барьцаа, баталгаанд авч байгаа өмч, хөрөнгө нь гэдэг юм уу, эсвэл тухайн мөнгөн хөрөнгө нь гэдэг юм уу, байршсан уу, байршаагүй юу, тэр нь үнэ, үнэлэмж нь хэд байна гэдэг асуудал дээр л анхаарал хандуулж байгаа болохоос биш тэр хэдэн жилийн хугацаанд царцсан уу, хэзээ дуусгана гэдэг нь бараг тэд нарын 100 дахь асуудал болж байгаа юм.

Тэгэхээр энэ үндсэндээ даатгалын тогтолцоо бол өөрөө өөрсдөө тэр бизнесийн үйл ажиллагааны эрсдэлийг хамгаалж байгаа, өөрөө өөрсөд дээр бас эрсдэл үүсгэж байгаа учраас өөрөө өөрсдөө тэр эрсдэлийн нөөц, дундын санг үүсгэж байгаа учраас өөрөө өөрсдөө гүйцэтгэлийн явц дээрээ хяналт тавих зайлшгүй шаардлагатай болж байгаа юм. Өөрөө өөрсдөө мэдээллийн нэгдсэн платформ, тогтолцоогоо ч бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай болж байгаа.

Тэгэхээр ерөөсөө энэ магадгүй энэ даатгалын баталгаа бүрдсэнээрээ цаашдаа чанаргүй ажил гүйцэтгэх ч гэдэг юм уу, цүнх баригч компаниуд бол ер нь байхгүй л гэж харж байгаа юм. Илүү энэ хяналтын үйл ажиллагааг амьдралд хэрэгжихэд илүү ойрхон болгох, дээрээс нь бид нар төр үүрдэг байсан ачааг төр өөрөө юу гэдэг юм, Сангийн яам ч гэдэг юм уу, Барилгын яам гэдэг юм уу, Барилгын хөгжлийн төвүүд хойноос нь хөөж очиж, хяналт тавих гэдэг асуудлаас илүү эд нар маань сар гэдэг юм уу, хагас жилээр ч гэдэг юм уу өөр өөрсдөө хяналтаа тавиад байх боломж, бололцоо бүрдэнэ гэсэн үг.

Тэгэхээр бид нар хувийн хэвшлийн оролцоотойгоор энэ юу гэдэг юм тухайн тэр тендерийн бараа, ажил үйлчилгээний чанар, гүйцэтгэл дээр нь хяналт тавих боломж, бололцоог бий болгож байгаагаараа бас онцлогтой.

Дээрээс нь энэ бол ерөөсөө нэг талдаа нэг шинэ зүйл биш. Энэ угаасаа л олон улсад нийтлэг байдаг, хэрэглэгддэг практик. Ерөөсөө Монголд магадгүй юу гэдэг юм, олон улсад ер нь жишээ нь томоохон төсөл, хөтөлбөр орж ирлээ гэхэд тэрэн дээр бүтээн байгуулалтын ажлууд байлаа гэхэд, дэд бүтэц байлаа гэхэд тэрэн дээр тавигддаг гол ерөөсөө асуудал бол давхар даатгалын тогтолцоо байдаг.

Тэгэхээр энүүгээрээ бид нар бас энэ олон улсын ч сайн жишиг орж ирж нэвтрэх энэ боломж, бололцоо бүрдэнэ гэж харж байгаа. Бид нар тэгээд тухайн тэр гүйцэтгэгч компаниуд дээр үнэлэх асуудлууд, хэд хэдэн үнэлгээний асуудлууд байна.

Тэгэхээр энэ дээр юу байх вэ гэхээр мэдээж тэр санхүүгийн чадварын асуудлууд байна, дадлага туршлага нь байна, мэргэжлийнх нь онцлог байна. Дээрээс нь салбарынх нь онцлогийг ч гэсэн харгалзаж үзэх энэ шаардлагууд бол тавигдана. Энэ хууль болоод хэрэв нэмэлт, өөрчлөлт батлагдах юм бол Санхүүгийн зохицуулах хорооноос мөрдөгдөж байгаа журмууд дээр өөрчлөлт орно. Монголбанкнаас мөрдөгдөж байгаа журмууд дээр бол өөрчлөлт орно. Ингээд илүү иргэд болоод хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд дээр нэмэлт шинэ санхүүгийн баталгааны нэг хэлбэрийг, үйлчилгээг, бүтээгдэхүүнийг бий болгох боломж, бололцоо бүрдэнэ л гэж харж байгаа.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа Тэмүүлэн гишүүнд. Энэ үндсэндээ даатгалын компаниуд өөрсөд дээрээ эрсдэл хүлээж байна, тийм үү? Өөрсөд дээрээ эрсдэл хүлээж байна. Тэгэхээр тэр даатгалын компаниудыг хэн сонгох юм?

Бараа, ажил үйлчилгээ худалдан авах захиалга өгч байгаа тэр захиалагч өөрөө сонгох юм уу? Энэ худалдан авалтыг, энэ хөрөнгө оруулалтын ажлыг энэ даатгалын компаниар хийлгэнэ гэж ингэх юм уу? Эсвэл тендэрт оролцож байгаа компаниуд өөрсдөө сонгох юм уу? Яаж энийгээ, компаниа сонгох юм бэ гэдгийг нэгд асууя.

Хоёрт, улс, нийслэл, төрийн өмчийн оролцоотой компаниуд нийтдээ 1 жилд хэчнээн хэмжээний мөнгөн дүн ер нь яригддаг юм? Энэ хуулийн хүрээнд. Баталгаа, батлан даалт, тэгээд гүйцэтгэлийн баталгаа тийм ээ? Энэ хэмжээндээ яригдвал ер нь хэдий хэмжээний мөнгөн дүн дээр энд яригдаад, тодорхой хэмжээнд эхнээсээ даатгалын компаниуд руу шилжих бололцоо боломж үүсэх юм бэ гэдгийг тодруулж өгөөч.

Эрсдэлийг даатгалын компанид өөрс дээрээ авч байгаа учраас энэ даатгалын компаниудад ямар нэг шалгуур, шаардлага тавьж байгаа юу? Одоо эхнээсээ манай даатгалын сангийнхан чинь, компаниуд чинь, сангийнхан чинь яаж байгаа билээ? Шимтгэл төлөгч нарыг эхнээс нь хохироогоод явж байгаа асуудлууд бий шүү дээ. Дараа нь нөгөө баталгаа, барьцаа даалт энэ юмнууд нь төлж чадахааргүй боллоо гээд ингээд нөгөө захиалагч гэдэг юм уу, компаниудыг хохироох асуудал үүсвэл хариуцлагыг нь хэн хүлээх юм? Энэ дээр хариулт өгөөч. Баярлалаа.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуултад хариулна.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ерөөсөө одоогийн ер нь энэ даатгалын байгууллагууд, даатгалын салбарынхны энэ даатгалынх нь нөөц сан нь хэд юм бэ гэдэг асуудал нэгдүгээрт эрсдэл хүлээх чадвар нь.

Тэгэхээр одоогоор даатгалын байгууллагуудын нөөц сан бол 208 тэрбум төгрөг байгаад байгаа юм. Тэгэхээр нэмэлтээр эд нар өөрөө өөрсдийнхөө нөөц, бололцон дээр суурилоод 320 тэрбумын санхүүжилтийн нөөц санг бүрдүүлэх боломжтой гэж харж байгаа. Тэгэхээр 508 тэрбум төгрөг гэсэн үг.

Тэгэхээр энэ бол зөвхөн зүгээр дотоодын эх үүсвэр. Үүнээс гадна олон улсын давхар даатгалын тогтолцоонд давхар даатгагдах, олон улсын давхар даатгалын тогтолцоогоор хамгаалагдах боломж бололцоо бол бүрдэнэ гэсэн үг. Тэгэхээр ерөөсөө манайд нэвтрээгүй байгаа бас нэг энэ салбарын асуудал бол ерөөсөө бид нар олон улсын нийтлэг жишгийн дагуу давхар даатгалын тогтолцоонд бас энэ хувийн хэвшлийнхний эрсдэл, бизнесийн үйл ажиллагааны эрх ашгийг нь хамгаалах боломж бололцоо бүрдэнэ гэсэн үг.

Саяын таны асуусан тэр зөвхөн тендерийн барьцаа, баталгаанд гэхэд хэдий хэмжээний мөнгө ер нь банк нь царцаагдаад юм бэ гэдэг асуулт байгаад байгаа юм. Тэгэхээр би нэг жишээг хэлье. Ерөөсөө л жилийн жилд зөвхөн төрөөс зарлаж байгаа тендер дээр шүү. Төрөөс гадна бас олон тендерүүд байна. Төрөөс зөвхөн зарлаж байгаа тендер дээр доод тал нь 500-700 тэрбум төгрөг банканд царцаагдаж байна. Энэ бол хувийн хэвшлийнхний мөнгө. Хувийн хэвшлийнхэн өөрөө өөрийнхөө мөнгийг, мөнгөн хөрөнгийг үйл ажиллагаандаа зарцуулж байх байсан тэр санхүүжилтийг банканд ямар нэг хүүгүйгээр, хамгийн шударга бус нь хүүгүйгээр царцааж байгаа. 5 хувь нь.

Тэгэхээр энэ ерөөсөө, энэ мөнгө буцаж эдийн засагт эргэж орж ирэх боломж бололцоо бүрдэнэ гэсэн үг болчхож байгаа. Тэр дундаа эдийн засаг хүнд байгаа энэ цаг үед бид нарт ийм

хэмжээний зохицуулалтуудыг хийх зайлшгүй шаардлагатай гэж харж байгаа. Сая сүүлийн 5 жилийн хугацаанд шүү. Сүүлийн 5 жилийн хугацаанд төрөөс залагдсан тендерүүдээс 2.3 их наяд төгрөг энэ арилжааны банкнуудад байршсан байгаад байгаа юм. Хүүгүйгээр. Энийг тухайн юу гэдэг юм, банк, банкны байгууллагууд, арилжааны банкнууд өөрсдийн юу гэдэг юм тухайн санхүүгийн эх үүсвэр болгож ашиглаж байгаа юм.

Тэгэхээр ерөөсөө бид нар ингэхгүйгээр энэ 2.3 их наяд төгрөг Монголын эдийн засагт орсон бол манай эдийн засаг өөрөө яаж тэглэх ёстой байсан бэ, тухайн илүү юу гэдэг юм их бүтээн байгуулалтуудыг хийх боломжтой байсан байдаг зүйл. Ер нь цаашдаа манай Монгол Улсын эдийн засаг өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүн нь яагаад жилийн жилд ер нь арванхоёр, гурван тэрбум долларт эргэлддэг юм, 43 их наяд төгрөг байдаг юм гэдгийн бас нэг үндсэн суурь шалтгаан ерөөсөө энэ юм байна лээ.

Тухайн тэр бизнес болоод үйл ажиллагааны эрсдэлийг хамгаалах, тэрийг нь даатгаад аваад явах тогтолцоо өнөөдөр үндсэндээ байхгүй байгаа. Хууль, эрх зүйн орчны хүрээнд. Тэгэхээр одоо даатгалын компаниуд бол ямар ч бай өнөөдөр ердийн даатгалын үйл ажиллагаа явуулдаг 15 байгууллага байна. 15 байгууллага. Эдгээр байгууллагууд бүгдээрээ энэ үйлчилгээг эрхлээд явах боломжтой гэсэн үг. Яг саяын түрүүний асуусан, магадгүй яг даатгалын компанийг хэн сонгох юм бэ гэдэг асуудал байна шүү дээ тээ? Тэгэхээр энийг мэдээж тухайн тэр бизнесийн харилцаанд олж байгаа хувийн хэвшлийнхэн өөрсдөө сонгоно гэсэн үг. Өөрсдөө сонголтоор яваад, тухайн аль хямд эх үүсвэрийг санал болгож байгаа аж ахуйн нэгж байгууллагууд дээр очно гэсэн үг.

Тэгэхээр олон улсынхаа нийтлэг жишгээр одоогийн барьцаа, баталгаанд

тавигдаж байгаа тэр мөнгөн хөрөнгөөс доод тал нь 20-40 дахин байх боломжтой гэж харж байгаа юм. 20-40 дахин. Тэгэхээр магадгүй 100 сая төгрөг та барьцаа, баталгааны банкных тавьж байсан бол магадгүй 5-10 сая төгрөгөөр даатгалын хураамж төлөөд үлдсэн 90-95 сая төгрөгөө үйл ажиллагаанд зарцуулах ч гэдэг юм уу, бусад юу гэдэг юм, байдлаар ашиглах боломж, бололцоо бүрдэнэ л гэсэн үг.

Тэгэхээр ерөөсөө л хямд сонголтыг хувийн хэвшлийнхэнд, аж ахуйн нэгж байгууллагуудад санал болгож байгаа ийм шинэ төрлийн үйлчилгээ, бүтээгдэхүүн байгаад байгаа юм. Тэгэхээр энэ бол нэг талдаа олон улсад нийтлэгээрээ байдаг л зүйлийг бид нар сүүлийн 20, 30 жилийн хугацаанд анзааргагүй явж ирж, хууль, эрх зүйн орчныхоо хүрээнд нээгээгүй явснаараа өнөөдөр үндсэндээ нийт Монголын санхүүгийн зах зээлийн 83 хувийг банкны салбарынхан эзэлж байна. Үүнээс болоод банкнаас санал болгож байгаа ажил үйлчилгээ, санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүн болгон өртөг нь өндөр байгаад байна. Монополчилсон байдлаар байна. Энийг бид нар төрөлжүүлэх ёстой, задлах ёстой. Санхүүгийн зах зээлийг илүү эрүүл болгох энэ тогтолцоо бол энэний хүрээнд бий болно. Өрсөлдөөн бий болно гэж харж байгаа юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Санал хураалтаа явуулна. Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал

хураалт. 25 гишүүн дэмжиж, 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тооцон анхны хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Маргааш 10 цагаас.

18.03 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ
ХЯНАСАН:*

ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

